



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,  
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН  
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,  
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН  
ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**№63**

УЛААНБААТАР  
2025



**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА, АСУУЛТ, ТҮҮНИЙ ХАРИУГ  
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ**

**(Монгол Улсын Их Хурлын 2024 оны намрын ээлжит чуулган)  
/2024.10.01 - 2025.01.24/**

**№63**

Улаанбаатар хот  
2025 он

|    |   |    |
|----|---|----|
| 1  | Улсын Их Хурлын гишүүний <b>асуулга, асуулт</b> , түүний хариуг хэлэлцэх журам  | 3  |
| 2  | Улсын Их Хурлын 2024 оны анхдугаар чуулганы завсарлагаа, 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулга, түүний хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн талаарх статистик мэдээ                                      | 8  |
| 3  | Улсын Их Хурлын 2024 оны анхдугаар чуулганы завсарлагаа, 2024 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Улсын Их Хурлын гишүүдээс тавьсан асуулт, түүний хариуг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцсэн талаарх статистик мэдээ                                       | 10 |
| 4  | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан “Асуулга тавих тухай” <b>АСУУЛГА-10</b>   | 13 |
| 5  | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан “Асуулга тавих тухай” АСУУЛГА-10-ын хариуг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл             | 16 |
| 7  | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас 2024 оны 8 дугаар сарын 05-ны өдөр Боловсролын сайд П.Наранбаярт хандсан “Асуулт тавих тухай” <b>АСУУЛТ-09</b>  | 24 |
| 8  | Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандсан “Асуулт тавих тухай” АСУУЛТ-09-ийн хариуг Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл                        | 28 |
| 9  | Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас 2024 оны 8 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд хандсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар” <b>АСУУЛТ-12</b>   | 44 |
| 10 | Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан “Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар” АСУУЛТ-12-ын хариуг Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцсэн мэдээлэл | 46 |

## УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ

Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуулга, түүний хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэх журмыг Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар тус тус зохицуулсан.

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

#### **8 дугаар зүйл. Гишүүний бүрэн эрх**

8.1. Гишүүн дараах бүрэн эрхтэй:

8.1.13. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын даргад асуулга, асуулт тавьж, хариуг хуульд заасан хугацаанд авах;

#### **37 дугаар зүйл. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх**

37.1. Улсын Их Хурлын хянан шалгах ажил нь Засгийн газрын хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах үйл ажиллагаа болон Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын хууль биелүүлэх үйл ажиллагаанд хяналт тавихад чиглэх бөгөөд Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

37.1.1. асуулт тавих;

37.1.2. асуулга тавих;

37.1.3. хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх;

37.1.4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;

37.1.5. төсвийн хяналт;

37.1.6. Улсын Их Хурлын хяналтын сонсгол хийх;

37.1.7. Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин наймдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.

37.2. Улсын Их Хурлаас хийх хяналт шалгалтыг Улсын Их Хурлын нэгдсэн удирдамжаар хэрэгжүүлэхээс бусдаар төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хяналт шалгалттай давхардуулахгүй хэрэгжүүлнэ.

37.3. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэх журмыг хуулиар тогтооно.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТУХАЙ**

*/Шинэчилсэн найруулга/*

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **ХОЁРДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АРГА ХЭРЭГСЭЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

#### **6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын арга хэрэгсэл**

6.1. Улсын Их Хурал хянан шалгах бүрэн эрхээ дараах арга хэрэгслээр хэрэгжүүлнэ:

- 6.1.1. асуулт тавих;
- 6.1.2. асуулга тавих;
- 6.1.3. хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх;
- 6.1.4. мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх;
- 6.1.5. төсвийн хяналт;
- 6.1.6. хяналтын сонсгол хийх;
- 6.1.7. хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах.

### **ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ**

#### **11 дүгээр зүйл. Асуулт тавих**

11.1. Гишүүн Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд тодорхой бодлогын асуудал, түүний санхүүжилт, төрийн санхүү, төрийн нийтийн өмч, хүний эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх асуудал болон Улсын Их Хурал бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын хуулиар тогтоосон чиг үүргээ хэрэгжүүлж байгаатай холбоотой мэдээлэл авахаар тухайн байгууллагын даргад бичгээр хандсаныг "асуулт" гэнэ. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8.1.16, 8.1.17-д заасан албан бичгээр авах мэдээлэл нь асуултад хамаарахгүй.

11.2. Асуултыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 14 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуултын хариуг хугацаа хожимдуулж ирүүлсэн, эсхүл ирүүлээгүй бол асуулт тавьсан гишүүн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналаа энэ хуулийн 57.10-т заасан Байнгын хороонд хүргүүлж болно.

11.3.Гишүүн асуултын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгааг авахаар хугацаатай албан бичиг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

11.4.Гишүүний асуултын хариуг холбогдох Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 114 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэнэ.

11.5.Асуулт тавьсан гишүүн тодорхой арга хэмжээ авах хүсэлтийг шийдвэрийн төслийн хамт холбогдох Байнгын хорооны даргад уламжилж болно.

11.6.Байнгын хороо гишүүнээс гаргасан хүсэлт, шийдвэрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

## **12 дугаар зүйл. Асуулга тавих**

12.1.Хууль тогтоомжийн биелэлтийг хэрхэн зохион байгуулж, ямар үр дүнд хүрсэн талаар тодруулах, хуульд заасан үйл ажиллагаа явуулахыг шаардаж гишүүнээс Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын Их Хурлаас бүрэлдэхүүн, удирдлагыг нь сонгож, томилдог байгууллагын даргад бичгээр хандсаныг "асуулга" гэнэ.

12.2.Асуулгыг хүргүүлснээс хойш холбогдох албан тушаалтан 30 хоногийн дотор хариуг гишүүнд бичгээр хүргүүлнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр асуулгын хариуг хугацаа хожимдуулж ирүүлсэн, эсхүл ирүүлээгүй бол асуулга тавьсан гишүүн холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах саналаа энэ хуулийн 57.10-т заасан Байнгын хороонд хүргүүлж болно.

12.3.Гишүүн асуулгын хариуд ирүүлсэн холбогдох байгууллага, албан тушаалтны мэдээлэл шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт мэдээлэл, тооцоо, судалгаа авахаар хугацаатай албан бичгийг явуулна. Холбогдох албан тушаалтан албан бичигт заасан хугацаанд нэмэлт мэдээллийг ирүүлэх үүрэгтэй.

12.4.Гишүүний асуулгын хариуг холбогдох Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 113 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

12.5.Нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 12.4-т заасны дагуу гишүүний асуулгын хариуг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргахыг дэмжсэн тохиолдолд холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгч болно.

12.6.Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль тогтоомжийн төсөл болон холбогдох санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

12.7.Гишүүний асуулт, асуулга, түүний хариуг мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ**

*/Шинэчилсэн найруулга/*

2024 оны 05 сарын 16 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

### **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ХАРИУГ СОНСОХ**

#### **113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх**

113.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

113.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух;

113.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух.

113.2.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

113.3.Гишүүний асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд дараах журмыг баримтална:

113.3.1.Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов, дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан тогтоох;

113.3.2.асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд тухайн асуудлыг хариуцан хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хурлын даргад урьдчилан мэдэгдэх;

113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

113.3.4.асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн нэг удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх.

113.4.Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.

113.5.Гишүүний тавьсан асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед ижил сэдвийн хүрээнд тавигдсан бусад асуулгын хариуг нэгтгэн хэлэлцүүлж болно.

113.6.Нэгдсэн хуралдаан асуулгын хариуг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгнө.

113.7.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 113.6-д зааснаар нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, тогтоолын төсөл боловсруулж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна.

#### **114 дүгээр зүйл.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх**

114.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

114.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

114.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух.

114.2.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

---o0o---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГАА, 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛГА, ТҮҮНИЙ ХАРИУГ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

| № | Улсын Их Хурлын гишүүний нэр | Хандсан албан тушаалтан  | Асуулгын агуулга   | Хамрагдсан асуудлын тоо | Асуулга тавьсан огноо, дугаар | Хариу ирүүлсэн огноо   | Гишүүнээс санал ирүүлсэн огноо | Хэлэлцсэн огноо    | Асуулт, уг хэлсэн гишүүн, асуулт /тоогоор/ |            |
|---|------------------------------|--|--|-------------------------|-------------------------------|--|--------------------------------|--------------------|--|------------|
|   |                              |  |  |                         |                               |  |                                |                    | Гишүүн                                     | Асуулт, уг |
| 1 | О.Алтангэрэл                 | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ  | "Авлигатай тэмцэх таван үйл ажиллагаа"-ны талаар   | 2                       | 2024.07.16 №01                | Хууль зүй, дотоод хэргийн сайдаар томилогдсон учир асуулгын хариуг авах шаардлагагүй гэж үзсэн | -                              | -                  | -  | -          |
| 2 | О.Алтангэрэл                 | Авлигатай тэмцэх газрын дарга, тэргүүн комиссар З.Дашдаваа                       | Авлигын гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагааны талаар  | 3                       | 2024.07.16 №02                | 2024.08.15 №06/13039   | -                              | -                  | -  | -          |
| 3 | О.Алтангэрэл                 | Монгол Улсын Ерөнхий прокурор, төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Б.Жаргалсайхан | Монгол Улсын Ерөнхий аудитороос Эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн талаар | 3                       | 2024.07.16 №03                | 2024.08.16 №1/6062   | -                              | -                  | -  | -          |
| 4 | О.Алтангэрэл                 | Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн                                       | Төрийн албаны зөвлөлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар  | 5                       | 2024.07.16 №04                | 2024.08.14 №01/1749  | -                              | -                  | -  | -          |
| 5 | Э.Болормаа                   | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан   | Асуулга тавих тухай  | 11                      | 2024.07.30 №06                | 2024.08.22 №01/225   | -                              | -                  | -  | -          |
| 6 | О.Цотгэрэл                   | Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн   | Компаниудын дансыг битүүмжилж буй үйл ажиллагааны талаар   | 3                       | 2024.08.02 №07                | 2024.09.06 №А-1/680  | -                              | -                  | -  | -          |
| 7 | О.Цотгэрэл                   | Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл                                      | Компаниудын дансыг битүүмжилж буй үйл ажиллагааны талаар   | 3                       | 2024.08.02 №08                | 2024.09.04 №01/635   | -                              | -                  | -  | -          |
| 8 | Ц.Мөнхтуяа                   | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ  | Асуулга тавих тухай  | 13                      | 2024.08.12 №10                | 2024.09.04 №ХЭГ/1619   | 2024.10.21 УИХ-03/4400         | БСШУСБХ 2024.10.29 | 2  | 6          |

|    |              |  |   |   |                   |                         |   |   |   |
|----|--------------|--|---|---|-------------------|-------------------------|---|---|---|
| 9  | З.Мэндсайхан | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд<br>Ц.Туваан                  | Халзан бүрэгтэй төслийн талаар асуулга тавих  | 8 | 2024.08.28<br>№13 | 2024.10.24<br>01/802    | - | - | - |
| 10 | Ж.Баярмаа    | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Төсвийн зөрчлийн шалтгаан нөхцөл, хяналт, хариуцлагын механизм хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаар | 9 | 2024.09.25<br>№19 | 2024.10.17<br>№ХЭГ/1999 | - | - | - |
| 11 | Ц.Мөнхтуяа   | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 326 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар                               | 8 | 2024.10.21<br>№21 | 2024.11.15<br>№ХЭГ/2243 | - | - | - |
| 12 | Г.Очирбат    | Сангийн сайд<br>Б.Жавхлан                                    | Тогтоолын хэрэгжилтийн талаар асуулга тавих тухай   | 1 | 2024.11.01<br>№23 | 2024.11.25<br>№01/9732  | - | - | - |
| 13 | Г.Очирбат    | Монголбанкны Ерөнхийлөгч<br>Б.Лхагвасүрэн                    | Тогтоолын хэрэгжилтийн талаар асуулга тавих тухай   | 1 | 2024.11.01<br>№24 | 2024.12.04<br>№А-1/911  | - | - | - |
| 14 | Г.Очирбат    | Санхүүгийн зохицуулах хорооны дарга<br>Д.Баярсайхан          | Тогтоолын хэрэгжилтийн талаар асуулга тавих тухай   | 1 | 2024.11.01<br>№25 | 2024.11.28<br>1/3900    | - | - | - |
| 15 | О.Цогтгэрэл  | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Төрийн өмчит компанийн талаар асуулга тавьж, мэдээлэл авах тухай  | 7 | 2024.11.06<br>№30 | 2024.12.09<br>№ХЭГ/2457 | - | - | - |
| 16 | О.Цогтгэрэл  | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар   | 8 | 2024.11.06<br>№31 | 2024.12.09<br>№ХЭГ/2458 | - | - | - |
| 17 | О.Цогтгэрэл  | Монгол Улсын Ерөнхий аудитор<br>Д.Загджав                    | Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийн талаар   | 2 | 2024.11.06<br>№32 | 2024.11.15<br>№2185     | - | - | - |
| 18 | Д.Энхтүвшин  | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд<br>Л.Энх-Амгалан | Гадаад ажилчдын ажлын байрны төлбөрийг хөнгөлөх, чөлөөлөх талаар  | 3 | 2024.11.06<br>№33 | 2024.11.29<br>№01/1434  | - | - | - |
| 19 | Б.Энхбаяр    | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар   | 1 | 2024.11.19<br>№35 | 2024.12.19<br>ХЭГ/2623  | - | - | - |
| 20 | Д.Энхтүвшин  | Монгол Улсын Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Улсын Их Хурлын тогтоолын хэрэгжилтийн талаар   | 4 | 2024.12.20<br>№45 | 2025.01.22<br>ХЭГ/219   | - | - | - |

--000--

**УЛСЫН ИХ ХУРЛЫН 2024 ОНЫ АНХДУГААР ЧУУЛГАНЫ ЗАВСАРЛАГАА, 2024 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ ХУГАЦААНД УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮДЭЭС ТАВЬСАН АСУУЛТ, ТҮҮНИЙ ХАРИУГ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ СТАТИСТИК МЭДЭЭ**

| № | Улсын Их Хурлын гишүүний нэр | Хандсан албан тушаалтан                              | Асуултын агуулга   | Хамрагдсан асуудлын тоо | Асуулт тавьсан огноо, дугаар | Хариу ирүүлсэн огноо   | Гишүүнээс санал ирүүлсэн огноо | Хэлэлцсэн огноо       | Асуулт, үг хэлсэн гишүүн, асуулт /тоогоор/ |            |
|---|------------------------------|--|--|-------------------------|------------------------------|------------------------|--------------------------------|-----------------------|--|------------|
|   |                              |  |  |                         |                              |                        |                                |                       | Гишүүн                                     | Асуулт, үг |
| 1 | О.Алтангэрэл                 | Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав               | Прокурорын байгууллагад Эрүүгийн хэрэг үүсгүүлэн шалгуулахаар холбогдох мэдээлэл, баримт бичгийг шилжүүлсэн талаар | 1                       | 2024.07.16<br>№05            | 2024.07.23<br>1640     | -                              | -                     | -  | -          |
| 2 | Ц.Мөнхтуяа                   | Боловсролын сайд П.Наранбаяр                         | Асуулт тавих тухай   | 20                      | 2024.08.05<br>№09            | 2024.08.16<br>№1а/480  | 2024.10.14<br>УИХ-03/4040      | 2024.10.15            | 5  | 7          |
| 3 | Ц.Мөнхтуяа                   | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ              | Боловсролын салбарын багш, ажилтны цалин хөлс, нийгмийн баталгааны талаар  | 4                       | 2024.08.16<br>№11            | 2024.09.04<br>ХЭГ/1620 | -                              | -                     | -  | -          |
| 4 | Л.Мөнхбаясгалан              | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ              | Газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар  | 11                      | 2024.08.20<br>№12            | 2024.09.05<br>ХЭГ/1628 | 2024.10.22<br>УИХ-03/4517      | 2024.10.30            | 8  | 19         |
| 5 | Ц.Мөнхтуяа                   | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ              | Боловсролын салбарын хамтын хэлэлцээрийн талаар  | 2                       | 2024.09.03<br>№14            | 2024.09.20<br>ХЭГ/1759 | -                              | -                     | -  | -          |
| 6 | Ц.Мөнхтуяа                   | Боловсролын сайд П.Наранбаяр                         | Боловсролын салбарын тоон мэдээллийн талаар  | 5                       | 2024.09.10<br>№15            | 2024.09.24<br>1/1161   | -                              | -                     | -  | -          |
| 7 | Ж.Баярмаа                    | Соёл, спорт, аялал жуучлал, залуучуудын сайд Ч.Номин | Соёлын төв, ариун цэврийн байгууламж, авто зогсоол бүхий отоглох цэгийг шинээр байгуулах тухай                     | 6                       | 2024.09.25<br>№16            | 2024.10.10<br>№3/673   | 2024.10.21<br>УИХ-03/4400      | БСШУСБХ<br>2024.10.29 | 2  | 6          |

|    |              |   |   |   |                |                     |   |   |   |
|----|--------------|---|---|---|----------------|---------------------|---|---|---|
| 8  | Ж.Баярмаа    | Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Загджав                      | Гадаадын зээл, тусламжийн эх үүсвэрээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд аудит хийсэн талаар      | 3 | 2024.09.25 №17 | 2024.10.10 №1983    | - | - | - |
| 9  | Ж.Баярмаа    | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ                     | Сумдын эмнэлэг, сургууль, цэцэрлэг, халуун усны газар, соёлын төв, иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн талаар | 7 | 2024.09.25 №18 | 2024.10.15 ХЭГ/1973 | - | - | - |
| 10 | Г.Ганбаатар  | Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ                     | Шинэ хилийн боомт нээх талаар   | 3 | 2024.10.01 №20 | 2024.10.17 ХЭГ/1998 | - | - | - |
| 11 | С.Ганбаатар  | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан                    | Геологи, хайгуулын салбарт баримтлах бодлого, төлөвлөлт, бүтцийн өөрчлөлт хийх талаар                       | 4 | 2024.10.21 №22 | 2025.01.15 01/118   | - | - | - |
| 12 | О.Номинчимэг | Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл                 | Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн хэрэгжилтийн талаар                                      | 1 | 2024.11.04 №26 | 2024.11.21 01/1893  | - | - | - |
| 13 | О.Номинчимэг | Эрүүл мэндийн сайд Т.Мөнхсайхан                             | Эрүүл мэндийг дэмжих сангийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар  | 1 | 2024.11.04 №27 | 2024.11.27 1а/4954  | - | - | - |
| 14 | О.Номинчимэг | Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл                 | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны биелэлтийн талаар   | 1 | 2024.11.06 №28 | 2024.11.21 01/1894  | - | - | - |
| 15 | О.Номинчимэг | Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн                      | Зээлийн хүүг бууруулах стратегийн хэрэгжилтийн талаар   | 3 | 2024.11.06 №29 | 2024.12.03 а1/903   | - | - | - |
| 16 | С.Эрдэнэболд | Хот байгуулалт, барилга, орон сууцнуулалтын сайд Ж.Батсуурь | Улаанбаатар хотын усны чанарын тухай  | 5 | 2024.11.11 №34 | 2024.11.22 01/1451  | - | - | - |
| 17 | Х.Ганхуяг    | Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан                    | Хуулийн биелэлттэй холбоотой мэдээлэл ирүүлэх тухай   | 2 | 2024.11.20 №36 | 2024.12.11 01/1293  | - | - | - |

|    |                 |   |  |   |                   |                        |   |            |      |
|----|-----------------|---|--|---|-------------------|------------------------|---|------------|------|
| 18 | Х.Ганхуяг       | Зам, тээврийн сайд<br>Б.Дэлгэрсайхан                            | Мэдээлэл ирүүлэх тухай   | 3 | 2024.11.20<br>№37 | 2025.01.06<br>01/49    | - | -          | -    |
| 19 | Ц.Мөнхтуяа      | Төрийн албаны<br>зөвлөлийн дарга<br>Л.Цэдэвсүрэн                | Боловсролын<br>хуулийн зарим<br>засалтын<br>хэрэгжилтийн талаар                                    | 3 | 2024.11.20<br>№38 | 2024.12.18<br>01/2561  | - | -          | -    |
| 20 | Ц.Мөнхтуяа      | Боловсролын сайд<br>П.Наранбаяр                                 | Боловсролын<br>хуулийн зарим<br>засалтын<br>хэрэгжилтийн талаар                                    | 4 | 2024.11.21<br>№39 | 2024.12.12<br>1/2678   | - | -          | -    |
| 21 | С.Эрдэнэболд    | Эрүүл мэндийн сайд<br>Т.Мөнхсайхан                              | Монгол хүний эрүүл мэндийн<br>тухай  | 9 | 2024.11.22<br>№40 | 2024.12.06<br>1a/5152  | - | -          | -    |
| 22 | Ц.Мөнхтуяа      | Боловсролын сайд<br>П.Наранбаяр                                 | Монгол Улсын Засгийн<br>газрын 2024.01.17-ны<br>өдрийн 25 дугаар тогтоолын<br>хэрэгжилтийн талаар  | 3 | 2024.11.25<br>№41 | 2024.12.23<br>1/2875   | - | -          | -    |
| 23 | Л.Мөнхбаясгалан | Монгол Улсын<br>Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Цагаан Уул - Өлзий боомтын<br>бүтээн байгуулалтын талаар   | 6 | 2024.11.27<br>№42 | 2024.12.18<br>ХЭГ/2601 | - | -          | -    |
| 24 | Л.Мөнхбаясгалан | Монгол Улсын<br>Ерөнхий сайд<br>Л.Оюун-Эрдэнэ                   | Зарим төрийн болон төрийн<br>өмчийн оролцоотой хуулийн<br>этгээд болон үйлдвэрийн<br>газрын талаар | 4 | 2024.11.27<br>№43 | 2025.01.07<br>ХЭГ/29   | - | -          | -    |
| 25 | Б.Бат-Эрдэнэ    | Монгол Улсын Шадар<br>сайд Т.Доржханд                           | Мэдээлэл ирүүлэх тухай   | 6 | 2024.11.27<br>№44 | 2024.12.18<br>ЗГ-3/458 | - | -          | -    |
| 26 | О.Батнайрамдал  | Боловсролын сайд<br>П.Наранбаяр                                 | Боловсролын зээлийн<br>сангийн үйл ажиллагааны<br>хэрэгжилтийн талаар                              | 8 | 2025.01.07<br>№01 | 2025.01.20<br>1/248    | - | 2025.03.26 | 8 22 |
| 27 | Б.Жаргалан      | Гэр бүл, хөдөлмөр,<br>нийгмийн хамгааллын<br>сайд Л.Энх-Амгалан | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр<br>эрхлэлтийг дэмжих талаар  | 3 | 2025.01.14<br>№02 | 2025.04.21<br>1/1277   | - | -          | -    |
| 28 | А.Ариунзаяа     | Хууль зүй, дотоод<br>хэргийн сайд<br>О.Алтангэрэл               | Шийдвэрийн хууль зүйн<br>үндэслэлийг хянуулах тухай  | 1 | 2025.01.22<br>№03 | 2025.02.04<br>1/682    | - | -          | -    |

--oOo--

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЯАГААС 2024 ОНЫ  
8 ДУГААР САРЫН 12-НЫ ӨДӨР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
Л.ОЮУН-ЭРДЭНЭД ХАНДСАН “АСУУЛГА ТАВИХ ТУХАЙ” АСУУЛГА-10**



2024 оны 07 дугаар сард Монгол Улсын Их Хурлаас Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын тухай хууль, Дээд боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг батлан гаргасан нь сайшаалтай. Дээрх хуулиуд шинээр батлагдсантай холбогдуулан тодорхой журмуудыг Засгийн газраас батлан гаргасан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд:

1.1.2023-2024 оны хичээлийн жилд хичээллэсэн Боловсролын ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт заасан багш мэргэжлийн сонгон бүлгийн болон түүнд суралцагсдын тоо, энэхүү журмаар дэмжлэг авч суралцсан суралцагсдын тоо, түүнээс хэд нь хэчнээн төгрөгийн дэмжлэг хүртсэн тухай мэдээг;

1.2.2023-2024 оны хичээлийн жилд бакалаврын сургалтын хөтөлбөрөөр хэдэн суралцагч дэмжлэгт хамрагдсан, түүнд зарцуулсан мөнгөн дэмжлэгийн дүнг;

1.3.2023-2024 оны хичээлийн жилд боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр хэдэн суралцагч нийт хэчнээн төгрөгийн дэмжлэг авсан тухай дүнг;

1.4.2023-2024 оны хичээлийн жилд Багшийн хөгжлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т заасан хэдэн суралцагч, нийт хэчнээн төгрөгийн дэмжлэг авсан тухай дүнг;

1.5.Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-д “төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн

боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батлах.” гэж заасан байдаг. 2023-2024 оны хичээлийн жилд энэ дэмжлэгийг хэчнээн багш, ажилтны хэдэн хүүхэд авч, нийтдээ хэдэн төгрөгийн дэмжлэгийг олгосон тухай дэлгэрэнгүй тайланг;

1.6.Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6-г хэрэгжүүлэхэд “15-аас дээш жил тасралтгүй ажилласан байх”, “тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр” гэсэн шалгуурын дагуу хэчнээн багш, ажилтны хүүхэд хасагдсан тухай мэдээг;

1.7.Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмын 2 дугаар зүйлийн 2.2.3-т “Боловсролын ерөнхий хуулийн 12.5, Дээд боловсролын тухай хуулийн 12.12-т заасны дагуу магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийг сонгосон байх” шаардлагын дагуу хэдэн багш, ажилтны хүүхэд дэмжлэг авч чадаагүй хохирсон талаарх мэдээг;

1.8.Цаашид боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан “15-аас дээш жил тасралтгүй ажилласан байх”, “тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр” суралцах, журмын 2.2.3-т заасан “магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх” гэсэн хэт явцуу, багш, ажилтнуудад дэмжлэг биш ялгаварлал үүсгэсэн энэхүү хатуу заалтуудыг хэрхэн уян хатан, хүртээмжтэй болгохоор ажиллаж байгаа тухай мэдээллийг;

1.9.Цаашид энэхүү журмыг “Багш, багш мэргэжлээр суралцагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх журам”, “Багш, ажилтны хүүхдийг төрийн өмчийн их, дээд сургуульд суралцахад дэмжлэг үзүүлэх” журам болгон салгаж болох эсэхийг;

1.10.Багш, багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмын 9 дүгээр зүйлийн 9.1-д “Энэхүү журмын хэрэгжилтэд Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавьж ажиллана.” гэж заасны дагуу хэрхэн хяналт тавьж ажиллаж байгаа талаарх тайлан мэдээллийг.

2.Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын хүрээнд:

2.1.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд 2024 оны улсын төсөвт хэчнээн төгрөг суулган олгож байгаа тухай мэдээллийг;

2.2.Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1-д “Гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна.” гэж заасан байдаг ч энэхүү журмын 2 дугаар зүйлийн 2.3.7-д “жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний нэг жил (12 сар) хүртэлх хугацаа”-г тасралтгүй ажилласан жилд хамааруулан тооцохоор зохицуулжээ. Нэгэнт хууль зөрчихгүй, харин ч хуулиар нээлттэй учраас жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөө авсан гурван жил (36 сар) хүртэлх хугацааг тасралтгүй ажилласан жилд хамааруулан тооцох боломжтой гэж үзэж байна. Энэ талаар Засгийн газар ямар байр суурьтай байгааг;

2.3.Боловсролын ерөнхий хууль батлагдах (2023 оны 07 дугаар сарын 07)-аас өмнө энэхүү асуулгын 2.2-т дурдагдсан харилцааг хэрхэн зохицуулж байсныг тус тус ирүүлнэ үү.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т заасан хугацаанд ирүүлэн хамтран ажиллана гэдэгт итгэж байна.

---oOo---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЯАГААС МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДСАН “АСУУЛГА ТАВИХ ТУХАЙ” АСУУЛГА-10-ЫН  
ХАРИУГ БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 29-НИЙ ӨДРИЙН  
ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 103, 104 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар тавьсан асуулгын хариуг хэлэлцлээ.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлогын зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын ахлах мэргэжилтэн Д.Отгонбаатар нар байлцав.

**Ч.Ундрам:** Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хуралдааныг эхлүүлье. Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудалтай холбоотой материалыг Та бүхэнд урьдчилж хүргүүлсэн байгаа. Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандсан асуулгын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулна.

**П.Наранбаяр:** Эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэд ирүүлсэн Засгийн газрын 2014 оны 103 болон 104 дүгээр тогтоолын хэрэгжилттэй холбоотой асуулгатай холбогдуулан бэлтгэсэн мэдээллийг Та бүхэнд танилцуулъя.

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоол батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл нийтдээ 1379 суралцагчид 2 тэрбум 367,6 сая төгрөгийн санхүүжилт олгож, 11 дүгээр сараас эхлэн 6288 суралцагчид 14 тэрбум 600 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөөд байна. Энэхүү тогтоолоор батлагдсан журамд 6 төрлийн шаардлага хангасан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилчдын хүүхдэд төрөөс дэмжлэг үзүүлэхээр заасан бөгөөд чиглэл тус бүрээр олгосон дэмжлэг санхүүжилтийн мэдээллийг хүргүүлье.

Нэгдүгээрт, тус журмын 2.1.1 дэх хэсэгт заасан, Боловсролын ерөнхий хуулийн 12.2-т заасан Ерөнхий боловсролын сургуулийн багш мэргэжлийн сонгон бүлгийн төгсөгч чиглэлээр 2024-2025 оны хичээлийн жилд суралцаж буй сурагч одоогоор байхгүй бөгөөд журмыг нь боловсруулж байгаа болно.

Хоёрдугаарт, журмын 2.1.2 дахь хэсэгт заасан багш бэлтгэх бакалаврын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцагч чиглэлээр 2024 оны 1-9 дүгээр саруудад 657 суралцагчид 1 тэрбум 146 сая төгрөгийн тэтгэлэг олгоод байна.

2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 4434 суралцагчид 9 тэрбум 48 сая 700 мянган төгрөгийг олгохоор тооцож байна. Мөн Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан журмын 2.11 дэх заалтын дагуу багш мэргэжлээр өндөр оноотой суралцагчийн тэтгэлэгт үргэлжлүүлэн суралцаж буй 1069 суралцагчдад 1,7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон.

Журмын 2.3.1.3-т заасан боловсролын чиглэлээр магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцах чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 19 суралцагчид 22,5 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 1062 суралцагчид 2 тэрбум 172 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон. Боловсролын 01 индексээр тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд хүргүүлсэн байгаа. Хүснэгтэд дурдсан мэдээллийг та бүхэн харах байх.

Дөрөвдүгээрт, Журмын 2.1.4, Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.3-т заасан хөдөө орон нутагт багш мэргэжлээр дадлагажигч чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 192 суралцагчид 154,7 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 265 суралцагчид 444,9 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон. Хөдөө орон нутагт багш мэргэжлийн дадлагажигчийн тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд хүснэгтэлж хүргүүлсэн байгаа.

Тавдугаарт, журмын 2.1.5, Боловсролын ерөнхий хуулийн 12.10-т заасан орон нутагт мэргэжлээрээ ажиллах багш чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 88 суралцагчид 155,4 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 736 суралцагчид 1 тэрбум 591 сая 900 мянган төгрөгийн санхүүжилтийг олгохоор тооцсон. Бакалаврын хөрвөх сургалтын хөтөлбөрөөр тэтгэлэгт хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн байгаа. Энэ задаргаатай нь та бүхэн танилцаарай.

Зургадугаарт, журмын 2.1.6, Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д заасан багш, ажилтны 1 хүүхэд чиглэлээр 2024 оны 10 дугаар сарын байдлаар 233 суралцагчид 552,8 сая төгрөг, 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 673 суралцагчид 2 тэрбум 692 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тооцсон.

Багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр суралцахад хамрагдах суралцагчдын тандалт судалгааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн байгаа. Боловсролын ерөнхий хуулийн 13.3.3 болон Засгийн газрын 2024 оны 104 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан журмын хэрэгжилтийн талаарх мэдээлэл.

Төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан хаагчид. Үүнд, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал, сургалтын менежер, сургуулийн нийгмийн ажилтан, дотуур байрны багш, албан бус боловсролын багш, цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн номын санч, эмч, хоол зүйч, тогооч, багш, багшийн туслах, сэтгэл зүйчид багтаж байгаа. Эхний 5 дахь жил болон дараагийн 3 дахь жил тутамд 1 удаа, 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг тооцон олгож байна. Тэтгэмжид хамрагдаж чадахгүй байгаа албан хаагчдын нийтлэг үндэслэлийг дурдвал:

1.Албан хаагч эхний 5 жил тасралтгүй ажилласан шаардлагыг хангаж тэтгэмж авсан ба дараагийн сар тасралтгүй ажилласан шаардлагыг хангахгүй, дундаа тасарсан байх тул журамд заасны дагуу зарим албан хаагч тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа.

2.Жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний 1 жил буюу 12 сар хүртэлх хугацааг тооцохоор журамд тусгасны дагуу тус шалгуураар зарим албан хаагч тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа. Тус журмын 2.1.1-2.1.3-т заасан багш, ажилтан, сургалтын байгууллага хооронд сэлгэн болон шилжиж ажилласан бол тухайн хугацааг нийгмийн даатгалын шимтгэл төлсөн лавлагаанд үндэслэн тасралтгүй ажилласанд тооцож, сүүлийн ажиллуулж байгаа байгууллага, албан тушаалын энэ журамд хамаарах нөхцөлөөр тэтгэмжийг тооцохоор журамласан байдаг. Зарим албан хаагч ижил түвшний сургалтын байгууллагад шилжин ажилласан боловч Боловсролын ерөнхий хуулийн 13.3.3-т заасан тэтгэмж авах албан тушаалд томилогдоогүй ба өөр албан тушаалд томилогдон ажиллаж байх тул тэтгэмж авах шаардлага хангахгүй хасагдаж байгаа. Үүний задаргааг та бүхэнд мөн хүснэгтэлж хүргүүлсэн. Энэ дээр ерөнхий боловсролын болон Сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг тус тус задалж харуулсан байгаа. Танилцуулж дууслаа. Баярлалаа.

**Ч.Ундрам:** П.Наранбаяр сайд аа, энэ хүснэгтэлж та бүхэнд харуулсан гэх тандалт судалгаанууд нь байхгүй байна. Ямар ч хүснэгт бид нарт ирээгүй учраас та шаардлагатай гэж үзэж байгаа гишүүдэд яаралтай хувилаад хүргүүлмээр байна.

Танилцуулга хийн дууссан учраас Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, ЗГХЭГ-ын Салбарын бодлого, зохицуулалтын газрын дарга Ш.Мөнхцэрэн нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү. Б.Хэрлэн гишүүнээр тасаллаа. Ц.Мөнхтуяа гишүүн асуулт асууя.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Монгол Улсын Их Хурлын гишүүний зүгээс Монгол Улсын Ерөнхий сайд Лувсаннамсрайн Оюун-Эрдэнэд 2024 оны 8 дугаар сарын 12-ны өдөр тавьсан асуулгын хариуг хэлэлцэхтэй холбогдуулан би товчхон бичээд ирсэн.

2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 103 дугаар тогтоолоор батлагдсан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг эрэлттэй, тэргүүлэх мэргэжлээр суралцахад төрөөс дэмжлэг үзүүлэх журмын тухай асуудал Боловсролын ерөнхий хуулийн 13.3.6-д “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, Политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны 1 хүүхдийг тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн их, дээд сургуульд үнэгүй сургана” гэж заасан.

Боловсролын яамнаас ирүүлсэн хариуг үзэхэд 2023-2024 оны хичээлийн жилд нийт 673 багш, ажилтан хүүхдийнхээ сургалтын төлбөрийг чөлөөлүүлэх хүсэлт өгсөн байна. Үүнээс 233 хүүхэд л тэтгэмжид хамрагдсан. 673-аас 233 шүү. Хуульд тусгагдсан эрэлттэй болон тэргүүлэх мэргэжлээр суралцах, 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан байх гэсэн шалгуур давалгүй хасагдсан 264 багш, ажилтан байна.

Журмын заалтаараа буюу магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрийг сонгосон байх гэсэн заалтаар 176 суралцагч энэ тэтгэмжээс чинь хасагдсан байна. Үндсэндээ 34 хувь нь тэнцээд, 66 хувь нь хасагдсан.

Үнэхээр харамсалтай тоо энд харагдаж байна л даа. Та нар нэг их өндөр, их олон тэрбум төгрөг тавьчихсан гээд л статистик мэдээ уншаад байдаг. Хачир дээрээ энэ хуулийн чинь энэ харгис, хатуу заалтаас болж ийм олон хүүхдүүд сургуульдаа сурч чадахгүй, хасагдаж байна шүү дээ. Энэ дээр хэдүүлээ “бүгдээрээ хэлэлцвэл буруугүй, бүлээн усаар угаавал хиргүй” гэдэг шиг ярилцах хэрэгтэй байна.

Энэ “эрэлттэй, тэргүүлэх, тасралтгүй 15” гэдэг үгийг энэ хуулиас хасах нэмэлт, өөрчлөлтийн төслийг би Ч.Ундрам, Д.Бум-Очир гишүүдтэй хамтраад санаачилна. Нэмэлт, өөрчлөлт оруулахаар ярьж байгаа.

Хоёрдугаарт, энэ тэтгэмжийг чинь 34-хөн хувь нь л авсан байна. Боловсролын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6 дахь заалтыг анх хуулийн төсөл боловсруулах явцад Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос санаачилга, саналыг анх оруулж байсан юм. Манай холбооныхон ярьж байгаад. /минут дуусав/.

**Ч.Ундрам:** Дэгийн хуулиараа асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байгаа. Ц.Мөнхтуяа гишүүн асуулга тавьсан гишүүн учраас хамгийн сүүлд үг хэлж болно. Б.Хэрлэн гишүүн асуулт асууна.

**Б.Хэрлэн:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Надад 2 асуулт байна.

Нэгдүгээрт, сая хөнгөлөлт эдэлж чадаагүй хүмүүсийн тодорхой хувь нь магадлан итгэмжлэгдээгүй сургуульд сурч байгаа учраас хөнгөлөлт эдлээгүй хасагдсан гэж энэ өгсөн хариу дотор бичсэн байна л даа. “Цаашид өмнөх жилд багш, ажилтны хүүхдүүд элссэн, эсвэл элсэн сурч буй магадлан итгэмжлэгдээгүй хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллана” гэсэн ийм тайлбар өгсөн байна. Тэгэхээр энэ нь нэг хэсэг хүмүүст хөнгөлөлт эдлүүлэхийн тулд тухайн хөтөлбөрийг нь магадлан итгэмжлэх хэрэгтэй болоод байна гэсэн үг үү? Нэг хэсэг хүмүүсийн хэрэгцээнд зориулан, тэр хүмүүст хөнгөлөлт эдлүүлэхийн тулд тухайн сургалтын хөтөлбөрийн агуулга, сургалтын орчин нь ямар байхаас үл хамааран магадлан итгэмжилье гэсэн бодлогыг Боловсролын яамнаас баримтлаад байна гэсэн үг үү? Өөрөөр хэлбэл, боловсролын чанарын тухай асуудалд энэ хэр нийцэж байгааг асуумаар байна.

Хоёрдугаарт, багш мэргэжлээр сурч байгаа, багш мэргэжлээр төрөөс тодорхой хэмжээний тэтгэмж, тэтгэлэг аваад бакалавр, магистрын сургалтад сурч байгаа олон хүн байгаа. Тэгэхээр энэ тайлбартай холбоогүйгээр би нэг зүйлийг асууя. Багшийн мэргэжлээр төрөөс сургалтынхаа төлбөрийг даалгаад сурч байгаа хүмүүсийг цаашид төрдөө яг ажил, мэргэжлээр нь ажиллуулах тухайд танай яамнаас ямар бодлого баримталж байгаа вэ? Багш мэргэжлээр ажиллаж байгаа хүмүүсийн хүүхдүүдийг бас сургах юм байна. Сургасныхаа дараа тэд нарыг тухайн эзэмшсэн мэргэжлээрээ хөдөлмөрийн зах зээл дээр ажил хөдөлмөр эрхлээд явах, хариуцлага хүлээж ажиллах талаас нь ямар бодлого баримтлах вэ?

**Ч.Ундрам:** Эхлээд Ц.Мөнхтуяа гишүүний асуултад П.Наранбаяр сайд хариулья.

**П.Наранбаяр:** Тэгэхээр 673 хүүхдийн асуудал яригдсан. 233 буюу 34 хувь нь аваад бусад нь аваагүй нь бодитой тоо. Журмын үндэслэл хэсгийн “15 жил тасралтгүй ажилласан” гэдэг дээр унасан хүмүүс бий. Үнэхээрийн харамсалтай. Яах аргагүй хуулийн заалтаараа хасагдсан байгаа. Хуульд өөрчлөлт орвол, багшаар ажиллаж байгаа бол хэрэгжээд явах бүрэн боломжтой гэж харж байгаа. Нөгөө талаар эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийн чиглэл гээд заачихаар өөр чиглэлээр сурч байгаа гэдгээр хассан тохиолдол бий. 9 дүгээр сард энэ асуудал бас яригдаж, магадлан итгэмжлэгдэж амжаагүй байна гэсэн асуудал үүссэн учраас бид өөрсдийнхөө хүрээнд магадлан итгэмжлэлийг хурдан гарга гэж шахаж байгаа. Энэ магадлан итгэмжлэл нь дандаа эрэлттэй, тэргүүлэх чиглэлүүд дээр байгаа. Яг энэ үндэслэлээр хасагдсан хүн байхгүй. Энэ үндэслэлээр эрэлттэй, тэргүүлэх чиглэл мөн байгаад магадлан итгэмжлэлд хараахан амжаагүй, эсвэл магадлан итгэмжлэх ажил нь явцын дундаа байгаа ийм мэргэжлүүд рүү явсан хүүхдүүдийн өргөдлийг бүгдийг нь хүлээн авч, цохолтын аргаар шийдсэн. Тэгэхээр аль аль талдаа ажлаа уялдуулах шаардлага байгааг бид харж байгаа.

Б.Хэрлэн гишүүний асуултад хамт хариулж болох уу?

Б.Хэрлэн гишүүний хэлээд байгаа нь үнэн. Эрэлттэй, тэргүүлэх мэргэжил учраас ер нь магадлан итгэмжлэх учиртай гэсэн бодлого барьж байгаа. Харин тэтгэлэг авч сурчхаад яг багшаар нь ажиллуулах асуудлыг хэрхэн шийдвэрлэж байна вэ гэдгийг журмаараа шийдчихсэн байгаа. Зарим хэсэг нь яг орон нутагтаа багшлах багш нар байгаа. Ийм үндэслэлээр авч байгаа тэтгэлгүүд байгаа. Энэ Гэрээнийхээ, журмынхаа дагуу л явна. Урьд нь бас гашуун туршлага бий. 2013 оноос билүү эхэлсэн 800 оноо дөхүүлж авсан, 700-гаас дээш оноо авсан хүүхдүүдийг МУБИС дээр 70-100 хувийн тэтгэлэгтэй бэлдчихээд, тэдний 40-хөн хувь нь багш болж, 60 хувь нь яваад өгчихсөн. Тэгэхээр бид энэ сургамжаа судлаад, яг л багшилж байж олгосон боловсролын тэтгэлэг буцалтгүй болно гэдгийг журамдаа тусгасан. Зарим нь бүр орон нутагтаа очиж багшлахыг нөхцөл болгосон байгаа. Энэ нь манай 6.2.3 дээр байгаа. /минут дуусав./

**Ч.Ундрам:** Хоёр хүний асуултад хариулж байгаа учраас П.Наранбаяр сайдад дахиад 3 минут өгье.

**П.Наранбаяр:** Цаашдаа бид ер нь ямар бодлого барих вэ гэвэл эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийг аль болохоор эртхэн тогтоож, хүмүүст эртхэн зарлахгүй бол гэнэт гэнэт өөрчлөгдөөд, нийгмийн амьдрал өөрөө хурдтай яваад байгаа учраас. Ноднин жил гэхэд энэ чинь эрэлттэй мэргэжилд орчихсон гэсэн гомдол их ирсэн нь төр талаас мэдээллээ хүргэхэд анхаараагүй бидний алдаа гэж харж байгаа. Тийм учраас бид эрэлттэй, тэргүүлэх мэргэжлийг тогтоох чиглэлээр Төрийн албаны зөвлөлтэй хамтарсан яриа хэлцэл явуулж байна. Саяын энэ журмын холбогдох заалтыг нь уншаад өгье. 6.2.3-т “багш бэлтгэх бакалавр, магистрын сургалтын үндсэн хөтөлбөрөөр суралцаж төгсөөд, төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагад орон нутагт гурваас доошгүй жил, эсвэл нийслэлд 5-аас доошгүй жил тогтвортой ажиллах” гэж заасан байгаа. Гэрээ байгуулах энэ заалтын нэг хэсэг нь болоод орчихсон учраас цаашдаа багш нар тэтгэлгээ авч сурчхаад, буцалтгүй болгох боломжтой болж байгаа. Эрэлттэй, тэргүүлэх мэргэжлүүдийг эртхэн зарладаг болох, тухайн эзэмшсэн мэргэжлээрээ яг ажиллаж байгаа эсэх асуудлаар судалгаа хийхэд их, дээд сургуулиудын эрэмбийг тогтоох, үнэлгээний нэг чухал үзүүлэлт болж байгаа.

Түүнээс гадна Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад дундын платформ хийж байна. Үүгээр бэлтгэгдсэн боловсон хүчин хөдөлмөрийн зах зээл дээр уялдаж байгаа эсэхийг харах юм. Б.Энх-Амгалан сайд, Боловсролын сайд миний бие болон хамтарсан ажлын хэсэг энэ 12 дугаар сарын сүүлээр дуусгахаар ажиллаж байна. Энэ нь Засгийн газрын 100 хоногийн төлөвлөгөөнд туссан ажил юм. Баярлалаа.

**Ч.Ундрам:** Хариулт дууссан уу. Бид нар өмнөх парламентад Боловсролын багц хуулийг шинэчлэхдээ “Багш нарын нийгмийн баталгаа” гэсэн дэд бүлгийг Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтраад, ярилцаад энэ бүлгийг шинээр Боловсролын хуульд оруулсныг та бүхэн мэдэж байгаа. Үүний гол зорилго нь багш нараа бид нар тогтоон барих, нийгмийн баталгааг нь ядаж энэ хүрээнд ч гэсэн хангах ийм зорилгоор энэ заалтуудыг оруулж ирсэн байгаа.

Тэгэхээр энэ заалтыг оруулсан ч гэсэн хүсэлт өгсөн хүмүүсийн 34 хувь нь л авч чадсан гэдэг чинь маш бага хувь хэмжээ гэдэг дээр бүгдээрээ санал нийлж байгаа гэж бодож байна. Тийм учраас Ц.Мөнхтуяа гишүүн санаачлаад, бид дэмжээд энэ хатуу заалтуудыг арай зөөлрүүлж өгье. Багш нараасаа судалгаа аваад, боломжийг нь нээж өгье. Яагаад гэвэл гол зорилгоо бүрэн биелүүлж чадахгүй байна гэж үзэж байгаа учраас хуулийн төсөл санаачлах бэлтгэл ажилдаа ороод явж байгаа. Энэ хугацаанд яамнаас тэргүүлэх мэргэжлүүдээ эртхэн зарлаж, аль болохоор уян хатан хандаж ажиллаж байгаад баяртай байна.

Б.Хэрлэн гишүүн бас чухал асуулт асуулаа. Эргээд тэтгэлэг авсан хүүхдүүд маань ажлын байртай байх ёстой. Нэгэнт төрөөс, татвар төлөгчдийн мөнгөнөөс тэтгэлэг авч байгаа болохоор эргээд төрдөө ажиллах, ялангуяа багш мэргэжлээр сурч байгаа хүүхдүүд багшлах, орон нутагтаа багшлах гэсэн үүрэгтэй байх ёстой. Тэгэхээр орон нутагт ажиллуулах нөхцөлийг гэрээнд нь тавьж байгаа гэж ойлголоо.

Ингээд дэгийн тухай хуулийн 113.1.2-т холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд асуулгатай холбоотой үг хэлэх гэж заасны дагуу Ц.Мөнхтуяа гишүүнд 5 минут өгье.

**Ц.Мөнхтуяа:** Баярлалаа. Сая Ч.Ундрэм гишүүний хэлсэнчлэн манай Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбооноос энэ заалтыг санаачилж Боловсролын ерөнхий хуульд оруулж байсан юм. Энэ заалт хатуу болсон учраас бид ярилцаад нэр бүхий гишүүдээс шинэ хуулийн төсөл санаачилна гээд сая Ч.Ундрэм гишүүн хэлчихлээ.

Магадлан итгэмжлэлийн асуудлыг бас ярьлаа. Магадлан итгэмжлүүлэх нь өөрөө сургуулийнх нь асуудал байдаг байх, тийм үү? Сургуулийнхаа сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлээгүйгээс болж хасагдана гэдэг бол эмгэнэлтэй шүү дээ. Энэ хүүхэд, эцэг, эхийн буруу биш учраас энэ асуудал дээр П.Наранбаяр сайд сайн анхаарч ажиллаарай гэж хэлье.

Ч.Ундрэм гишүүнтэй санал нэг байна. Манай багш нар 15 жилээс “тасралтгүй” гэдэг үгийг л хасъя гээд байгаа юм. Хүний амьдралд өвчтэй, зовлонтой, амьдрал ахуйгаа, банкны өр зээлээ дарахаар Солонгос 3 сар яваад ирэхэд л тэтгэлэгтээ хамрагдаж чадахгүй болох учраас багш нараас ирсэн гомдол, саналыг оруулж байгаа юм шүү. Тэгэхээр “эрэлттэй, тэргүүлэх мэргэжил, тасралтгүй” гэдгийг хасвал багшийн хомсдолоос бага ч гэсэн гарах боломжтой гэж Ч.Ундрэм гишүүн хэлж байна. Жишээ нь, 10 жил ажиллаад Солонгос гарчихсан хүн буцаж ирээд 5 жил ажиллаад энэ тэтгэмжид хамрагдах жишээтэй. Улсын зардлаар сураад 40 хувь нь ажилласан гэж сая П.Наранбаяр сайд хэллээ. Энэ чинь залуучууд цалингаа голоод л багшийн мэргэжлээс дайжаад байгаа гол шалтгаан байхгүй юу. Ажиллахгүй байгаадаа биш, ерөөсөө л цалин хөлс, нийгмийн баталгаа нь хангалтгүй байгаа учраас залуу багш нар энэ ажлыг хийхгүй, төгсчхөөд хаяад явж байна. Энэ дээр л төр засаг онцгой анхаараач гэж 7, 8 жил ярьж байна.

Хоёрдугаарт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, ажилтанд мөнгөн тэтгэмж олгох журам”-ын хүрээнд ганц л заалт асуудал, гомдол дагуулаад байгаа юм. Тэр нь журмын 2 дугаар зүйлийн 2.3.7-д “жирэмсний болон амаржсаны амралттай, хүүхдээ асрах чөлөөтэй байсан эхний нэг жил (12 сар) хүртэлх хугацаа”-г тасралтгүй ажилласанд тооцно гээд байгаа юм. П.Наранбаяр сайд аа, энэ заалт өмнө нь 6 сар байж байгаад бөөн хэл ам дагуулаад Л.Энх-Амгалан сайдын үед 12 сар болсон. Энэ 12 сарыг 24 болгох боломжийг хэдүүлээ хайя. Бид дандаа болохгүй, бүтэхгүй, хуульд ингэж заасан гэж ярьдгаа болимоор байна. Хүн рүүгээ чиглэсэн, хүндээ ээлтэй хуулийн заалтууд оруулж ирэхгүй бол хахир хатуу, хүндээ ээлгүй ийм хуулиа дагаж мөрдөнө гээд чичрээд суугаад байж болохгүй гэж бодож байна. Энэ 12 сарыг 24 сар болгож өөрчилмөөр байна. Яагаад гэвэл Хөдөлмөрийн тухай хуулийн 139 дүгээр зүйлийн 139.1-д “3 хүртэлх насны хүүхэдтэй эх, эцэг өөрөө хүсэлт гаргасан бол ажил олгогч түүнд хүүхэд асрах чөлөө олгох бөгөөд энэ хугацаанд тэтгэмж олгох асуудлыг холбогдох хууль тогтоомж, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр, хөдөлмөрийн гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээгээр зохицуулна” гээд заачихсан байгаа. Тэгэхээр үүнийг 24 сар болгох боломж Засгийн газарт байгаа гэдгийг П.Наранбаяр сайдад бас дуулгая. Хэдүүлээ дандаа болохгүй гэдэг үгээ жоохон өөрчилъе. Манай энэ парламентын бараг 81 нь шинэ гишүүн байгаа гэж би сонссон. Тэгэхээр шинээр харж, сэтгэж байгаа шинэ гишүүддээ би уриалмаар байна. Хуучин нь ч гэсэн 2, 3 сонгогдсон сайн ажилладаг гишүүд байгаа. Манай Ч.Ундрам гишүүн боловсрол дээр нэлээн дуу хоолой болоод явж байгаа мундаг эмэгтэй. Энэ дээр нэлээн хүч өгч, анхаарал хандуулаарай гэдгийг боловсролын асуудал хариуцсан Байнгын хорооны даргын хувьд хэлмээр байна.

**Ч.Ундрам:** Асуулт асууж, хариулт авч дууслаа. Цаашид Боловсролын яам Улсын Их Хурлын гишүүдийн сая асуусан асуулт, хэлж байгаа үгийг маш сайн анхаарч, цаашдынхаа ажилд тусгаад, аль болохоор уян хатан явах хэрэгтэй байх. Бид нарын хамгийн том салбарын асуудал бол ерөөсөө багшийн хомсдол байгаа. Тэгэхээр багш нартаа аль болохоор хамгийн ээлтэй ажиллах орчныг бий болгож, нийгмийн баталгааг нь хангах тал дээр анхаарах ёстой. Чадахаасаа чадахгүйгээ хүртэл зүтгэх ёстой гэж бодож байгаа. Ингээд хэлэлцэх асуудал дууссан учраас өнөөдрийн хуралдааныг хаалаа.

---oOo---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЯАГААС 2024 ОНЫ  
8 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДӨР БОЛОВСРОЛЫН САЙД П.НАРАНБАЯРТ  
ХАНДСАН “АСУУЛТ ТАВИХ ТУХАЙ” АСУУЛТ-09**



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн, 2024-2025 оны хичээлийн жил эхлэх гэж байгаатай холбогдуулан, Улсын Их Хурлын гишүүний зүгээс боловсролын салбарын багш, ажилтнуудтай хийсэн уулзалтын үеэр гарсан санал, хүсэлтийн дагуу Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

**1.Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн А/01 тушаалаар батлагдсан хичээлийн жилийн бүтцийн талаар:**

1.1.2023-2024 оны хичээлийн жилийн бүтэц 4 улиралтай байсныг 3 улиралтай болгох шийдвэр гаргажээ. Энэхүү бүтцээс харахад хичээлийн жилийн 1-р улирал 1-2-р ангид 16, 3-9-р ангид 17, 10-12-р ангид 18 долоо хоног байхаар тооцсон нь суралцагчид залхах, багш, сурагчгүй ядрах, хичээллэх хүсэл сонирхол буурдгийг өмнөх жилүүдийн туршлага харуулсаар байтал энэхүү шийдвэрийг гаргах болсон үндэслэл, шалтгааныг тайлбарлана уу?

1.2.Хичээлийн жилийн 1-р улирлын дундуур буюу 9 дэх долоо хоногт Бие даалтын үйл ажиллагааг тавьснаар ямар үр дүн гарна гэж тооцоолж байгаа вэ? Энэ хугацаанд 1-р улирлын амралтыг зохион байгуулж, хичээлийн жилээ 4 улиралтай байхаар тооцоолж болоогүй юм уу? Бие даалтын үйл ажиллагаа нь Боловсролын ерөнхий хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасан сургалтын хэлбэрийн аль хэсэгт хамаарах вэ?

1.3.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсэгт “Холбогдох хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.” гэж заасан байхад хууль зөрчин, 1-р улирлын 18 дахь долоо хоногт ахлах ангийн сургалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна гэсний шалтгаан юу вэ?

1.4.2025 оны билгийн тооллын цагаан сарын шинийн нэгэн 3 дугаар сарын 01-ний өдрийн бямба гарагт тохиож байгаа. Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь хэсэгт зааснаар цагаан сарын шинийн 1, 2, 3-ны өдрүүд нийтээр тэмдэглэх баярын өдөр тул амарна. Иймд ёс уламжлал, нөхцөл байдлаа тооцоод 1 долоо хоногийн амралт зохион байгуулах боломж бий юу?

1.5.VI-XII ангийн суралцагчдын хичээлийн жилийн үргэлжлэх хугацааг 36, 37 долоо хоног байгааг 35 болгон, 6 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хичээлийн жилийг дуусгах арга хэмжээ авч болох эсэх.

## **2.Багшийн мэргэжлийн зэрэг олгох журам шинэчлэгдэн гарахгүй байгаа талаар:**

Мэргэжлийн зэрэг олгох, хасах тухай 2018 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/812 тоот тушаал 2023 оны 10-р сарын 06-ны өдөр хүчингүй болсон ч харгалзах журмыг одоо болтол гаргаагүй байна.

2.1.Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг хэзээ шинэчлэн гаргах вэ?

2.2.Өмнөх журам хүчингүй болсноос хойш шинэчлэгдэн гарах хүртэлх хугацаанд мэргэжлийн зэргээ шинээр авч, эсвэл сунгаж чадаагүй багш нарын хохирлыг хэрхэн барагдуулах вэ?

## **3.Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ээлжийн амралтыг хуваан эдлүүлэх чиглэлийн талаар:**

Боловсролын сайдын зүгээс 2024 оны 7 дугаар сарын 23-ны өдөр Боловсролын ерөнхий газрын даргад хүргүүлсэн 2/72 тоот чиглэлийн хүрээнд 2025 оны багш, ажилтны ээлжийн амралтын 48 хоногийн 5-ыг нь 2025 оны 1 дүгээр сарын эхний долоо хоногт эдлүүлэх зохицуулалт хийхийг үүрэгжүүлсэн байх бөгөөд энэ хүрээнд дараах асуултууд урган гарч байна.

3.1.Боловсролын сайдын шууд үүрэгжүүлсэн чиглэлээр багш, ажилтны ээлжийн амралтыг ингэж хэсэгчлэн хуваахад Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-д заасан “Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно. Хэсэгчлэн амрах ээлжийн амралтын аль нэг тасралтгүй амралтын үргэлжлэх хугацаа нь ажлын 10 өдрөөс доошгүй байна.” гэсэн заалт зөрчигдөх үү?

3.2.Чиглэлд дурдагдсан ээлжийн амралтын эхний 5 хоногийг хэсэгчлэн эдлэх 2025 оны 1 дүгээр сарын эхний долоо хоног нь хуулиараа ажлын өдрүүд байгаа. Хэрвээ энэ өдрүүдэд ээлжийн амралтаа хэсэгчлэн эдэлсэн тохиолдолд ажилласнаар тооцож цалингаа олгох уу, эсхүл ээлжийн амралт эдэлснээр тооцож ээлжийн амралтын цалин олгох уу? Зуны амралтаар эдлэх үлдсэн 43 хоногийн амралтын цалин 48 хоногоор бодогдох уу? Багш, ажилтнуудад ямар ашигтай хийгээд хохиролтой нөхцөл байдал үүсэж болох вэ? Гаргасан тооцоо, судалгаа байна уу?

3.3.Багш, ажилтны ээлжийн амралтыг хувааж эдлүүлэх талаар багш, ажилтнуудаас саналыг нь авсан уу? Авсан бол ямар дүгнэлт гарсан бэ?

3.4.2024-2025 оны хичээлийн жил дуусах хугацааг 6 дугаар сарын дунд хүртэл тооцохоор багш, ажилтны ээлжийн амралтыг хувааж, тэдний эрх ашгийг

зөрчих нөхцөл үүсэж байгааг ойлгож байна уу? Асуултын 1 дэх хэсэг болон энэ хэсгийн нөхцөл байдлыг тооцоолоод хичээлийн жилийн бүтцээ эргэн харж, уян хатан зохицуулалт хийж болохгүй байгаа юм уу?

**4.2024-2025 оны хичээлийн жилд үүсэж буй багш, ажилтны хомсдолын талаар:**

Боловсролын сайд болон Боловсролын яамны зүгээс гаргаж байгаа мэдээллээр энэ хичээлийн жилд 4200 орчим багшийн дутагдалтай байна.

4.1.Боловсролын яамны зүгээс аль сургууль, цэцэрлэг, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагуудад ямар мэргэжлийн хэдэн багш, ажилтан дутагдалтай байгаа талаарх дэлгэрэнгүй судалгаа байна уу?

4.2.Дутагдалтай багш, ажилтныг нөхөх талаар ямар арга хэмжээнүүд төлөвлөн ажиллаж байна вэ?

4.3.Сүүлийн 4 жилийн (2020-2021, 2021-2022, 2022-2023, 2023-2024 оны хичээлийн жилүүд) дутагдалтай байсан багш, ажилтны тоо, тэдгээрийг хэрхэн нөхөж ирсэн талаар дэлгэрэнгүй судалгаа байна уу? Байгаа бол бичгээр явуулна уу.

**5.Боловсролын сайдын 2024 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын талаар:**

5.1.Боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргасан эсэх, дүгнэлтийг ирүүлнэ үү.

5.2.Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтыг ирүүлнэ үү.

5.3.Боловсролын сайдын 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн А/06 тоот тушаалын хавсралтаар байгуулагдсан ажлын хэсгийн гүйцэтгэх ажлын удирдамж, төлөвлөгөө гарсан уу? Гарсан бол ирүүлнэ үү.

**6.Багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах мэдээллийн талаар:**

Боловсролын сайдын удаа дараагийн мэдэгдлүүдэд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг сэлгэн ажиллуулах талаар хоорондоо зөрүүтэй, салбарын багш, ажилтныг маш их бухимдуулсан асуудлууд гарсан.

6.1.Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах хууль, эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэж байгаа юу?

6.2.Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах үндэслэл, шаардлага, гарах үр дүнг тайлбарлана уу?

6.3.Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах тохиолдолд тэдний нийгмийн хамгааллын асуудлыг өмнөх түвшнээс нь дордуулахгүй байх ямар зохицуулалтыг хийсэн бэ?

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

---oO---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ц.МӨНХТУЯАГААС БОЛОВСРОЛЫН САЙДАД  
ХАНДСАН “АСУУЛТ ТАВИХ ТУХАЙ” АСУУЛТ-09-ИЙН ХАРИУГ  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДРИЙН ХУРАЛДААНААР  
ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг хэлэлцэв. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Б.Батцэцэг, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Дээд боловсролын газрын дарга Ж.Ариунболд, Боловсролын зээлийн сангийн дарга О.Сийлэгмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Хяналт шалгалтын газрын референт Х.Хэрлэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүнээс тавьсан асуултын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулав. Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Эрдэнэбат, Д.Бум-Очир, Ц.Мөнхтуяа, Г.Дамдинням нарын тавьсан асуултад Боловсролын сайд П.Наранбаяр хариулж, тайлбар хийв.

**Г.Дамдинням:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхтуяагаас Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг Боловсролын сайд П.Наранбаяр танилцуулна. П.Наранбаяр сайдын микрофоныг өгье.

**П.Наранбаяр:** Ц.Мөнхтуяа гишүүнээс ирүүлсэн асуултаудын дагуу эхний хариуг 2024 оны 8 дугаар сарын 16-ны өдөр, 9 дүгээр сарын 10-нд ирүүлсэн асуулгад 9 дүгээр сарын 26-ны өдөр хариу өгсөн. Мөн холбогдох бусад байгууллагуудад хандсан асуулгад нь хариу өгсөн. Нийт өгсөн хариу нь нэлээд хэмжээний бичиг баримтууд болчихсон байгаа. Ц.Мөнхтуяа гишүүний яриад байгаа цалин хөлс, хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэхийг дэмжиж байгаа. Үнэхээрийн чадварлаг боловсон хүчнийг боловсролын салбарт оруулж ирэх шаардлагатай байгаа нь үнэн. Үүний тулд цалин хөлсний бодлого нь өөрөө дэлхийн жишиг рүү ойртох ёстой. Энэ асуудлыг бид Үйлдвэрчний эвлэлийн хороотой ярьж хамтын хэлэлцээрийг 2026 он хүртэл 3 жилийн хугацаанд байгуулсан байгаа. Энэ жил цалингийн өсөлтийг инфляцын түвшинтэй уялдуулаад төрийн албан хаагчдын цалинг 6 хувиар өсгөхөөр төсвийн төсөлд тусгагдсан байгаа. Монголын Үйлдвэрчний эвлэлийн харьяа Боловсрол, шинжлэх ухааны Үйлдвэрчний эвлэлийнхэнтэй өмнөх сайдын үед байгуулсан хамтын хэлэлцээрийн заалтуудыг харахад 30 хувь гэсэн амлалт бий. Доор хаяж 30 хувь, энэ амлалтдаа 2026 ондоо хүргэж чадна гэж харж байгаа. Явуулж байгаа үйл ажиллагаа, тэнд хүлээсэн үүргүүд ямар хувьтай байгаа талаарх мэдээллийг манай яамнаас Ц.Мөнхтуяа гишүүнд албан бичгээр хүргүүлсэн. Цалин хөлсний асуудал дээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Засгийн газар дотроо голлох яамны хувьд бодлогоо зангидаж байгаа. Бид цалин хөлсний бодлого дээр төлөвлөгөө боловсруулаад яаманд хүргүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газар энэ удаад 14 мега том төсөл гэж оруулж ирээд, санхүүжилтийг нь шийдээд, эхний 5 төсөл нь л хэрэгжиж эхлэхэд манай эдийн засгийн өсөлт ямар хэмжээнд хүрэх, нийт иргэдэд оногдох GDP буюу ДНБ-ий өсөлт ямар байх тухайд Сангийн яам болон холбогдох сайд нар олонтоо танилцуулсан учраас би давтан хэлэхгүй. Эдийн засгийн өсөлт яг цалин хэлбэрээр төрийн албан хаагчдад, нэн ялангуяа багш нарт хүрч байх ёстой. Үүнийг бүрэн хүлээн зөвшөөрнө. Бид цалингийн дундаж хэмжээг өнөөдөр мөрдөгдөж байгаа төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээлэлд үндэслээд үзэхэд сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын багш, арга зүйчийн дундаж цалин 2 сая 698 мянган төгрөгт хүрээд байгаа. Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын багш, сургалтын менежер... /микрофон хаав./

**Г.Дамдинням:** П.Наранбаяр сайд аа, уучлаарай. Улсын Их Хурлын гишүүний асуулт болон асуулгад хариулахдаа дарааллын дагуу нэг, хоёрт гээд хариулбал гишүүдэд ойлгомжтой байна. Яагаад гэвэл өнөөдөр 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр, одоо тараагдсан нэмэлт мэдээлэл 2024 оны 10 дугаар сарын 14-ний өдөр буюу өчигдөр ирсэн байж таараад байна. Тиймээс ойлгомжтой байх, мөн дэгийн зарчмаа бариад явъя, болох уу, П.Наранбаяр сайд аа.

**П.Наранбаяр:** Ойлголоо. Тэгэхээр 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэцтэй холбоотой 4 улиралтай байсныг 3 улиралтай болгох шийдвэрээ тайлбарлаарай гэсэн. 18 долоо хоног байхаар суралцагч залхах, багш, сурагчгүй ядрах, хичээллэх хүсэл, сонирхол буурдгийг өмнөх жилийн туршлага харуулсаар байтал энэхүү шийдвэрийг гаргасан үндэслэл шалтгааныг тайлбарлана уу гэсэн асуулт ирүүлсэн.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т “ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ” гэсэн хуулийн заалтын дагуу 34-өөс 37 долоо хоног хичээллэхээр баталсан байгаа. Энэ хугацаанд нийцүүлэн ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жилийн бүтцийг:

- 1-ээс 2 дугаар ангид 34,
- 3-аас 4 дүгээр ангид 35,
- 6-аас 9 дүгээр ангид 36,
- 10-аас 12 дугаар ангид 37 хоног байхаар нийцүүлж гаргасан.

4-өөс 6 долоо хоногийн амралтыг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудад өвлийн ид хүйтрэлт буюу томуу, томуу төст өвчний дэгдэлт ихэсдэг 12 дугаар сарын сүүлээс 01 дүгээр сарын дунд үеийг дуустал 3-5 долоо хоног, хаврын амралтыг 1 долоо хоног байхаар зохицуулсан. Харин аймаг, сумын ерөнхий боловсролын сургуулийн өвлийн амралт 2-4 долоо хоног, хаврын

амралтыг мал төллөх хугацаатай уялдуулан 2 долоо хоног байхаар тус тус төлөвлөсөн. Энэ болохоор хэт хүйтрэлт, агаарын бохирдол, томуу, томуу төст халдварт өвчний тархалтын нөхцөл байдлыг харгалзаж амралтын хугацаанд хот, хөдөөгийн хувьд ялгаатай тавьсан. Гэхдээ 10 дугаар сарын сүүлээр, мөн 3 дугаар сард “бие даалтын долоо хоног” гэж оруулж ирсэн, үүнийг сургуулиуд өөрсдөө шийднэ. Энэ хугацаанд эрүүл мэндийн үзлэгт хүүхдүүдийг бүрэн хамруулах, гамшгийн сургалтыг хийх, музей үзүүлэх зэрэг ажлуудыг зохион байгуулах юм. 1 дүгээр улирал нь 16-18 долоо хоног үргэлжилж байгаа хэдий ч хичээлийн жилийн 9 дүгээр долоо хоногт зохион байгуулах бие даалтын ажлыг оруулсан.

2 дугаар асуулт, хичээлийн жилийн нэгдүгээр улирлын дундуур буюу 9 дэх долоо хоногт бие даалтын үйл ажиллагааг оруулснаар ямар үр дүн гарна гэж тооцоолж байна вэ?. Нэгдүгээр улирлын амралтыг зохион байгуулж, хичээлийн жилээ 4 улиралтай байхаар тооцоолж болоогүй юм уу? гэсэн асуулт байна. Тэгээд бас танхим, цахимын хэлбэрээр зохион байгуулна гэсэн шалтгаан нь юу вэ гэсэн асуулт. Түүний дараа 9 дүгээр сарын.../минут дуусав/

**Г.Дамдинням:** П.Наранбаяр сайдад дахин 5 минут өгье.

**П.Наранбаяр:** Энэ нэлээн том асуултууд учраас маш товчхон ярья.

Бие даалтын цаг оруулж ирсэн нь хувь хүний хөгжил, бүтээлч сэтгэлгээ, зөөлөн ур чадвар, үүнийг мэдрэхүйн ур чадвар ч гэж ярьдаг үүнийг хөгжүүлэхэд чиглэсэн төрөл бүрийн үйл ажиллагааг эцэг эх, асран хамгаалагчдын хамтын ажиллагаанд тулгуурлан зохион байгуулахаар байгаа юм. Гамшгийн сургалтыг 3 дугаар сард хийхээр Монгол Улсын Шадар сайдтай ярилцаж байгаа.

Аюулгүй амьдрах ухаан гэсэн аятайхан хөтөлбөр байдаг. Гэвч энэ хэрэгжихгүй байгаа учраас гамшгийн сургалтыг 3 дугаар сард бие даалтын долоо хоногоор явуулна. Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.6-д сургалтын цахим систем хөгжүүлэх, гамшгийн улмаас танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг зогсоосон тохиолдолд сургалтын тасралтгүй бэлэн байдлыг хангахыг боловсролын сургалтын байгууллагын удирдлагын чиг үүрэгт заасан. Тиймээс цахим хичээлийг оруулж байгаа. Ер нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд заасан хичээлийн жил эхлэх, дуусах, үргэлжлэх хугацаа болон энэхүү тайлбар бичгийн 1.1-д дурдсан өвлийн улирлын амралтыг байгаль цаг уур, орон нутгийн онцлогт тохируулан нийцүүлсэн зохицуулалтаас хамааран холбогдох хуульд заасан нийтээр амрах амралтын өдрүүдээр нэмж ямар нэгэн амралт зохион байгуулах боломжгүй. Ер нь 4 улирлаар явахаар маш их карантин зарлагддаг. Амьдрал дээр Та бүхэн харж байгаа. Энэ нь хүүхдүүд хичээл завсардах, долоо хоногт ховор ордог зарим хичээлүүд бүр орхигдох урхагтай байдаг учраас ингэж зохион байгуулж байгаа гэдгийг Та бүхэн ойлгоорой.

6-12 дугаар ангийн суралцагчдын хичээлийн жилийн үргэлжлэх хугацаа 36, 37 долоо хоног байгааг 35 болгон 6 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хичээлийн жилийг дуусгах талаар арга хэмжээ авах эсэх талаар асуусан байна.

Энэ бол 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл буюу 170-аас 185 хоног хичээллэх хуулийн заалттай учраас дунд, ахлах ангийн хичээллэх долоо хоногийг 35 болгох, 6 дугаар сарын эхний долоо хоногт хичээлийн жилийг дуусгах боломжгүй байна.

Багшийн мэргэжлийн зэрэг олгох журмыг хэзээ шинэчлэх талаар.

Журам гарсан, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд мэргэжлийн зэрэг олгох журам бүртгэгдсэн байгаа. Тиймээс багш нарт мэргэжлийн зэрэг олгох ажил эхэлчихсэн. Үүнийг бид эрх ашиг нь хөндөгдөх улсуудаас хууль, журамд заасны дагуу саналыг нь авсан гэдгээ таньд хэлье.

Ерөнхий боловсролын сургуулийн багш, ажилтны ээлжийн амралтыг хуваан эдлүүлэх чиглэлийн тухайд.

Хөдөлмөрийн тухай хуулийн 99 дүгээр зүйлийн 99.8-д заасан “Ажилтан өөрийн хүсэлтээр ээлжийн амралтыг тухайн ажлын жилдээ багтаан хэсэгчлэн эдэлж болно.” гэсэн заалтыг ашиглаж байгаа. Хөдөлмөрийн тухай хууль болон Боловсролын ерөнхий хуульд зааснаар “ажлын 48 өдөр байна” гэдгийг бид огт хөндөөгүй. Ээлжийн амралтын нэгдүгээр хэсгийн үргэлжлэх хугацаа 5, хоёр дахь хэсгийн тасралтгүй үргэлжлэх хугацаа 43 ажлын өдөр байх нь Хөдөлмөрийн хуульдаа нийцэж байгаа юм. Ингэснээрээ бид нэгдүгээр сарын эхний долоо хоногт ямар нэгэн байдлаар сургууль дээр багш нарыг цуглуулах, элдэв сургалт хийхгүй гэсэн ийм чиглэл өгсөн байгаа. Тэгэхээр багш нар бүрэн амрах боломжтой юм шүү. Харин зуны 45 хоног нь 43 болсноороо арай наана буюу 8 дугаар сарын дундуур, сүүлээр ажилдаа орж ирээд хичээлийнхээ жилийн бэлтгэлийг хангах боломжтой гэдгийг хэлье.

2024-2025 оны хичээлийн жилд үүсэж буй багш, ажилтны хомсдолын талаар.

Засгийн газрын хуралдааны дараа 6 багц арга хэмжээг олон нийтэд дэлгэрэнгүй зарласан. 2024-2025 оны хичээлийн жилд дутагдалтай байгаа тоог би зарлаж, ярьж ирсэн учраас энд ярихгүй. Дутагдалтай багш, ажилтныг нөхөх талаар ямар арга хэмжээ авах вэ гэсэн асуултад миний зүгээс Засгийн газрын хуралдааны дараа хариулсан учраас энэ дээр товчилж өгье.

Боловсролын “Цөм” хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар дүгнэлт гаргасан эсэх тухайд Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалыг.../ минут дуусав./

**Г.Дамдинням:** Дахин 5 минут өгье.

**П.Наранбаяр:** Уучлаарай, “Цөм” хөтөлбөрийн хэрэгжилтийн тухайд “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” батлагдсаны дагуу сургуулийн өмнөх боловсрол, бага боловсролын үндэсний хөтөлбөр, түүний зэрэгцээ сурах бичгүүдийг шинэчлэх ажлын

хэсэг байгуулагдсан. Энд дандаа мэргэжлийн улсууд оролцсон. Судалгааны 2 ч тайлан гарсан байгаа. Монгол Улсын ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг “**боловсруулах**”, “**хэрэгжүүлэх**”, “**үнэлэх**” үйл явцын тайлан, түүнд нөлөөлж буй хүчин зүйл гэсэн ийм тайлангууд байгаа. Чадамжийн шинжилгээг бүрэн хийсэн. Үүнийг асуулгын хариуд бүрэн тусгасан учраас товчлоод явчихъя. Суурь боловсролын тухайд 19 хичээлийн сургалтын хөтөлбөрийн зорилго, зорилт, агуулга, арга зүйн үнэлгээ, шинжилгээ хийж үзэхэд:

- 22 хувь нь “бүтээлч сэтгэлгээ”;
- 21 хувь нь “нийгэмшил, сэтгэл хөдлөл”;
- 24 хувь нь “хүний хөгжил”;
- 14 хувь нь “мэдээллийн технологийн хэрэглээ”;
- 19 хувь нь “Монгол болон дэлхийн иргэний чадвар”-т туссан.

Эндээс үзэхэд хувь хүний хөгжлийг дэмжсэн чадварууд өндөр хувьтай харагдаж байгаа бол мэдээллийн технологийн хэрэглээ, Монгол болон дэлхийн иргэний чадварын хувь нэлээн бага байгаа. Үүнийг энэ удаагийн үндэсний хөтөлбөрт нэмэгдүүлэхээр орж байгаа. Бүрэн дунд боловсролын тухайд энэ агуулгууд нь бүрэн туссан. Танд хүргүүлсэн хариунд бүх нарийвчилсан мэдээлэл нь байгаа учраас товчилъё.

Боловсролын салбарын багш, ажилтнуудыг сэлгэн ажиллуулах хууль, эрх зүйн орчин бүрдсэн байна уу? гэсэн асуултын тухайд.

Хөдөлмөрийн тухай хуулийн 59.1-д “ажил олгогч ажилтантай харилцан тохиролцсоны үндсэн дээр аж ахуйн нэгж, байгууллага дотроо харьяа нэгж салбарын хооронд дараах үндэслэлээр ажилтныг 3 жил хүртэл хугацаагаар сэлгэн ажиллуулж болно.” гэсэн заалт байдаг. Боловсролын ерөнхий хуулийн 12.14-т “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцон тухайн аймаг, сум, дүүрэг, баг, тосгоны боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.” гэсэн ийм заалттай. “Шилжүүлэн ажиллах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн заалтын дагуу боловсруулсан. Үндэслэл, шаардлага, гарах үр дүнг асуусан байна. Шилжүүлэн ажиллуулахын тухайд.

2023-2024 оны хичээлийн жилийн статистик мэдээгээр улсын хэмжээнд нийт 1410 цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байгаа ба эдгээрт нийтдээ 1360 эрхлэгч ажиллаж байгаагаас 27 хувь нь тухайн албан тушаалдаа 11-ээс дээш жил ажилласан туршлагатай хүмүүс байна. Тэгэхээр үндсэн багш нарын 21 хувь нь багшаараа 11-ээс дээш жил ажилласан.

2024 оны 8 дугаар сарын мэдээгээр ерөнхий боловсролын 871 сургуулиас 157 сургуулийн (нийслэлийн 41, орон нутгийн 116 сургуулийн) захирал тухайн албан тушаалдаа 10-аас дээш жил ажилласан туршлагатай байна. Эдгээр ажилтнуудын сайн туршлагыг түгээхийн тулд тухайн дүүрэг, аймгийн төв дотор нь сэлгэн ажиллуулж байгаа.

Журмын төсөлд тусгахдаа “багш, ажилтныг шилжүүлэн ажиллуулах тохиолдолд цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлийг дордуулахгүй, хүлээх үүрэг, хариуцлага зэргийг харилцан тохиролцож гэрээ байгуулахаар, байгууллагын бүтэц, зохион байгуулалт өөрчлөгдсөн, томилох эрх бүхий албан тушаалтан солигдсон нь шилжүүлэн ажиллуулах шийдвэрийг хугацаанаас нь өмнө цуцлах, шилжүүлэн ажиллах хугацаа дууссан багш, удирдах ажилтныг урьд эрхэлж байсан ажил, албан тушаалд нь үргэлжлүүлэн ажиллуулахаас татгалзах үндэслэл болохгүй байх” гэсэн зүйлүүдийг оруулснаараа тухайн багшийг хамгаалж байгаа юм. Энэ хариултыг Та бүхэнд өгсөн.

9 дүгээр сарын 10-ны өдөр ирүүлсэн 2023-2024 оны хичээлийн жилийн бүтэцтэй холбоотой нэмэлт мэдээллийг танд хүргүүлсэн. Мөн ээлжийн амралттай холбоотой мэдээллийг танилцуулгатай нь хүргүүлсэн учраас би товчхон мэдээлэл хийлээ. Баярлалаа.

**Г.Дамдинням:** Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Ц.Мөнхтуяа гишүүнээр тасаллаа. Одоо С.Эрдэнэбат гишүүн асуултаа асууя.

**С.Эрдэнэбат:** Гишүүний хүргүүлсэн асуултад нэлээн чухал асуудлууд байгаа. Энэ талаар саяхан багш нарын баярыг тохиолдуулаад “хичээлийн амралт”, “сэлгэн ажиллуулах”, “багшийн дутагдлыг нөхөх”, “цалин хөлсний асуудал” гэх мэтчилэн олон багц асуудлаар саналаа Боловсролын яаманд хүргүүлээд, зарим саналуудыг авсан. Зарим шийдвэрүүдийг гаргахад ажиллаж байгаа багш, ажилчид, Үйлдвэрчний эвлэлүүдээс урьдчилан санал авах нь бидний анзаараагүй маш их зүйлийг хэлж өгдөг. П.Наранбаяр сайдын хувьд яг ямар ямар асуудал эцэслэн шийдсэн бэ?

Тэр зөвлөгөөн дээр яригдсан нэлээн олон асуудлыг бид тохирсон гэж ойлгож байгаа. Боловсролын яамныхан маань бүгдээрээ байсан. Бага, СӨБ, их, дээд боловсролын гээд. Тэгэхээр энэ асуудлуудтай холбоотойгоор ойрын хугацаанд ямар шийдвэрүүд гарах вэ?

Процессын хувьд шинэ дэгийн хуулиар гишүүд асуулт, асуулга тавьсан тохиолдолд 10 хоногийн дотор хэлэлцэнэ. Тэгэхээр тухайн асуудлаар бүх гишүүд сайд нарт асуулт тавиад, тэр болгоныг нь 10 хоногийн дотор хэлэлцээд байх нь хэр оновчтой байх вэ? Хэлэлцэх эсэх асуудлыг Байнгын хорооны гишүүдийн саналыг харгалзан шийддэг байвал зүгээр юм уу гэж бодож байна. Сайд гишүүд хоорондоо ярилцаад боломжтой асуудлыг тэндээ шийдээд явчих нь зүйтэй. Ер нь Байнгын хорооны гишүүд энгийн ярилцах байдлаар ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол, хүүхдийн хоол зэрэг асуудлаар яамныхантайгаа уулзаад нэг мөр шийдчихвэл надад ч гэсэн маш олон асуулт байна. Тэгэхээр энэ тал дээр ойрын хугацаанд хийж тодорхой арга хэмжээ авч өгөөч гэдэг хүсэлт байна.

**Г.Дамдинням:** Боловсролын сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Асуултад хариулъя. Хоёр дахь асуулт Байнгын хорооны даргаас асуусан гэж ойлголоо. Энэ дээр өөрийнхөө байр суурийг хэлэхэд

уг нь таны хэлээд байгаа их зүйтэй. Асуулга тавьсан гишүүнтэйгээ уулзаад ярилцахад би хэзээд нээлттэй, уулзахад бэлэн байна. Монголын боловсрол, шинжлэх ухааны Үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэлтэй бид байнга холбогдон ярилцаж, саналуудыг авч байгаа. Манай яамны холбогдох дарга нар уг зөвлөгөөнд оролцож, нэлээн сайн ярилцаж байгаа. Үнэхээр сайн ярилцаад ирэхээр гаргаж байгаа журмууд ч чамбайрч байгаа нь харагдаж байна. Захиргааны хэм хэмжээ тогтоож байгаа ерөнхий хуулийн дагуу журмын төслүүдийг яамны цахим хуудсанд байршуулан олон нийтээс санал авдаг. Мөн холбогдох байгууллагууд руу албан бичгээр хүргүүлж санал авдаг. Энэ процессоо бид цаашид ч сайн мөрдөж явна. Ер нь бүгдээрээ хэлэлцвэл буруугүй гэж ярьдаг, хуулиар заасан хүрээнд нь хандана гэдгээ хэлье. Баярлалаа.

**Г.Дамдинням:** Д.Бум-Очир гишүүн асуултаа асууя.

**Д.Бум-Очир:** Багш нарын цалингийн хэмжээг та дунджаар гэж танилцуулсан. Таныг танилцуулах биш илүү тодруулаад өгөөч ээ гэж хүсэж байна. Татварын өмнө үү, хойно уу гээд. Үүнтэй уялдаад нэлээд их санал, гомдол гарсныг та бүхэн сонссон байх. Сошиалаар ялангуяа, багш нар ийм их цалин авдаг, авдаггүй гэдэг маргаан гараад байна. Таны танилцуулж байгаа энэ тоо баримт хаанаас гаргасан тоо баримт юм. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам юм уу, Боловсролын яам юм уу? Хаанаас гаргасан тоо юм бэ?

Хоёрт, ер нь сонсоход их өндөр сонсогдож байгаа. Хүмүүс, ялангуяа багш нар итгэхгүй байдалд хүрээд байх шиг байна. Ийм их цалин бид авдаггүй шүү дээ гэсэн санал, гомдол нэлээд харагдаж байна. Мэдээж төрийн сайд хүний хийж байгаа мэдээлэл хариуцлагатай байгаа болов уу гэж ойлгож байна. Түүнээс санаанаасаа тоо хэлэхгүй байх. Бодоход орон нутагт, ялангуяа суманд 40 хувь, аймагт 20 хувийн нэмэгдэл өгч байгаа. Энэ нэмэгдэл ороод ингэж өндөр сонсогдож байна уу? Нэмэгдэл гарахаас өмнө өнгөрсөн хавар миний авч байсан мэдээлэлтэй зөрөөд, байгаа юм л даа.

Цалингийн хэмжээ өндөр сонсогдохоос гадна би тоог нь буруу хэлж байж магадгүй шүү, 17 мянган багш 2 сая 500 мянгаас дээш гэж байсан уу, гэх мэтчилэн мэдээллүүд байгаа. 17 мянган багш гэдэг чинь их олон шүү дээ. Бидэнд ямар мэдээлэл байгаа вэ гэвэл бүх нэмэгдлүүдээ авч байгаа цөөхөн тооны багш өндөр цалинтай байгаа. Дийлэнх багш нар, ялангуяа залуу багш нар цалин нь нэлээд бага. Ер нь багш нар их залуужиж байгаа шүү дээ. Өнгөрсөн хаврын мэдээллээр гар дээр нь 1 сая 200, 300-аас илүү ирэхгүй байгаа гэсэн мэдээлэл байсан. Би багш нартай уулзаад гар дээр чинь яг дунджаар хэд ирж байна гэхэд 1,0-1,2 сая гэж байсан санагдаад байгаа. Багш нар ч гэсэн үүнийгээ яриад байна. Тэгэхээр цалингийн мэдээлэл дээр тодруулга хийж өгөхгүй юу?

**Г.Дамдинням:** П.Наранбаяр сайд хариулъя.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Д.Бум-Очир гишүүний асуултад хариулъя. Та бүхэнд хэлсэн мэдээлэл бол Төрийн албаны цалингийн нэгдсэн системийн мэдээллээс авсан. Цалингийн тоо нь татварын өмнөх шүү. Багш нарын үндсэн

цалин 2023 оны Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор тогтоосноор 1 сая 273 мянга байна. Ерөнхий боловсролын сургуулийнх 1.3 сая байсан нь сая Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор 1.4 сая. Сургуулийн өмнөх боловсролын багш нар 1.47 буюу 1 сая 471 мянга болж өөрчлөгдсөн.

“Цалингийн нэмэгдэл”, “нэмэгдэл хөлс” гэж тусдаа байдаг. “Цалингийн нэмэгдэл” гэдэг нь “мэргэжлийн зэрэг” юм. Үүнд:

- “Заах аргач” 10 хувь;
- “Тэргүүлэх” 15 хувь;
- “Зөвлөх” 20 хувь;
- “Докторын зэрэг” 20 хувь.

“Орон нутгийн нэмэгдэл” гэдэгт:

- аймгийн төвд 20 хувь, сумын төвд 40 хувь;
- “Ур чадварын нэмэгдэл” 5 - 25 хувь;
- “Төрийн алба хаасны нэмэгдэл” ажилласан жил тутам 1 хувиар нэмэгдэнэ.

Цэцэрлэгийн багшийн хувьд заах аргын нэгдэл удирдсан 5 хувь байдаг. “Нэмэгдэл хөлс” дээр би ахиад ярья. Сургуулийн багш:

- анги даасны 10 хувь;
- заах аргын нэгдэл удирдсан 5 хувь;
- кабинет, лаборатори хариуцсан 5 хувь;
- илүү цаг заавал 1.5-аар тооцож олгодог. Бусад нэмэлт чиг үүргийн гээд.

“Гүйцэтгэл”, “үр дүнгийн урамшуулал” гэж бас бий. Энэ дээр 6 индексээр үнэлж байгаа. 2024 онд 1 дүгээр индексээр нийт багш нараас үнэлэгдсэн багшийн тоо 2346, 2 дугаар индексээр 6324 гэх мэт ийм тоонууд байгаа. 1 дүгээр индексээр үнэлэгдвэл цалингийн шууд 40 хувийн урамшууллыг авч байгаа.

- 1 дүгээр индекс 40;
- 2 дугаар индекс 25;
- 3 дугаар индекс 20;
- 4 дүгээр индекс 15;
- 5, 6 дугаар индекс урамшуулал авахгүй.

Багшийн үйл ажиллагааг дэмжих бусад зардал дээр:

- нөхөн хангалтын зардал;
- хичээл практикийн зардал;
- мэдээлэл технологийн зардал;
- багшийн хөгжлийг дэмжих зардал;
- эрүүл мэндийг дэмжих зардал.

Багш нарын 2024 оны 5 дугаар сарын цалингийн мэдээллийг “гүйцэтгэл”, “үр дүнгийн урамшуулал” ороогүй дүнгээр ярихад:

- ур чадварыг 9,911 багш;
- анги даалт дээр 21,448 багш;
- орон нутгийн 26,164 багш;
- мэргэжлийн зэрэг дээр 26,658 багш;
- алба хаасны хугацаан дээр 38,600 багш авсан байна. /минут дуусав/

**Г.Дамдинням:** П.Наранбаяр сайдад 1 минут өгье.

**П.Наранбаяр:** 2024 оны 5 дугаар сард олговол зохих цалингийн мэдээллийг харахад:

- 1.2-оос 1.5 сая төгрөгийн цалин авсан 734 багш;
- 1.5-аас 1.7 сая төгрөгийн цалин авсан 2,381 багш;
- 1.7-гоос 2 сая хүртэл 4,599 багш;
- 2-оос 2.5 сая төгрөгийн цалин авсан 15,651 багш;
- 2.5-аас дээш 17,221 багш;
- 3.5 саяас дээш цалин авсан 3,041 багш гээд байгаа юм.

Би дахиад хэлье. Энэ татварын өмнөх шүү. Мөн бодитой тоонууд гэдгийг Та бүхэнд хэлэх гэсэн юм. Баярлалаа.

**Г.Дамдинням:** Ц.Мөнхтуяа гишүүн асууя.

**Ц.Мөнхтуяа:** Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Боловсролын сайд П.Наранбаяр 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн А/01 тоот “Хичээлийн жилийн бүтцийг батлах тухай” анхны тушаал байсан. Мэдээж бодлогын яамны сайдаар томилогдсон хүн судалгаа, шинжилгээ хийсэн гэж бодож байгаа. Гэхдээ өмнөх сайдын үед 3 улиралтай байсныг нийцэхгүй байна гээд буцаагаад 4 улиралтай болгосон. Гэтэл үүнийг буцаагаад 3 улиралтай болгох шаардлага байхгүй гэдгийг багш нар маш их шүүмжилж байгаа. Манай П.Наранбаяр сайдад нэг дутагдал байна. Та хөрсөн дээр ажиллаж байгаа багш нараа сонсмоор байна. Өнөөдөр сайхан агаарын тоог хэн ч цээжлээд яриад байж чадна. Хөрсөн дээрээ ажиллаж байгаа, амьдралын зовлон жаргалдаа буцалж байгаа хүмүүстэйгээ нэг уулзаач.

Миний хувьд анх 2017 онд багшийн цалин 535,000 төгрөг байхад багшийн цалинг 1.6 саяд хүргээд өгөөч гэж нийгэмд шүгэл үлээсэн багш хүний хувьд, өөрөө боловсролын салбарын халуун тогоонд 23 жил багшаар ажилласан хүний хувьд танд нэлээн үнэтэй, хөрсөн дээр буусан зөвлөгөөнүүдийг өгнө. Яг уулзъя гэхээр та өөрөө уулзахгүй, намайг харахаараа доошоо хараад, хулмалзаад өнгөрч байгаа. Тэгэхээр сайдтай уулзах хүсэлт байна. Намайг худлаа яриад гэж байгаа бол би сургууль сургуулийн төлөөлөл 200 багш цуглуулчихъя. Хоёулаа урдаас нь харж сууж байгаад асуудлаа ярья гэдэг урилга танд хүргүүлбье. Үүнийг Та эхлээд хэрэгжүүлмээр байна. Түрүүн чуулганы индэр дээр би танаас хоёр удаа үг хэлж, асуулт асуухад та нэлээн шоолонгуй өнгө аяс гаргаж, хүмүүсийн дургүйцлийг хүргэсэн байгаа. Тэгэхээр хамгийн түрүүнд та хөрсөн дээр ажиллаж байгаа багшаа сонс. Би сургуулиуд руу хүсэлт явуулаад 200 багш цуглуулчихъя.

Үйлдвэрчний эвлэлийн төлөөллүүдтэй уулзаж байгаа гэж байна. Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо ажлаа сайн хийж чадахгүй байна гээд 2017 онд жагсаал цуглаан хийгээд, 2018 оны 2 сард бид мэргэжлийн Үйлдвэрчний эвлэл болох Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоог Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хуулийн хүрээнд байгуулсан. Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбооны төлөөлөл багш нартай таныг уулзаач гэж дахин хэлье, сануулъя.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5.2-т “Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн жил нь 9 дүгээр сарын 01-ний өдрөөс дараа оны 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл үргэлжилнэ.” гэж заасан. 6 дугаар сарын 15 хүртэл хичээллэх ёстой гэсэн үг биш. 6 сарын 15-ыг хүртэл хичээллэнэ гэсэн санаа. Түүнээс хойш хичээллэхгүй гэдэг санааг агуулж байгаа гэж би ойлгож байгаа. Гэтэл П.Наранбаяр сайд багш байсан, сургуулийн захирал байсан гээд өөрөө их ярьдаг. Тэгэхээр 6 сар гарахаар шалгалт шүүлэг аваад, хичээл ороход ямар хүндрэл бэрхшээл хүүхдүүд, багш нарын дунд байдаг вэ гэдгийг надаар хэлүүлэлтгүй мэдэж байгаа байх. Тэгэхээр хичээлийн жилийн бүтэц бол нэг их оролдоод байхаар зүйл биш байсан шүү.

OECD-ийн гишүүн орнуудын 19.4 хувь нь 3 улиралтай, 33.3 хувь нь 4 улиралтай гэсэн хариулт өгсөн байна. Манай яамныхан, дарга нар дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын жишиг гэж их ярьдаг. Тэр жишгээ дуурайх гээд хичээлийн жилийн бүтцийг нь аваад ирж байгаа бол сургалтын орчныг нь, тэр цалин хөлсийг нь аваад ир. Багшлах боловсон хүчнээ яаж бэлтгэдэг юм, тэрийг нь хуулаад аваад ир. Өөрсдөдөө ашигтай юмыг нь хуулж авчихаад, багш нарт, хүүхдүүдэд хэрэгтэй юмыг нь болохоор хуулдаггүй ийм дутагдал ажиглагддаг. Манай багш нар ч үүнд шүүмжлэлтэй ханддаг.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.7-д “Холбогдох хуульд заасны дагуу гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгт шилжсэн үед сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.2-т заасан танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.” гэж заасан. Хичээлийн жилийн нэгдүгээр улирлын 18 дахь долоо хоногт гамшиг болно гэдгийг урьдчилан тооцоолоод ахлах ангийн сургалтыг цахимаар явуулахаар заачихсан. Үүнийг нь асуухаар Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.6-д заасан сургалтын цахим систем хөгжүүлэх.../минут дуусав./

**Г.Дамдинням:** Ц.Мөнхтуяа гишүүн нэмэлт асуултын минутыг одоо авах уу, хариултынхаа дараа авах уу? П.Наранбаяр сайд хариулт өгье.

**П.Наранбаяр:** Ц.Мөнхтуяа гишүүний асуултад хариулъя. Би нэг их хулмалзаад, хүнээс зугтаад байдаг ч хүн биш. Тийм юм байхгүй. Та надад уулзъя гэсэн хүсэлтээ ерөөсөө тавьж байгаагүй. Та надад албан бичгээр асуулгууд, асуултуудаа ирүүлдэг. Хуульд заасан хүрээнд би хариултыг нь өгдөг.

Би бүхий л сургууль, цэцэрлэгийнхээ эрхлэгч, захирлууд, багш нартай уулзаад явж байгаа. Шаардлагатай бол уулзана. Таны хэлсэнчлэн ийм юм

байхгүй гэдгийг хариуцлагатайгаар мэдэгдье. Та ч багш хүн, би ч багш хүн. Тиймээс үгээр хоёр биенээ идээд яах вэ дээ. Тийм биз. Та үгийнхээ сонголтыг бодох шаардлагатай болов уу гэж бодож байна.

Монголын Үйлдвэрчний эвлэлийн тухайд манай яамны зүгээс Хөдөлмөрийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэгт “Хамтын хэлэлцээр байгуулах санаачилга гаргасан этгээдийн тооноос үл хамааран тухайн түвшинд нэг хамтын хэлэлцээр байгуулна.” гэж заасан. Тэгэхээр Боловсролын яам болон Монголын боловсрол, шинжлэх ухааны Үйлдвэрчний холбооны хооронд хамтын хэлэлцээрийг байгуулахад Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоотой хамтарч байгуулах эсэх асуудлаар тодруулга авахаар 2023 оны 1А/4589 дугаартай албан бичгийг Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоонд бид хүргүүлсэн. Тус холбооноос, өөрөөр хэлбэл таны цаана сууж байгаа холбооных нь Ерөнхийлөгчөөс “Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо болон Монголын боловсрол, шинжлэх ухааны Үйлдвэрчний эвлэлийн холбоонд гишүүнчлэлгүй, төлөөлж оролцох боломжгүй талаар хариу ирүүлсэн юм. Тэгэхээр надтай зууралдахын оронд тэнд байгаа Үйлдвэрчний эвлэлийн холбоотойгоо яриад хоёр холбоо учраа олоод, нэг болоод ороод ирэх ийм л юм хэлээд байгаа шүү дээ.

**Г.Дамдинням:** Ц.Мөнхтуяа гишүүн тодруулъя.

**Ц.Мөнхтуяа:** Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо нь Монголын багш нарын Үйлдвэрчний эвлэлийн холбоог орох эсэхийг тогтоодог субъект нь биш л дээ. Тийм учраас Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай БНМАУ-ын хууль дээр хэд хэдэн Үйлдвэрчин байж болно. Нэгдээд тооныхоо харьцаагаар орох эрх нь хуулиараа байхад зориуд санаатайгаар манай холбоог оруулахыг эсэргүүцдэг ийм үйл ажиллагаа 6, 7 жил явагдаж байгаа юм.

Л.Энх-Амгалан сайдын үед янз бүрийн асуудалгүй, учраа олоод тэгшхэн харьцаж байсан. Энэ удаа бид хуулийнхаа хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам руу албан бичиг хүргүүлсэн. Үйлдвэрчний эвлэлүүд тэгш эрхтэй, хэн хэнийгээ захиргаадаад орох орохгүйг заадаг субъект биш. Үйлдвэрчний эвлэлүүдтэйгээ тэгш харьцаарай. Яг адилхан эрх тэгш субъект.

**Г.Дамдинням:** Гишүүд асуулт асуулаа. Надад хоёр, гурван асуулт байна.

Та хоёрынхоо ярилцаж байгааг харахад бид нарын ажил мэтгэлцэх үндсэн зарчмаар явж байгаа. Тэгэхээр яаж ярих нь Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн асуудал байх. П.Наранбаяр сайд аа, та гүйцэтгэх засаглалын хүн. Өөрийнхөө хариуцаж байгаа салбарын хамгийн дээд байгууллагад ажиллаж, төрийн бодлогыг барьж байгаа учраас Улсын Их Хурлын гишүүдийн асуултад тодорхой хариулах нь дээр байх. Улсын Их Хурлын гишүүн уулзъя гэж байгаа бол уулзах ёстой байх л даа. Засгийн газрын тухай хуульд ч, Улсын Их Хурлын тухай хуульд ч “Улсын Их Хуралд хүндэтгэлтэй хандана” гэдэг заалт байгаа шүү. Тэгэхээр энэ асуудлуудаа та нар хоорондоо ярьчихвал уг нь зүгээр байгаа юм. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулаад хэдэн асуулт байна.

Багш нартайгаа, амьдралын дунд явж байгаа хүмүүстэйгээ уулзаач ээ, яриа ч ээ, нийтийн дунд орооч ээ гэдгийг манай тойргийн гишүүд ч, багш нар ч ярьж байгаа. Сайд нар шинээр томилогдоод гоё харагдах гээд л зөндөө юм хийдгийг мэднэ. Шинэ ч юм биш, гоё ч юм биш. Багш нартай уулзах асуудлыг нь хүлээж аваач. Яагаад уулзаж болдоггүй юм.

Хоёрдугаарт, багш хомсдолын асуудлаар нэлээн яриа гарсан. Би Багшийн их сургууль байхад нь ороод Монгол Улсын Боловсролын их сургууль болоход нь төгссөн. Сурган, сэтгэл судлалыг 4 жил үзэж төгссөн хүн байхгүй юу. 4 жил тасралтгүй үзээд, дараа нь түүгээрээ магистр ч хамгаалсан. Хүүхдэд хичээл заана гэдэг бол мэргэжлийн ажил. Энэ бол хүний сэтгэл зүйтэй ажилладаг ажил. Өндөр хөгжилтэй улс орнууд, ер нь дэлхийн бүх улс орнуудад эмчтэй, хуульчтай зүйрлэж үздэг. Тэгэхээр энэ ажлыг багш дутагдаж байгаа нэрээр 45 хоногт бэлдэнэ гэдэг тийм ч сайн сонсогдохгүй байгаа. Би өөрөө 2023 оны 7 дугаар сарын 07-нд батлагдсан Боловсролын ерөнхий хуулийг болон хамт өргөн мэдүүлсэн нийт 8 хуулийг 4 хууль болгож баталж гаргахдаа таны хэрэгжүүлэх гээд байгаа энэ багш бус хүнийг багш болгодог тогтолцоог хуульд нь хийж өгсөн. Гэм буруутайг нь олоод ир гэвэл би байна. Гэхдээ хэрэгжүүлэхдээ “бушуу туулай борвиндоо баастай” гэж, сайд нь өөрөө журам гаргаад хэрэгжүүлэх ёстой эрхийг нь олгосон, 45 хоногт бэлдэнэ гээд байгаа чинь ямар учиртай юм. Энэ бол боломжгүй. Кредитийг нь цуглуулгаж байгаад, суулгаж байгаад хийх тухай асуудлыг яриа ч ээ. Ингэж болдоггүй юм уу? Эсвэл та нарын нийгэмд ойлгуулах аргачлал чинь буруудчихсан юм уу?

Дараагийн асуудал. Багш дутагдаж байгаа асуудлыг шийдэх дараачийн боломж бол онлайн сургалт. “Мэдлээ” [<https://medle.mn>] сургууль уг нь танай яамны дэргэд байгаа. Монголын бүх сайн, мундаг гэгддэг багш нарын бичлэг, хичээлүүд танай тэр сургууль дээр чинь байгаа. Онлайн сургалтын орчныг бүрдүүлээд багш дутагдлын асуудлаа шийдэх талаар ямар санал, санаачилга гаргаж ажиллаж байна вэ? Дэлхий даяар л онлайн-аар сурч, хэнээс ч хичээл авч үзэж болж байна. Хэдэн ч удаа асууж, хэдэн ч удаа үзэж байгаад сурч болж байна шүү дээ. Тэгэхээр энэ чиглэл рүү ямар санаачилга гаргаж байгаа вэ?

Дараагийнх нь, би таны танилцуулгаас харахад сурах бичгийг өөрчлөх тухай л асуудал яригдах юм, Боловсролын сайд болгон томилогдохоороо сурах бичиг өөрчлөх юм ярих юм даа. Хэдэн хэвлэлийн компанийн лоббид ороод л явдаг байдал руу орчхоод байдаг юм шүү дээ. Үүнийгээ больчихвол яадаг юм. Харин үүнийхээ оронд та нар “сургалтын хөтөлбөрүүдийг үзэл баримтлалтай болгоно” гэдэг заалтын хүрээнд ямар ажлууд хийж байна вэ? Дуртай болгон нь өөрчлөөд тодрох гээд оролдоод байдлыг болиулж, нэг батлагдсан хөтөлбөр 12 жил явдаг байя гэдэг хуулийн зохицуулалтыг бид хийж өгсөн. Үүний хэрэгжилт ямар байна вэ?

Төгсгөлд нь, бид “багш, багш” гэж явсаар байгаад сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, менежер, удирдах ажилтнуудаа хаясан байна лээ шүү. Нөгөө нэмэгдлүүд байхгүй, нийгмийн баталгаа нь байхгүй. Тэр сургуулийн хамаг ачааллыг үүрээд менежмент хийгээд явж байгаа хүмүүст дэмжлэг байхгүй болсон

байна. Энэ дээр ямар бодлого барих вэ? Адилхан л хүүхдийн дунд бужигнаад, алс орон зайд ажиллаж байгаа хүмүүс. Адилхан л олон цагаар ажиллаж байгаа. Тэр бүү хэл мань мэтийн хэрэгтэй хэрэггүй асуулт асууж, хэрэгтэй хэрэггүй дарга, шалгаж очдог хүмүүст байнга загнуулж орон нутагтаа байгаа хүмүүс шүү дээ. Бид нараас эхлээд олон даргатай, асар ачаалалтай хүмүүс байхгүй юу. Боловсролын салбарыг удирдаад явж байгаа энэ хүмүүсийнхээ нийгмийн асуудлыг бас бодох ёстой. Энэ дээр ер нь ямар бодлого барих вэ? Ийм асуултууд байна.

**П.Наранбаяр:** Баярлалаа. Г.Дамдинням гишүүний хэлээд байгаа саналуудыг хүлээн зөвшөөрнө. Миний бие 7 дугаар сарын 10-ны өдөр сайдаар томилогдсоноос хойш 3 сар орчим болж байна. Нийслэлийн бүх сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгч нартай уулзчихсан. Дархан хотод очиж боловсролын газрынхантай, Дорноговь аймагт очиж боловсролын газар, захирлууд, багш нарын төлөөлөлтэй уулзсан. Ер нь уулзалтуудыг эрчимжүүлнэ. Таны хэлсэнчлэн багш нарынхаа дуу хоолойг сонсох гэж л энд би сууж байгаа. Ц.Мөнхтуяа гишүүний хэлээд байгаа багш нартай ч уулзахад бэлэн байна. Бодит байдлаа эгцлэн хараад сайхан ярьцгаая. Энэ бол зүйтэй.

Багшийн хомсдол бодитой нүүрлэхээд байгаа. Байхгүй байна гэж хэлээд байгааг би ойлгохгүй байна. “Алтан нарыг алгаараа хааж болдоггүй” гэдэг шиг тэр бодитой асуудал чинь өөрөө байгаад байна. Бидэнд 6 багц арга хэмжээ байгаа.

- Багш мэргэжлээр төгссөн болон багшийн ажил эрхлээгүй байгаа хүний нөөцийг ашиглах;
- Тэтгэвэрт гарсан багш нарыг бага цагаар багшлуулах;
- Шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургууль амжилттай төгссөн, эсвэл 3, 4 дүгээр курсэд суралцаж байгаа оюутнуудыг багшийн ажилд татан оролцуулах;
- Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах;
- Багш бэлтгэх их, дээд сургуулийн 4 дүгээр ангийн оюутнуудыг дадлагажигч багшаар ажиллуулах;
- Цахим сургалтыг багшийн дутагдал өндөр байгаа хичээл, сургалтад илүү эрчимтэйгээр хэрэгжүүлэх гээд.

Энэ бол таны хэлээд байгаа яг тэр “Medle.mn” цахим сургууль. Энэ сургууль дээр одоо бараг 20 мянга гаруй хичээл бэлтгэгдчихсэн байгаа. Үүнийгээ цахим орчинд өөрсдөө ороод үздэг “Metaverse” хэлбэр лүү оруулж, илүү таатай үзэх боломжийг бий болгохоор ажиллаж байна. Энэ бол багшийн хомсдолыг арилгахад, ялангуяа алсын зайд байгаа хүүхдүүдэд хэрэгтэй. Та бүхэнд уриалахад “хүүхэд бүрд компьютер” гэсэн хэрэгтэй заалт байсныг нь дэмжээгүй шүү. Тэгш хүртээмжийг нэмэгдүүлэхэд цахим сургалтын арга барил хэрэгтэй гэдгийг шууд хүлээн зөвшөөрнө. Сурах бичиг өөрчлөх нь өөрөө хуультай болсон. Үндэсний хөтөлбөртэй уялдуулаад зарим нэгэн сурах бичгээ өөрчлөх ажлыг хуулийн дагуу л хийнэ. Түүнээс нэг сайд гарч ирээд өөрчлөх асуудал одоо байхгүй болсон. Хуулиараа хориотой. Жишээлбэл, сургуулийн өмнөх боловсрол дээр “Түмэн бодис” гэдэг хичээл орохоор бичигдэж байна.

“Унших бичиг” хичээлийн асуудал бас орж ирж байна. Ийм зүйлүүдийг дагасан сурах бичгүүдийг мэргэжлийн хүмүүс нь хуульд заасны дагуу боловсролын .../минут дуусав./

**Г.Дамдинням:** Нэмэлт 1 минут өгье.

**П.Наранбаяр:** Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнтэй хамтраад явж байгаа. Та бүхэнд явцыг мэдээлэхэд бэлэн байна. Боловсролын үндэсний хөтөлбөрийг шинэчлэх үзэл баримтлал нь батлагдчихсан байгаа.

Таны хэлж байгаа яг үнэн. Сургуулийн, цэцэрлэгийн эрхлэгч, захирлуудын цалин хангамж багшаасаа доогуур орчихсон. Энэ нэмэгдлийг нь олгох шаардлага байна. Энэ дээр бид тооцоо хийж байгаа. Хүмүүстэй уулзаад явахад үүнийг хэлж байна. Ялангуяа цэцэрлэгийн эрхлэгч нарт тэр балансын урамшууллыг нь олгочихоор аудит нь очоод торгочихдог. Энэ асуудлаар бид аудитын байгууллагад хандаж байгаа. Баярлалаа.

**Г.Дамдинням:** Тэгэхээр П.Наранбаяр сайд, асуудлуудыг хэдүүлээ хуралдаанууд дээр сайхан хэлээд явах нэг хэрэг. Дарга нартай уулзаад тойроод явах даргын л ажил. Яг багшлах боловсон хүчинтэйгээ уулз, П.Наранбаяр сайд аа. Багшлах боловсон хүчинтэйгээ уулзахад өөр юм ярьдаг юм шүү. Боловсролын хуулийг бид өөрчлөхдөө боловсролын хямралд орчихсон байна гэж үзээд босоо тогтолцоо руу шилжүүлчихсэн. Үр дүн нь гарах ёстой. Та өөрөө шууд халж болдог тогтолцоо руу орчихсон учраас таны томилгоогоор ажиллах хүмүүс танд бодит амьдралыг хэлэхгүй шүү. Багш нартайгаа уулз. Багш нартайгаа аймаг аймгаар нь уулз. Би ч гэсэн тантай багш нараа уулзуулахад бэлэн байна, багш нар уулзах ёстой.

Энэ асуулгыг харвал яг багш нар бичсэн байгаа байхгүй юу. Амьдралд нь тулгамддаг бэрхшээлүүдийг, хэр баргийн хүн мэдэхээргүй. Эдгээрт анхаармаар байна. Тэр 45 хоногийн багш гэдэг юмаа больж үзээрэй дээ. Хэдүүлээ бас нэг ойлголцолтой байя, төр байна даа. Тэгж тоглоом хийгээд ях вэ.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулиар асуулт асуусан гишүүн үг хэлнэ. Ц.Мөнхтуяа гишүүнд 5 минут өгье.

**Ц.Мөнхтуяа:** Дутуу орхисон асуултуудаа асууя. Боловсролын сайдын 2024 оны 7 сарын 25-ны өдрийн А/06 дугаар тушаалын талаар. Энэ тушаал нь сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, сурах бичгийн эх зохиох, хянах, багийн бүрэлдэхүүн батлах тухай заасан байгаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны эрхлэх асуудалд хамаарах чухал салбар болохын хувьд асуудлын ач холбогдол, хамрах хүрээг нь бодож үзсэн ч энэ сэдвийн хүрээнд Байнгын хорооноос олон нийтийн оролцоотой нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж, асуудлыг нэлээн дэлгэрэнгүй авч үзэх хэрэгтэй байна. Тэгэхгүй бол сургалтын хөтөлбөр, сурах бичгээ баталчихдаг. Дараа нь

“өнгөрсөн борооны хойноос цув нөмөрнө” гэдэг шиг бөөн асуудал дагуулдаг. Энэ дээр П.Наранбаяр сайд сайн бодолцоорой. 200 гаруй хүн сонгоод хийж байгаа гээд тушаал гарчихсан байсан. Тэнд орсон хүмүүсээс чинь надад гомдол ирээд байгаа л даа. Бид ерөөсөө уулзаагүй, юу ч яриагүй байгаа гээд. Тэгэхээр ам, ажил хоёр чинь зөрөөд байна гэдгийг сануулж хэлэх нь зүйтэй байх.

Дараагийн асуудал, миний зүгээс Боловсролын яамнаас ирүүлсэн “Багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах журам”-ын төсөлтэй танилцаад, өөрийн цахим хаягтаа багш нарт танилцуулж, санал авч байгаа бөгөөд саналаа цуглуулж дуусаад нэгтгэсний дараа Боловсролын сайдад албан бичгээр хандана. Үүнийгээ танд эртхэн дуулгая гэж бодож байна. 45 хоногийн курсийн тухайд би Г.Дамдинням гишүүнтэй үнэхээр санал нэг байна. Багшийн мэргэжил 4 жил сурч, сурган, сэтгэл судлал бүтэн үздэг ийм нарийн нандин мэргэжил. “Нарт хорвоод эгнэшгүй нандин сайхан албыг гагцхүү багш хүнд заяажээ” гэсэн үг зүгээр хоосон гараагүй байх гэж ойлгож байна. Тэгэхээр багшийн мэргэжлийг жирийн өөр мэргэжлийн хүмүүсээр 45 хоногийн курсээр бэлдэнэ гэдэг үнэхээр бүтэхгүй. Харин тэтгэвэрт гарсан багш нараа бага цагаар багшлуулна гэдэг чинь их зөв. Сая П.Наранбаяр сайдын дурдсан шинжлэх ухааны чиглэлээр их, дээд сургууль амжилттай төгссөн, эсвэл 3-аас 4 дүгээр курст суралцаж байгаа оюутнуудыг багшийн ажилд татан оролцуулах ажлыг Л.Энх-Амгалан сайдын үед хийж эхлүүлсэн. Сургалтын цагийн норм 19 цагт хүрдэггүй зарим багш нарыг хөрвүүлж ижил төстэй хичээл заалгах зэрэг янз бүрийн аргууд байна. Харин 45 хоногийн курс чинь үнэндээ таалагдахгүй байгааг бас хэлье.

Боловсролын салбар боловсон хүчний хомсдолд орсон. Үндсэн шалтгаан нь ерөөсөө л цалин. Түрүүн Д.Бум-Очир гишүүн хэлж байна. Цалингаа л дорвитойхон нэмж байж энэ салбарт хүмүүс өрсөлдөөнтэй орж ирнэ. Та нар хар ухаанаар бод доо. Яг энэ мэргэжил дээр 300-аас 400-хан ам.долларын цалин дээр өндөр хөгжилтэй оронд төгссөн тэр мундаг залуус чинь ирж ажиллах уу. Энэ тал дээр бүгдээрээ хөрсөн дээрээ бууя. Г.Дамдинням гишүүн Боловсролын ерөнхий хуулийг батлуулахад өөрөө манлайлж, ахалж орсон хүний хувьд хоёулаа цалин дээр хамт дуугаръя. Сая Галаа захирал ч хэлж байна. Үнэгүй магистрт тэтгэлгээр явуулаад явуулаад нөгөө 300 ам.доллар дээр чинь ирж ажиллах уу.

Багш нарын цалин арай л дэндүү бага учраас ажлаасаа зугтааж байна. Бүгдээрээ Солонгос явах хүсэлтэй, визэнд орж байна. Тэгэхээр бүгдээрээ тулга тойрсон юм яриад байхгүй гол асуудал руугаа орж, бодитой ажил хийх хэрэгтэй байна. Гол асуудал чинь ерөөсөө л цалин.

**Г.Дамдинням:** Ц.Мөнхтуяа гишүүнээс Боловсролын сайдад хандаж тавьсан асуултын хариуг сонсож дууслаа. Улсын Их Хурлын хянан шалгах бүрэн эрхийг хэрэгжүүлэх хүрээнд Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнд хандаж “асуулт, асуулга” тавьдаг. Гишүүн санал гаргавал Байнгын хорооны болон Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсдог дэгтэй. Гишүүд асуулт асууж, санал хэлж дууслаа. /алх цохив./

Гишүүдийн хэлсэн саналуудыг ажил хэрэг болгож дараагийн ажлууд дээрээ тусгаад явна гэдэгт найдаж байна. Хэлэлцэх асуудал дууслаа. Байнгын хорооны хуралдааныг өндөрлүүлж, идэвхтэй оролцсон гишүүддээ талархал илэрхийлье.

---oO---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯСГАЛАНГААС 2024 ОНЫ  
8 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
Л.ОЮУН-ЭРДЭНЭД ХАНДСАН “ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР” АСУУЛТ-12**



Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ хүрээнд дараах асуултыг Танд тавьж байна. Үүнд:

- 1.Бүгд Найрамдах Энэтхэг Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Газрын тос боловсруулах үйлдвэр барих” төслийн ажлын гүйцэтгэлийн явцын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 2.Тус төслийн хүрээнд Улсын төсөв болон Монгол Улсын Хөгжлийн банкнаас санхүүжилт олгож эхэлсэн болон зогссон хугацаа, олгосон санхүүжилтийн нийт дүн, түүний зарцуулалтын талаарх мэдээлэл;
- 3.Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Засгийн газраас авсан зээл, үүнтэй холбоотойгоор байгуулсан гэрээнүүд, тэдгээрийн нэмэлт, өөрчлөлтүүд болон зээлийн хөрөнгийн зарцуулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 4.Төслийн 1, 2, 3, 4 багц ажлын хүрээнд хийгдсэн дэд бүтцийн төслүүд тэдгээрийн үр дүнгийн талаар;
- 5.Төслийн хүрээнд ерөнхий, туслан гүйцэтгэгч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч гадаад болон дотоодын компаниуд тус бүрийн хариуцсан ажлын үнийн дүн, ажлын гүйцэтгэлийн явцын болон хийсэн ажлын тайлан, тэдгээрийн сонгон шалгаруулалтын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;
- 6.“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйл ажиллагааны зардлын дэлгэрэнгүй мэдээлэл;
- 7.Монгол Улс 2020-2024 онд шатахуунд зарцуулж буй мөнгөн дүн болон газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн эдийн засгийн үр ашгийн тооцоолол;
- 8.“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн үйл ажиллагаа болон санхүүд хийсэн дотоод болон олон улсын хөндлөнгийн аудитын байгууллагын тайлан, дүгнэлтүүд;
- 9.Бүтээгдэхүүн хуваах гэрээний талаар;

10.Төслийн хүрээнд бий болох ажлын байрны тоо, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-д одоо ажиллаж буй нийт ажилтнуудын тоо, үүнээс газрын тосны үйлдвэрийн хотхонд орон сууцанд хамрагдан амьдарч буй ажилтнуудын тоон мэдээлэл;

11.“Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК нь газрын тос хайх болон ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшдэг эсэх талаар дэлгэрэнгүй мэдээлэл зэрэг болно.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан хугацаанд бичгээр ирүүлж, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахад бэлтгэхийг Танаас хүсье.

---oOo---

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Л.МӨНХБАЯСГАЛАНГААС МОНГОЛ  
УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ХАНДСАН “ГАЗРЫН ТОС БОЛОВСРУУЛАХ  
ҮЙЛДВЭРИЙН ТАЛААР” АСУУЛТ-12-ЫН ХАРИУГ АЖ ҮЙЛДВЭРЖИЛТИЙН  
БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ 2024 ОНЫ 10 ДУГААР САРЫН 30-НЫ  
ӨДРИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН МЭДЭЭЛЭЛ**

Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны 2024 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангаас Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаарх асуултын хариуг хэлэлцэв. Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг, мөн компанийн Технологийн албаны дарга Б.Мөнх-Эрдэнэ, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга Э.Түвшинжаргал, компанийн Стратеги төлөвлөлт, төслийн газрын дарга Ц.Анх-Од нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны референт Г.Баярмаа, Хяналт шалгалтын газрын референт Р.Дүүрэнбаяр нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалангийн Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж тавьсан асуултын хариуг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав. Горимын саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаясгалан үг хэлэв. Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулахад дэмжигдээгүй болно.

Асуултын хариуг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг танилцуулав.

**С.Ганбаатар:** Улсын Их Хурлын гишүүн Лувсанбямбаагийн Мөнхбаясгалангийн Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Монгол газрын тос боловсруулах үйлдвэр барих төслийн талаар тавьсан асуултын хариуг сонсьё.

**Д.Алтанцэцэг:** Сайн байцгаана уу? Эрхэм хүндэт Улсын Их Хурлын гишүүд, Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны гишүүд та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Миний нэр Д.Алтанцэцэг, “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Та бүхэнд Монгол газрын тосны үйлдвэрийн бүтээн байгуулалтын явцын талаар товчхон танилцуулъя.

Юуны өмнө хэлэхэд “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” гэдэг компани анхандаа Монгол Улсад газрын тосны үйлдвэр барихаар байгуулагдсан боловч дагалдах төслүүд ч хэрэгжүүлдэг. Манай гол төсөл болох газрын тосны үйлдвэр Дорноговь аймгийн Алтанширээ сумын нутагт баригдаж байгаа.

Хоёр дахь төсөл бол үйлдвэрийн түүхий эдийг тээвэрлэх газрын тосны “Тосон Уул-ХИХ” талбайгаас үйлдвэрийн талбай хүртэл 530км түүхий тос дамжуулах хоолой. Энэ нь Монгол Улсдаа газрын тос, байгалийн хий дамжуулах анхны том дэд бүтэц болж байгаа юм. Газрын тосны үйлдвэрийн хотхон мөн нийгмийн шаардлагаар урган гарч ирсэн. Дорноговь аймагт багадаа үйлдвэрийн 500, 600 ажилчид ажиллана. Ихэнх нь залуучууд байдаг учраас залуу гэр бүлийг орон сууцтай болгох, нийгмийн асуудлыг шийдэх зорилготой. Хоёрдугаар гол зорилго нь энэ хотхонд үйлдвэрийн бүтээн байгуулалтад оролцох гадаад, дотоодын гэрээлэгчдийг оролцуулснаар бид нар хөрөнгө оруулалтын зардлыг нэлээд хэмжээгээр бууруулах арга хэмжээ авч байгаа. Энэ дэд бүтцийн төсөл 2018 онд Монгол Улсын Засгийн газрын шийдвэр гарч Хөгжлийн банкны санхүүжилтээр 2 жилийн дотор баригдаад 2019 оны 10 дугаар сард хүлээлгэж өгсөн. Манай хамгийн хурдан явагдсан төсөл байгаа. Энэтхэгийн Засгийн газар 2017 онд ирж зээлийн шугам дагаж мөрдөх журмыг танилцуулахдаа манай Засгийн газрын хөнгөлөлттэй зээл бол зөвхөн үйлдвэрийг барихад зарцуулагдана гэдгийг мэдэгдсэн. Улс оронд цоо шинээр салбар бий болж байгаа учраас дагалдаж гарах дэд бүтэц, эрчим хүчтэй холбоотой асуудлуудыг танай Засгийн газар өөрсдөө шийдээрэй гэсэн танилцуулга явсны дагуу төр засгаас түргэн шуурхай шийдвэр гаргаад, энэ дэд бүтцийг барьж байгуулсан.

Мөн аль ч улс орны газрын тосны ийм интегрэйтэд компани болгохын тулд газрын тосныхоо нөөц, баялгийг мэдэх ёстой байдаг юм байна. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2014 оны 3 дугаар сарын 17-ны өдөр гарсан зөвлөмжөөр Монгол Улс газрын тосны үйлдвэр баривал өөрийнхөө тосыг боловсруулна гэсэн зөвлөмж байдаг. Тэгтэл бид газар доорх тосоо өөрсдөө сайн мэдэхгүй байгаа. Хайгуул хийсэн, олборлодог хоёр компани нь Хятадынх. Сүүлд Америк, Их Британийн хөрөнгө оруулалттай Петро Матад ХХК монгол хүний нээсэн цооног дээр тос олборлолт эхэлж байна. Энэ бол манай компанийн хэрэгжүүлж буй төслүүд.

Энэ зургийг яах гэж харуулсан юм гэвэл манай газрын тосны үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардлын тухай та бүхэн асуух байх. Тэгэхээр хамгийн гол ойлгох ёстой зүйл бол анх энэ үйлдвэр 1 тэрбум ам.долларын өртөгтэй байгаагүй юм шүү. Энэ 1 тэрбум ам.доллар гэдэг нь 2015 онд Энэтхэгийн Ерөнхий сайд манай Ерөнхийлөгчтэй уулзахдаа Энэтхэгийн Засгийн газраас 1.75 хувийн хүүтэй Засгийн газрын нэн хөнгөлөлттэй зээлийг танай улсын хөгжлийн төсөлд зориулж олгох боломж байна. Энийг Монголын Засгийн газар 2017 оны 2 сард шийдэхдээ, ямар ч байсан энэ хөрөнгөөр газрын тосны үйлдвэр барья гээд техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг нь хийлгэсэн. Ингээд ТЭЗҮ-ийг нь хийлгэхэд 2017, 2018 онд хийсэн ТЭЗҮ-ээр үйлдвэрийн бүтээн байгуулалтын зардал хамгийн доод тал нь 1 тэрбум 236 сая болох юм байна. Анх 1 тэрбум 480 гэсэн тоотой байсан. Тэгэхээр 1 тэрбумаас хол давж байгаа учраас бид техникийн хувьд олон буултууд хийсэн. Жишээ нь, газрын турбиныг нь уурын турбин болгох гэх мэтчилэн техникийн хувьд буултууд хийснээр 1 тэрбум 236 гэдэг тоог Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулсан юм.

Монгол Улсад газрын тосны үйлдвэр барьж байсан түүх бол бараг 60 жилийн өмнө Зүүнбаянд Оросууд барьж өгч байсан. Монгол Улсад мэдлэг туршлагатай хүн байхгүй, техник технологи нь байхгүй учраас ТЭЗҮ-д хөндлөнгийн хяналт хийх шаардлага гарсан. ТЭЗҮ-ийг Энэтхэгийн төрийн өмчит газрын тосны Энэтхэгээс гадна олон улсад маш нэр хүндтэй “Инженерс Индиа” (Engineers India Limited) гэж компанид боловсруулсан. Бид өөрсдөө бас хөндлөнгийн хяналт тавиулах ёстой учраас Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас олон улсад нээлттэй тендер зарлаж байгаад Италийн Кинетикс технологи (Kinetics Technology), Прометивз (Prometeus) гэж хоёр компанийн түншлэлээр энэ ТЭЗҮ-д жил хагасын турш хяналт тавиулсан.

Италийн компаниуд бид нарт маш их тусалсан. Бид нар асар их мэдэхгүй юмаа мэдэж авсан, техникийн олон сайжруулалт хийсэн, энэ хооронд. Газрын тос боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ гэдэг бол энэ үйлдвэрийг Монгол Улс барьж чадах юм уу, чадахгүй юм уу, хэрэгтэй юу, хэрэггүй юу гэдэг асуултад хариулт өгдөг судалгааны баримт бичиг. Ингээд 2019 оны эхээр эцэслээд үүнийг барих нь Монгол Улсын эрчим хүчний бие даасан байдал, цаашилбал улс үндэстний тусгаар тогтнолтой холбоотойгоор ямар ч байсан барих шийдвэр гараад, 2019 онд “инженерчлэл” гэдэг ажлаар үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил эхэлсэн.

Инженерчлэл хийхийн өмнө олон улсын томоохон аж үйлдвэрийн төслийн жишгээр Төслийн менежментийн зөвлөх гэдэг компани авдаг. Энэ нь Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлээр хэрэгжүүлж байгаа учраас тэр улс өөрийнхөө бүх улсад хэрэгжүүлж байгаа төсөлтэй ижил төсөлд дагаж мөрддөг журмыг бид нарт танилцуулсан. Түүнд зөвлөх болоод гүйцэтгэгч бүх компани Энэтхэгийн компани байна гэсэн ийм үг, үсгээр эхэлдэг. Ингээд Энэтхэгийн компани үргэлжлүүлээд манай үйлдвэрийн төслийн менежментийн зөвлөхөөр ажилласан. Энэ компанийн онцлог бол зөвхөн менежмент хийгээгүй. Энэ компани үйлдвэрийн зураг төсөл, худалдан авалт, барилга угсралтын бүх үе шат, улсын комисст хүлээлгэж өгөх хүртэл монголын Засгийн газрын Монгол газрын тос боловсруулах үйлдвэрийн өмнөөс хяналт тавьдаг компани юм. Мөн энэ компани инженерчлэлийн 5 үе шатын зарим лицензгүй технологийн байгууламж болоод дагалдах, туслах бүх байгууламжуудын ерөнхий зураг төслийг хийсэн компани.

Үйлдвэрийн бүтээн байгуулалт 4 багц ажлын хүрээнд хэрэгждэг. Эхнийх нь технологийн бус барилга, байгууламж буюу бусад барилга, байгууламжуудыг барих суурийг тавьж байгаа юм. Манай үйлдвэрийн онцлог нь бүх зүйлийг эхнээс нь барьж байгаа. Бид сая хэлсэн зам харгуйгаасаа эхлээд гээд. Энэ технологийн барилга, байгууламжуудын ажил 2021 онд яг КОВИД-19-ын үед эхэлсэн. Бид ямар ч байсан гэрээ байгуулсан үнийн дүнгээрээ хичээсээр байгаад бариулж дуусгалаа. Энэ хооронд уг компани чартер, хамаг юмны үнэ өссөн олон шалтгаанаар монголын талаас нэхэмжлэл гаргасан. Бид гэрээнийхээ хүрээнд манай компанийн Гэрээ, эрх зүйн газар, санхүү, эдийн засаг, манай компанийн мэргэжилтнүүд үнэхээр хичээж ажиллаж, гэрээний дүнг өөрчлөхгүйгээр ажлыг дуусгаад улсын комисст хүлээлгэж өглөө.

Хоёрдугаар багц ажлаар үндсэн технологийн байгууламж эхэлж байгаа .../минут дуусав./

**С.Ганбаатар:** Д.Алтанцэцэг даргад минут нэмж өгье.

**Д.Алтанцэцэг:** Товчхон ярья. Та бүхний харж байгаа энэ ногоон буюу эхний технологийн бус барилга, байгууламжийн ажлын хүрээнд 89.9км урт шугам хоолой, цахилгаан дамжуулах шугам, үйлдвэрийн талбайд 11 иргэний байгууламж, усны нөөцийн сав гэх мэтчилэн бүгдийг бариад дуусгалаа. Үүнтэй холбогдуулаад төр шинээр өмчтэй болсон учраас үүнийг арчлах, хамгаалах зардал гарч ирэх учраас энэ талаар бид өнгөрсөн оны сүүлээс Засгийн газарт хандсан. Харуул хамгаалалт, хулгай зэлгий их байна. Эрчим хүч ашиглаад эхлээд улсын комисст хүлээлгэж өгсний маргаашаас нь захиран зарцуулах асуудлаа та нарын хэн чинь шийдэж, хэн хариуцах юм гэдэг. Засгийн газар ерөнхийдөө шийдлүүд олоод явж байгаа.

Хоёрдугаар багц ажил бол үндсэн технологийн байгууламжууд. Энд асар их шугам хоолой, шугам хоолойн тулгуур баригдана. Нийтдээ 500км шугам хоолой, атмосферийн нэрлэгийн, вакум нэрлэгийн байгууламж, толгой хий ялгах байгууламж, 40 орчим газрын тос, завсрын бүтээгдэхүүн болон бэлэн бүтээгдэхүүний агуулах сав, парк, бүтээгдэхүүний ачих, буулгах байгууламж баригдана. Эдгээр ажил эхэлсэн. 2022 оны 10 сарын 28-нд гэрээгээ байгуулсан. Энэ бүх ажлууд “EPC” буюу инженерчлэл, худалдан авалт, барилга угсралт буюу түлхүүр гардуулах нөхцөлтэй олон улсын FIDIC гэрээний нөхцөлийг дагаж мөрдөх гэрээ юм.

Одоо EPC-2 дугаар ажлын зургийг Intecsa гээд Испанид хийдэг. Тоног төхөөрөмжийн захиалгууд эхнээсээ хийгдээд үйлдвэрлэл эхэлсэн. Тухайлбал, технологийн зуухыг Францын Axens-ын охин компани Ардэй, давсгүйжүүлэх байгууламжийн Intecsa, АНУ-ын Forum energy гэх мэтчилэн газрын тосны үйлдвэр, нефть, химийн үйлдвэрийн салбар нь дотор нь ороод ажиллаад ирэхээр ойлгомжтой байдаг юм байна. Өөрөөр хэлбэл тэр юмыг нь тэр л компани хийдэг, тийм 3 газар л үйлдвэрлэдэг, зургийг нь тэр л хийдэг гээд.

Та бүхэн ажлын явцыг харж байна. Манай үйлдвэрийн талбай дээр Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооныхон хавар дулаарангуут очиж үзээсэй гэж бодож байна. Шугам хоолойн тулгуурын ажлууд хамгийн түрүүнд хийгдэж, тэр олон зуун км шугам хоолой хамгийн түрүүнд тавигдах ёстой. Энэ жил хамгийн гол нь суурийн бетон цутгалтын ажлыг 40,000м<sup>3</sup>-ыг хийж чадах уу, үгүй юу гэж байсан бол одоо яг 39,000м<sup>3</sup> дээр төлөвлөгөөгөө биелүүлж байна. Стокадын ган хийцүүд байна. Ган хийцүүд бол хагас бэлэн бүтээгдэхүүн гэсэн учраас Энэтхэгийн зээлийн нөхцөлөөр өөр орноос авахаар болж Хятадын Хайнанд хийж байгаа. Энэ жил үйлдвэрийн талбайд “EPC” гэрээлэгчийн 1500 гадаад ажилчин ажиллалаа. Хоёрдугаар багц ажлын гол ажил бол үйлдвэрийн хянах байрууд Мониторинг төвүүд байгаа.

Гуравдугаар багц ажил бол үйлдвэрийн цахилгаан станц. Агуулах сав энэ тэрийг ярихад манай улсад одоогоор газрын тосны бүтээгдэхүүний л агуулах сав байдаг. Хамгийн том нь 8000-10,000м<sup>3</sup> орчим байдаг. Манай түүхий тосны агуулах сав бол хамгийн том нь 40,000м<sup>3</sup>, 45,000м<sup>3</sup>. Өөрөөр хэлбэл, диаметрээрээ Бөхийн өргөө шиг том байгууламжууд баригдаж байгаа.

Үйлдвэрийн Дулааны цахилгаан станцын уурын турбинийг Германы Сименс /Siemens/-ийн захиалгаар хийгдэж байгаа. Бойлерыг Их Британийнх байгаад сүүлд Wood-эд орсон Испанийн Foster wheeler-ийн захиалгаар үйлдвэрлэгдэж байна. Энэ үйлдвэрийн цахилгаан станцын үндсэн өгөгдөл 265 тонн.цаг хурц уур үйлдвэрлэнэ. 35МВт хүчин чадалтай.

Нийт зураг төслийн ажил өнөөг хүртэл зохиогдсон, батлагдсан зургаар бол 100-аад мянган зураг, төслөөр яригдаж байгаа.

Бидний хамгийн эмзэг цэг энэ 4 дүгээр багц ажил буюу олон улсын нефть, химийн салбарын технологи хөгжүүлэгч газрын тосны салбарын магнатуудын зохиосон технологийн патенттай байгууламжууд байна. Заавал эдгээрийн байгууламжийг патентаар нь хийдэг. Энэ лиценз эзэмшигчдийг сонгон шалгаруулах асуудал 2019 оны сүүлээр эхэлсэн. Тэд нар чинь манай үйлдвэрийг тэр болгон сонирхохгүй. Яагаад гэвэл овор нь хэтэрхий бага. Жишээ нь, бензин боловсруулах үйлдвэрийн изомержуулалт гэдэг байгууламж бол жилийн урсгал нь 88,000 тонн гэхээр энэ Honeywell UOP, Shell, Chevron зэрэг компаниуд чинь манайх ийм жижигхэн урсгалтай юм хийдэггүй гэх жишээтэй. Гэхдээ компани байгаа тулдаа бид нар энийг дэлхийд нээлттэй зарладаг. Технологийн лиценз эзэмшигчдийн маш хүндрэлтэй үе шат байсан. Үүнийг даван туулаад, энэ концернууд өөрсдийнхөө тухайлсан байгууламжийнхаа ерөнхий зураг төслийг нь 2022 оны сүүлчээр манайд нийлүүлсэн. Ингээд гэрээ байгуулах үед “КОВИД-19”-ийн хүнд үе таарсан.

Ингээд та бүхний хамгийн сонирхож байгаа хэсгийг одоо ярья.

ЕРС-4 багц ажлыг үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал нь тендерт ирүүлж байгаа үнээр тооцогдож байгаа юм. Засгийн газрын гишүүдээс тавьж байгаа асуулт юу вэ гэвэл бид өөрсдөө төсвөө зохиож байгаа юм шиг ярьж байгаа юм. Тэгэхээр ЕРС гэрээ гэхээр бид олон улсад тендер нээлттэй шалгаруулаад, түүнээс ирсэн дүнгээр нь үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал тодорхойлогдож байгаа юм.

Ингээд бид ямартай ч үйлдвэрийн бүтээн байгуулалтад дутахаар юм байна. Өөрөөр хэлбэл 1 тэрбум 236 саяас давахаар юм байна. Тэгэхээр ямар ч байсан батлагдсан үнийн дүндээ багтаагаад 4 дүгээр багц ажлынхаа эхний хэсгийг байгуулж байх шийдвэрийг Засгийн газар өнгөрсөн жилийн 9 сард гаргаад байгуулсан боловч Энэтхэгийн Экзим банк нийт хөрөнгө оруулалтын зардал шийдэгдсэн тохиолдолд зээлийн шугамд оруулна гээд оруулаагүй. Тэгэхээр гишүүд та бүхэндээ зээлийн энэ тодотголын талаар хэлэхэд хөрөнгө оруулалтын зардал бол 1 тэрбум 236 сая байж байгаад 1 тэрбум 658 сая буюу 34 хувиар өссөн. Энэ хөрөнгө оруулалтын зардал өссөн шалтгааныг бид бүгд мэдэж байгаа. Дэлхийн зах зээл дээр бараа материал, техник, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээний зардал өссөн үү гэвэл өссөн.

Хоёрдугаарт, бид ТЭЗҮ-ийн дараа инженерчлэл эхлэхэд маш олон төрлийн оновчлолууд хийх шаардлагатай болсон. Ямар ямар оновчлол хийгдсэн

талаар би дараа ярья. Яг барихдаа тулахаар тэнд ч тийм юм, энэ ч ийм шаардлагыг сайжруулах шаардлагатай, лиценз эзэмшигч заавал энэ тоноглол шаарддаг гэх мэтээр маш нарийн олон мянган юм гарч ирдэг. Тэгэхээр бидний оновчлолын гол зорилго юу байсан гэхээр техник, технологийн эдэлгээг уртасгана, түвэгшлийг бууруулах, дээрээс нь эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, алсдаа байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах гэх мэт зүйлүүдээс болж үнэ өссөн юм. Өнгөрсөн жилээс хойш манай Засгийн газраас Энэтхэгийн Засгийн газарт хандан 7 удаа албан ёсоор зээлийн дүнг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалтын зардлыг бүрэн шийдэж өгөхийг хүссэн албан бичиг явсан.

Ингээд төсөл хэрэгжих хугацаа хойшлох, зардал өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлүүдийг Та бүхэнд хэлье. Байнгын хорооны гишүүдэд хандаж хэлэхэд, ерөнхийдөө манай улсад томоохон төсөл, хөтөлбөр гадаад улсуудтай хамтарч хэрэгжүүлэхэд хүндрэлтэй зүйл нь бидний ажиглалтаар дотоод, гадаад шалтаг байна.

Гадаад шалтгаан нь геополитикийн асуудал, дээрээс нь дэлхийн зах зээлийн үнэ ханш, гуравдугаарх нь манайх далайд гарцгүй орон болохоор тээвэр ложистик, хүндрэлтэй байна.

Дотоод шалтгаан нь угаасаа хүнд аж үйлдвэрийн салбар муу хөгжсөн, дэд бүтэц хангалтгүй, мэдлэг туршлагатай экспертүүдийн хомсдолтой, техник, тоног төхөөрөмж дутуу, эрх зүйн орчинд зарим зүйл нь ойлгомжгүй байна. Янз бүрийн дүрэм, журмаар маш их боомилчихсон, салбар хоорондын уялдаа дутмаг байна. Барилгын улирал богино гэдэг бас маш том дайсан. 4 сарын турш бид юу ч хийж чадахгүй байж байна. Эдгээр хүчин зүйлүүд нь төслийн хугацааг алдагдуулах, зардлыг өсгөх хүчин зүйл болж байна.

Ингээд 2, 3 дугаар багц ажил бид нарт юу тохиолдсон бэ? Зовлон жаргалаа ярина гэж сая.../минут дуусав./

**С.Ганбаатар:** Д.Алтанцэцэг даргад дахиад микрофоныг нь нээж өгье.

**Д.Алтанцэцэг:** Маш хурдан ярья. 2, 3 дугаар тендер зарлах үед КОВИД-19 таарсан. Тендерт оролцох хүн байхгүй. ЕРС-2-ын тендерийн хугацааг 5 удаа, ЕРС-3-ын тендер 7 удаа сунгасан. Яасан гэхээр гэнэтхэн үнэ нь өсчихсөн. Дээрээс нь тоног төхөөрөмжийг нийлүүлэхэд, Монгол руу аваачихад хэцүү болсон. Тяньжинь дээр ийм ийм асуудалтай гээд компаниуд оролцохгүй. Бид нар уриад л байдаг, уриад л байдаг. Тендерийн хугацаа дуусах болохоор л дахиад 3 сараар, 2 сараар. Бид нар тендер авахгүй байснаас сунгаад ч болсон авсан нь дээр гэдэг байр суурь дээр бүгд нэгдэж байсан. Бүтэн 12, 15 сар хүлээлгэж байгаад тендер авсан чинь асар өндөр үнийн дүнтэй тендер ирсэн. Ингээд аргаа барахдаа бид Ерөнхий сайдад хандсан. Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Модид хандаж танайхаас ирсэн зээлийн шугам дагуу тендер зарлахад ийм өндөр үнийн дүнтэй санал ирлээ. Нэгэн дээр нь л гэхэд бүхэл бүтэн зээлийн ерөнхий хэлэлцээрийн дүнтэй тэнцүү юм байна, яах вэ гээд.

Энэтхэгийн Ерөнхий сайд Нарендра Моду шуурхай арга хэмжээ авч Энэтхэгийн Сангийн Яам, Гадаад хэргийн яам, манай төслийн менежментийн зөвлөхийн удирдлагуудыг явуулаад бид цоо шинээр Энэтхэгийн Засгийн газарт хүсэлт гаргасан. Энэ нь юу вэ гэвэл эхний тендерээ цуцалъя, өрсөлдөөнийг бий болгох нөхцөл зааж өгөөч гэж. Мөн зөвхөн Энэтхэг компани биш, бусад улсын компанийг оруулах боломжийг бий болгох, Энэтхэгээс авах бараа, ажил, үйлчилгээний хэмжээг бууруулж Хятадаас, Оросоос, Монголоос авах боломжийг бий болгож өгөх, хөнгөлөлттэй зээлийнхээ журамд техникийн зарим өөрчлөлт оруулж өгөөч гэдэг асуудал тавьсан.

Эдгээр асуудлыг бүгдийг Энэтхэгийн тал 7 хоногийн дотор хуралдаж зөвшөөрсөн. Ингээд бид дахин тендер зарлахад энд улаанаар тэмдэглэсэн тоо болох ЕРС-2-ын тендерийг харвал нэг компани 1 тэрбум 264 сая ам.долларын санал өгч байсан. Биднийг шоконд оруулсан юм бол энэ. Хамгийн багадаа л 736. Бидний 598-аар хийчихсэн байгаа гэрээ шүү дээ. Ингээд түргэвчилсэн тендер зарлахад хамгийн багадаа 675, хамгийн ихдээ 900, 895 орчим. Тэгээд бид энэ үнийг нээсэн. Ямар ч байсан эхнийхийгээ бодвол бас доошилж ирсэн.

3 дугаар багц ажил буюу цахилгаан станц дээр нэг ч компани орохгүй байж байгаад төрийн өмчит энэ компани 7 удаа хойшлуулж байгаад тендерт үнийн санал ирүүлэхдээ 380.0 сая ирүүлж байгаа юм. Үүнийг нь дахиж дээд талынх шигээ цуцалж хаяж байгаад дахиж зарлахад ингээд 225.0 сая, яахав өрсөлдөөн шиг юм бий болж 780.0 сая байснаа 225.0 сая гэдэг тоо бид авсан. Ингээд тэр хоёр багц ажил дээр хоёуланд нь хамгийн бага үнийн санал авсан компани бол одоо энэ 2, 3 дугаар багц ажлыг хийж байгаа Энэтхэгийн Megha Engineering and Infrastructure гэж компани байгаа. Энэ компанийн бизнесийнх нь дарга нар, эзнийг нь хүртэл Монголд урьж авчраад үнэ бууруулах хэлэлцээ хийсэн. Танайх нэгэн дээр нь хамгийн бага буюу 675.0 сая, нөгөөдөх дээр нь хамгийн бага буюу 215.0 сая, нийт 900.0 сая ам.долларын ажлыг манайд хийе гэжээ. Энийгээ хэлэлцье гээд. Бид маш хүнд хэлэлцээрт орж техникийн болон эрх зүй талаас нь Монголын төр засгийн анхаарлын төвд байгаа, бүх талын дэмжлэгтэй ийм төсөл энэ тэр гэж байж 788.0 сая ам.доллар болгож бууруулсан. Өөрөөр хэлбэл, 2, 3 дугаар багц ажлын тендерт ирсэн саналыг нийтдээ 111.4 сая ам.доллараар бууруулсан юм шүү. Нийт бүх лиценз эзэмшигч ЕРС-1 дүгээр гэрээ бүгд дээр бид 164.5 сая ам.доллараар үнийн дүн бууруулсан байдаг. Бид үүнийг ярьж байгаагүй, өнөөдөр та бүхэнтэй ам нээвэл уушги нээж бүх зовлон, жаргалаа ярья гэж бодсон юм.

Инженерчлэлийн үе шатанд хийсэн оновчлолуудыг товчхон хэлье. Жишээ нь, хамгийн анх монголын туслан гүйцэтгэгчээр ТЭЗҮ-ийн үед ажилласан компани манай цэвэр усны нөөцийн савыг газар дээр төлөвлөчихсөн, үүнийг нь хүлээгээд авчихсан. Тэгтэл энэ стратегийн объектын усны сав яагаад ч газар дээр байж болохгүй. Тиймээс газар доор оруулахад л 8-10 сая ам.долларын зөрүү гарах жишээтэй.

Дээрээс нь онгоцны түлшийг 40.0 мянга байснаа манай шинэ онгоцны буудал бий болсонтой холбоотойгоор бид бас Монгол Улсыг Азийн нислэгийн

ХАБ болоосой гэж бодож 80.0 мянган тонн олон улсын стандартын JET A1 түлш үйлдвэрлэе гэж шийдсэн. Шингэрүүлсэн шатдаг хийг пропан, бутан нь ялгагдаг байгууламж хийе гэсэн. Манай зах зээл дээр процентоор хольдог учраас манайд ялгагдаг газар байдаггүй.

Цахилгаан станцын хүчин чадлыг нэмсэн. Хамгийн гол нь энэ байгаа 40-өөд агуулах савыг анхнаасаа бүгдийг нь зөвхөн 1 хөвөгч дээвэртэй төлөвлөсөн байсныг Дорноговийн салхи, шуурга, говийн цаг агаарын сүүлийн 80 жилийн дунджид үндэслэн зайлшгүй давхар дээвэр хийх хэрэгтэй болсон. Өөрөөр хэлбэл, бүх сав маань дотроо хөвөгч, гаднаа фикс буюу хатуу хучилттай гэсэн хоёр дээвэртэй болгосон нь эдэлгээнд маш их хэрэгтэй байсан юм. Шингэрүүлсэн шатдаг бөмбөрцөг байсан. Аюулгүй ажиллагааг дээд зэргээр хангахын тулд орчин үеийн хэвтээ, далд булагдсан ийм сав сонгосон. Жишээ нь, цахилгаан станц дээр гэхэд цахилгаан станцын үнс баригчийг зайлшгүй хийх хэрэгтэй, энэ бол том тоноглол юм. DeNOx (утаан дахь NOx-ийг азот (N<sub>2</sub>) + ус (H<sub>2</sub>O) болгон хувиргадаг) гэж заавал байх ёстой, аммиак хадгалах сав. Монголын цаг агаар, байгаль орчны онцлог шалтгаан болон элэгдэл, хорогдол зэргийг бүгдийг тооцож сайжруулсан юм.

Бензиний гарцыг 340 байсныг 399 болгон 400 руу ойртуулсан. Энэ хооронд бензиний хомсдол гарсан. Тэгэхээр монголын газрын тосыг яаж максимум бензин гаргадаг болгох вэ? Манай тос өөрөө бензин бага гардаг шинж чанартай, сайн чанарын их дизель гардаг. Бензин боловсруулдаг 3 байгууламж байдаг. Нафта гидротехник (Naphtha Hydrotreating), изомержуулалт (Isomerization), риформинг (Catalytic Reforming) гээд 95 октантай евро 5 стандартын бензин үйлдвэрлэхэд заавал энэ юунуудыг тавих юм. Эдгээрийг тавихад бүгдийнх нь хүчин чадал нь өссөн. Ингээд яриад байвал яриад байна. Ийм маягаар инженерийн үе шатанд өөрчлөлтүүд хийсэн.

Дамжуулах хоолойн төсөл сайн явж байгаа. Энэ төслийг Хятадын компани EPC контрактаар нь ажилладаг. Хятадын Norinco International Cooperation гэж компанийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас шалгаруулсан. 530-ийг барина шүү дээ. 5 янзын давхар хяналттай явдаг. Жишээ нь, зураг төслийг нь Канадын Worley Parsons компани, хяналтыг нь манай өмнөөс Италийн Prometheus компани, Хятадын талаас Sinopac компани гүйцэтгэж байна. Манай компани өдөр тутмын хяналтыг хэрэгжүүлдэг. Барилгын хөгжлийн төв Тавантолгойд тусалж байгаа. Техникийн хяналтын асуудлыг бид маш их ярьж байгаа. Германы компани болон Монголын Армор компани үл эвдэх сорилын 3 янзын тест, радиограф, магнитометр, ультра саундын тестүүд хийдэг.

Манай газрын тосны хайгуулын талбай байна. Үүнийг Улсын Их Хурал, Засгийн газар дэмжиж ирсэн. Манай компани цаашдаа өөрийн гэсэн газрын тосны түүхий эдийн түшиц газартай болохыг хүсдэг. Ерөнхийдөө тос олоод яваад байгаа. Хөрөнгө оруулагчид манайд орж ирэх үнэхээр дургүй байна.

Газрын тосны үйлдвэрийн хотхон уг нь нийгэм, эдийн засгийн өндөр ач холбогдолтой төсөл. Харамсалтай нь нэг хэсгийг нь Батлан хамгаалах яамыг

хариуц гээд өгчихсөн, та бүхний харж байгаа баруун талд байгаа нь манай компанийн өөрсдөө шууд гэрээлсэн энэ юунууд баригдаад, бид гэрээ хэлэлцээр хийхдээ гүйцэтгэгч компаниудыг инженерүүдээ манай энд ийм үнээр байлга гэдэг. Ингэсний хүчинд зочид буудлынхаа мөнгийг бууруулаад, хөрөнгө оруулалтын зардалд сайнаар нөлөөлдөг байхгүй юу.

Шийдвэрлэх шаардлагатай асуудал энэ тэрийг ярихаа больё. Ер нь газрын тосны үйлдвэр гэдэг бол, ямар ч улс хөгжье л гэж бодвол, өөрийн тосгүй Сингапур, Япон, Солонгос бүгдээрээ хамгийн түрүүнд газрын тосны үйлдвэрээ барьж авдаг юм байна лээ. Өнөөгийн аж үйлдвэрийн хөгжих цөм нь газрын тос боловсруулах үйлдвэр. Түлш шатахууныг төр засаг нь өөрөө захиран зарцуулах боломж байж байна. Энэ бол гадаадын бие даасан байдалд хэрэгтэй, улсын төсөвт дорвитой хувь нэмэр оруулна. Үйлдвэр бүрэн хүчин чадлаараа ажиллахад борлуулалтын орлого нь дунджаас жоохон доогуур бодоход 4.5 их наяд. Хамгийн гол нь түүхий тосны үнэ зардалд хамгийн том жин дардаг. Манай улсын төсөвт асар өндөр хувь нэмрээ оруулна. Валютын урсгалыг бууруулна, ажлын байр өнөө хэр нь зөндөө олдсон байж байна. Бид үйлдвэрээ барьчих юм бол монголын ард түмэндээ, залуучууддаа, бас төр засагтаа итгэх итгэл, ирээдүйдээ итгэл өгөх нь хамгийн том ач холбогдол юм байна гэж харж байгаа. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Д.Алтанцэцэг даргад баярлалаа. Улсын Их Хурлын гишүүний асуултад 5-аас илүүгүй хугацаанд албан тушаалтан хариулна. Монголын ард түмэнд маш санаа зовниж байгаа зүйл учраас хугацааг нь жоохон сунгаж 15 минут ярилаа. Асуултад хариулна гэхээсээ илүү миний ойлголтоор төслөө танилцуулах шиг боллоо. Асуултуудад яг тодорхой хариулъя.

Горимын нэг санал гарсан. Энд их мөнгөний тухай, том том, чухал асуудлууд ярьж байгаа учраас хаалттай хэлэлцүүлэх горимын саналын дагуу санал хураалт явуулъя. Горимын санал хураахын өмнө Л.Мөнхбаясгалан гишүүн тайлбар хэлье.

**Л.Мөнхбаясгалан:** Энэ газрын тос боловсруулах үйлдвэрийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавьсан гишүүний хувиар, мөн энэ үйлдвэр манай тойрогт баригдаж байгаа Оюу Толгойн бараг дараа орох том төсөл учраас тайлбар хэлье гэж бодож байна.

Нэгэнт авсан зээлүүд нээлттэй байгаа мэдээлэл. Одоо 431 сая ам.долларын зээл авахаар оруулж ирж байгаа. Үүнийг бид, бид нарын үр хүүхэд төлнө, Монгол Улс төлнө. Тэгэхээр энэ улсын нууц биш юм чинь хаалттай хэлэлцэх шаардлага байхгүй гэж бодож байна. Гишүүдийг нээлттэй хэлэлцэхийг дэмжиж өгөөч гэж хүсэж байна.

**С.Ганбаатар:** Горимын саналтай холбогдуулж Л.Мөнхбаясгалан гишүүн байр сууриа илэрхийллээ. Горимын санал нэгэнт гарсан учраас санал хураах ёстой. Газрын тосны асуудлыг хаалттай хэлэлцэх горимын саналыг дэмжиж байгаа гишүүд кнопоо дарна уу. Санал хураалт. Санал 100 хувиар дэмжигдээгүй тул нээлттэй хэлэлцье.

Төслийн талаарх мэдээллийг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК-ийн Гүйцэтгэх захирал Дашдаваагийн Алтанцэцэг танилцуулсан. Өнөөдөр Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Газрын тосны бодлогын газрын дарга Б.Анхбаяр, Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Ч.Хишигдалай нар ирсэн. Монголын ард түмнийг төлөөлж, хяналт тавьж, мэргэжил арга зүйн хувьд тусалж, дэмжиж, хамтарч ажиллаж байгаа яамдын төлөөллүүд ирсэн учраас танилцуулах нь зөв байх. Д.Алтанцэцэг захиралд баярлалаа.

Асуултын хариулттай холбогдуулан асуулт асууж, үг хэлэх гишүүд нэрээ өгнө үү. Х.Жангабыл гишүүнээр тасаллаа. П.Мөнхтулга гишүүн асуултаа асууна уу.

**П.Мөнхтулга:** Бүгдэд нь энэ өдрийн мэндийг хүргэе. Энэ төсөл, зээлийн бусад санхүүжилтийн асуудлыг Л.Мөнхбаясгалан гишүүн сүүлд нь асуух байх.

Миний хувьд энэ яг хэзээ ашиглалтад орж, хэзээнээс бүтээгдэхүүнүүд нь үйлдвэрлэгдэж эхлэх вэ? Шинэ технологийн горимууд нэвтрүүлж байгаа гэж байна. Энэ дээр манай улс төдөн тонн түлш, АИ95, АИ92, АИ98, онгоцны бензин хэрэглэдэг, харин манай үйлдвэр ашиглалтад орсноор АИ92, АИ95-ын, дизель түлшний, онгоцны түлшний төдөн хувийг манайх дотоодоосоо хангадаг болох юм гэдэг статистик тоог хэлж өгөөч.

ТӨХХК гэж явж байгаа юм байна. Тэгэхээр 100 хувь манай төрийн өмчит байгаа юу? ТӨҮГ-ууд их авлигажаад байна, менежмент их муу байна, ер нь төр менежментийг сайн хийдэггүй гэдэг жишээг дэлхий даяараа харж байгаа. Тэгэхээр энийг олон нийтийн нээлттэй компани болгох тал дээр, цаашдаа үр хүүхдүүддээ үлдээе гэх юм бол төрийн оролцоог илүү багасгах л ёстой. Тийм болохоор ХХК хэлбэр нь хувьцаа эзэмшилд нь яаж явж байгаа вэ? гэсэн асуултууд байна.

**С.Ганбаатар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** П.Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. Үйлдвэр хэзээ ашиглалтад орох нь ЕРС-4-ийн гэрээг хэзээ байгуулж чадах вэ гэдгээс хамаарна. Гэрээ хийлээ, түүнээс хойш 36 сар. Тийм учраас зээлийн дүнг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдүүлэх гэдэг төсөл хэрэгжүүлэгч компанийн хувьд маш чухал байна. Хоёр улсын төр засгаас хамааралтай. Энэтхэгийн Засгийн газраас тун удахгүй хариу ирнэ гээд хүлээлгэж байгаа. Энэ жил Энэтхэг, Монголд хоёуланд нь улс төрийн сонгуулийн жил таарлаа. Бид 12 сард ЕРС-4-ийнхөө гэрээг байгуулж чадвал 2027 оны 12 сард. Бүтээгдэхүүний талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамнаас Ч.Хишигдалай хариулах байх.

Шинэ технологи гэж байна. Энэ үйлдвэр бүх шатандаа, өөрөөр хэлбэл зураг төслөөсөө эхлээд үйлдвэрийн барилга байгууламж, тоног төхөөрөмж, автоматжуулалт гээд өдөр тутмын ажиллагаа хүртэл “state of the art” буюу бүх юм шинэ технологид суурилж хийж байгаа. Бүх юм нь автомат системийн, автомат удирдлагуудтай. Нарийвчилж, ямар системүүд явагдаж байгаа гэдэг дээр манай автоматжуулалт, тоноглолын инженерүүд танилцуулга өгч болно.

Манай компани 100 хувь ТӨХХК. Би өөрөө эдийн засагч, инженер хүн. Төр муу менежер гэж зарим талаар ярьдаг боловч зарим талаар бас тийм ч үнэн биш. Дэлхийн сүүлийн үеийн гол тенденц хандлага юу байв гэхээр стратегийн чухал ач холбогдолтой газрын тос, байгалийн хийн ордоос өгсүүлээд үйлдвэрүүдээ национальчлах, энэ нь 1990-ээд оноос хойш хамгийн анх 1971 онд ОПЕК-аас эхтэй. 1990 оноос хойш та бүхэн судлаад үзвэл дэлхий дээр газрын тосны орд болоод үйлдвэрүүдийн 80 хувь нь төрийн өмчит компаниуд байгаа. Төрд хэнийг ажиллуулах нь Засгийн газар, төрийн томилгоо. Бид үнэнч шударгаар ажилладаг, өөрсдийгөө муу менежер гэж хэлэхгүй. Үйлдвэрийн бүтээгдэхүүнийг газрын тосны зах зээлийн судалгаанд суурилж хийдэг. Манай зах зээлийн шатахууны зах зээлийн хэрэглээний 65 орчим хувь нь дизель байдаг. Тэгэхээр манай үйлдвэрийн концепц юу вэ гэвэл ийм физик, химийн шинж чанартай 1.5 сая тонн түүхий тосыг 65 хувь нь дизель, тэдэн хувь нь бензин, тэдэн хувь нь шингэрүүлэн шатдаг хий болгохын тулд ямар үйлдвэрийн концепц зохиох вэ? Үүгээр бол конфигурац (configuration) явагдаж байгаа. Тэгэхдээ өнөөдөр хүмүүс манай үйлдвэрийн бүтээгдэхүүнийг нийт.../минут дуусав./

**С.Ганбаатар:** Д.Алтанцэцэг дарга маш тодорхой асуулт асуусан, тодорхой хариулбал сайн шүү. Оюу Толгойн гэрээ ярьж байхад их ерөнхий ярина, дандаа гадаад нэр томьёо хэлнэ, маш том луйвар болсон. Газрын тосны асуудлаар маш тодорхой, чухал зүйл ярьж байгаа учраас улам тодорхой болговол сайн гэсэн санаа хэлж байгаа юм шүү. Тодруулж, нэмж хариулах уу? Товчхон хариулбал сайн байна. Ерөнхий тойроод яриад байвал яг асуудал дээрээ худлаа байна гэсэн үг.

**Ч.Хишигдалай:** Газрын тос боловсруулах үйлдвэрийн үйлдвэрлэх түүхий эдийг нэг бүрчлэн, хувиар тодорхой танилцуулъя. Газрын тос боловсруулах үйлдвэр маань 80 мянган тонн онгоцны түлш үйлдвэрлэнэ. Өнөөдрийн Монгол Улсын хэрэглээ бол 60 мянган тонн орчим байна. Үйлдвэр ашиглалтад орох хугацаанд өсөн нэмэгдэхийг тооцоод 80 мянган тонн түлш тухайн үеийн хэрэгцээг 100 хувь хангана. АИ92 авто бензин бол 390 мянган тонныг, АИ95 бензин 400 мянган тонн орчим үйлдвэрлэнэ. Өнөөдрийн Монгол Улсын хэрэглээ бол жилийн 720 мянган тонн байна. Үүний 55 хувийг дотоодоосоо хангана.

Дизель түлшний хэрэглээ жилийн 1 сая 300 мянган тонн, манай үйлдвэр 825 мянган тонн орчмыг үйлдвэрлэнэ. Дотоодын нийт хэрэгцээний 65 хувийг дотоодоосоо хангана. Шингэрүүлсэн шатдаг хийн хэрэглээ бол.../минут дуусав./

**С.Ганбаатар:** 5 дугаар микрофонд минут нэмж өгье. Чухал асуудлын талаарх тоонууд ярьж байна.

**Ч.Хишигдалай:** Шингэрүүлсэн шатдаг хийн өнөөдрийн хэрэглээ 40 мянга орчим тонн байна. Үйлдвэр 40 мянган тонн шингэрүүлсэн шатдаг хий LPG үйлдвэрлэх учраас 100 хувь хангана.

**С.Ганбаатар:** Гишүүний тодруулга асуулт бол саяын ярьсан үр дүнгүүдээс харахад хангалттай нөөц бэлэн байгаа гэж ойлгож болох уу гэсэн.

**Ч.Хишигдалай:** Монгол Улсын газрын тосны баталгаат нөөц 300 гаран сая тонн байдаг. Үүний ашиглалтын баталгаат нөөц 43.7 сая тонн. Үүнээс 10 сая орчим тонныг нь олборлоод, экспортолчихсон байна. Үйлдвэр ашиглалтад орох хугацаанд тодорхой талбайнууд дээр нэмэлт газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулаад хайгуулын ажлууд хийгдэнэ. Мөн одоо олборлолт явуулж байгаа талбайнууд дээр олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх янз бүрийн технологийн аргуудыг хэрэглэнэ. Үйлдвэр ашиглалтад ороход 100 хувь түүхий эдээр хангахаар хүчин чармайлт гаргаад, бодлогын хэмжээнд дэмжиж ажиллаж байгаа. Нөөц бол байна гэсэн үг.

**С.Ганбаатар:** П.Мөнхтулга гишүүн тодруулъя.

**П.Мөнхтулга:** Албан ёсны хүмүүсээс нь асуугаад байгаа юм. Надад ирсэн мэдээллээр бол энэ үйлдвэрийг хүчин чадлаараа ажиллахад хангалттай түүхий эд байхгүй л гээд байгаа юм. Тэгэхээр протоколд үлдэж байгаа учраас, үндэсний хэмжээнд 50, 55, 65 хувийн дотоодын хэрэгцээг хангах хэмжээний үйлдвэр баригдаж байгаа ч гэсэн хангах түүхий эд нь бодлогын түвшинд бэлэн болсон юм уу, гэрээ хэлэлцээрүүд нь хийгдсэн юм уу, ямар ямар уурхайгаас? Тэр ЕРС-3 дээр мега компанийн хоолой татаж байгаа юм байна. Энэ хоолой чинь Тамсаг-аас татаж байгаа гэж ойлгож болох уу? Хүрэлцээтэй юу, хэдэн эх үүсвэртэй вэ, энэ эх үүсвэрүүд резервтэй юу? Аль нэг.../минут дуусав./

**С.Ганбаатар:** С.Жавхланбаатар дарга хариулна уу, 1 дүгээр микрофон нээе.

**С.Жавхланбаатар:** П.Мөнхтулга гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Монгол Улс 4 талбайгаас олборлож байна. Сая сүүлийн 4 дэх нь монгол хөрөнгө оруулалттай газрын тосны цооног нээгдсэн. Энэ 4 талбайн нөөц нийлээд 4 сая орчим байгаа. Петрочайнагийн иргэний хөдөлгөөний асуудлуудаас болоод өнгөрсөн жилээс олборлолт нь түр багассан байгаа. Ер нь жилийн дундаж олборлолт 4 сая гаруй баррель буюу 500 гаруй мянган тонныг олборлож, экспортолдог байсан. Энэ жил одоогийн гүйцэтгэлээр 10 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 460 орчим мянган тонныг олборлож, экспортолсон. Газрын тосны үйлдвэр маань 1 сая 500 мянган тонн хэрэгцээ байгаа. Технологийн хувьд өнөөдрийн олборлож, ашиглаж байгаа 4 цооногоо нэмэгдүүлээд үүнийг бүрэн хангах боломжтой. Гэхдээ нэмээд бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 14 хайгуулын гэрээ Засгийн газар байгуулсан байгаа. Бусад компаниуд дээр хайгуул хийгдэж байгаа гэсэн үг. Хайгуулаар тогтоогдсон нөөцүүдээр ирээдүйд газрын тосны үйлдвэрийн түүхий эдийг хангах бодлого явагдаж байгаа.

**С.Ганбаатар:** Хурал даргалагчийн хувиар би гишүүний асуултыг тодруулаад асууя. Түрүүн Ч.Хишигдалай дарга хариулсан. Нөөц 100 хувь хангалттай биш гэж ойлгоод байна. Яагаад гэвэл хайгуул хийж байгаа, технологийн шийдэл хайж байгаа гэж ярилаа. С.Жавхланбаатар дарга 4 сая тонн гарахаар болчихсон гэж байна. Монгол газрын тосны үйлдвэрийг боловсруулах үйлдвэрт нийлүүлж болно гэсэн. Энэ болно гэдэг чинь бас болохгүй гэсэн утга агуулга байдаг л даа. Тэгэхлээр яг таг гэрээ хийчихсэн юм уу, нийлүүлнэ гэж

байгаа юм уу? Тэр дотор чинь бас хувийн компаниуд байгаа. Тэгэхээр энэ болгон дээр гэрээгээ нарийвчилж хийсэн үү гэсэн гишүүний асуултад тодорхой хариулбал сайн байна. 5 номер.

**Ч.Хишигдалай:** Газрын тосны тухай хуульд Монгол Улсад олборлолтын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж дотоодын газрын тос боловсруулах үйлдвэр байгуулсан тохиолдолд нэн тэргүүнд бүтээгдэхүүнээ зах зээлийн үнээр нийлүүлнэ гэсэн хуулийн заалттай. 2012 онд батлагдсан хууль.

Хоёрдугаарт, Петрочайна Дачин Тамсаг компанийн олборлолтын орд ашиглалтын төлөвлөгөөн дээр тулгуурлаж боловсруулах үйлдвэрийг барих ажил эхэлсэн. Орд ашиглалтын төлөвлөгөөгөөр бол 1 сая 500 мянган тонныг тогтвортой 8 жил олборлоно гэсэн байгаа.

Гуравдугаарт, Монгол Улсын ашиглалтын баталгаат нөөц өнөөдрийн байдлаар 33.5 сая тонн байна. 33.5 сая тонн гэдэг бол боловсруулах үйлдвэрийг 20 орчим жил хангах боломжтой гэсэн үг. Өөрөөр хэлбэл, өнөөдөр ашиглалтад шилжээд буй ордууд 33.5 сая тонн ашиглалтын баталгаат нөөцтэй. Энэ дээр өөр газрын тос илэрсэн тодорхой.../минут дуусав./

**С.Ганбаатар:** Манай газрын тосны үйлдвэр түүхий эдээр огт тасрахгүй гэдэг талаар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Газрын тосны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ч.Хишигдалай нар хариуллаа.

Одоо Г.Лувсанжамц гишүүн асуултаа асууна.

**Г.Лувсанжамц:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Инженер хүний хувьд та бүхний зовлон, жаргалыг ойлгож байна. Ийм том төслийг хэрэгжүүлэхэд яалт ч үгүй сунаад байдаг. Ялангуяа ийм том үйлдвэрүүд болохоор багц багцаараа явахаар хэцүү болдог. Тэрийг маш сайн ойлгож байгаа.

Нэгдүгээрт нь горимын санал байна. “Engineers India Limited” компанийг ерөнхий зөвлөх үйлчилгээний компаниар шалгаруулаад явж байгаа юм байна. Тэднийхийг бас дуудмаар байна. Нэгэнт зөвлөх үйлчилгээнийхээ ажлыг хийлгэж байгаа юм чинь хамгийн нарийн юмыг нь мэдэж байгаа нь тэр хүмүүс байх ёстой болов уу гэж бодож байна. Угаасаа олон улсын том төсөл, хөтөлбөрүүдийг хэлэлцэж байхад ирэх ёстой байдаг. Та бүхэн мэдэж байгаа. Дараа заавал тэдний хүмүүсийг дуудаж авчраарай.

Хоёрдугаарт, энэ аудитын дүгнэлтийг харахад манай Батлан хамгаалах яам ажлаа хийнэ гэхихээд хийхгүй алга болчихсон юм байна, тиймээ? Тэгэхээр төрийн байгууллага юм чинь цугт нь дуудаад, асууж тодруулаад цаашид хийх үгүйг тодорхой болгож асуумаар байна.

Асуултаа орьё. “Engineers India Limited” компанитай хийсэн гэрээний маягт нь бас FIDIC үү? Ямар гэрээний маягтаар хийсэн бэ? EPC-1, 2, 3, 4 бол Silver Book-ээр хийсэн юм байна тиймээ? Тэрийг ойлголоо.

Хоёрдугаарт, энэ танилцуулгаар үйл ажиллагааны, бүтээн байгуулалтын ажлын явц л танилцууллаа. Бизнес төлөвлөгөө хармаар байна. Хэзээнээс, сая ярьсан EPC-4 гэрээ хийгдэх юм бол 2027 оноос үйл ажиллагаа эхэлнэ, боловсруулж эхэлнэ гэсэн. Жилдээ тэдэн тонн дизель, хийн, онгоцны түлш энэ тэр хийнэ гэж байна. Хэдийг үйлдвэрлээд, хэдээр борлуулаад, ямар хэмжээний ашигтай ажил хийх юм. Тийм бизнес төлөвлөгөө бид нар мэдэхгүй бол энд юу ч хэлээд тодорхойгүй л байгаад байна. Хэзээнээс ер нь ашигтай ажиллаж эхлэх юм. Нөөц нь тэдэн тонн байгаад, тэдэн тонныг боловсруулбал ашигтай ажиллаж эхэлнэ гэсэн хугарлын цэг байх ёстой шүү дээ. Ийм бизнес төлөвлөгөөний тоо хармаар байна.

Гурав дахь асуулт, танай компани болон яам хоёулангаас нь асууя. Хүний нөөцийн тухайд FIDIC-ийн гэрээний маягыг ашиглаж байсан туршлагатай хуульч танайд хэд байна вэ?

Хоёрдугаарт, Project Management Professional буюу олон улсад ийм төслүүдийн менежментийг авч явдаг зэрэг байдаг. Тийм төслийн менежментийн зэрэг эзэмшсэн хэдэн жилийн туршлагатай, хэдэн хүн байна вэ? Хэрвээ байхгүй бол энийг, хүний нөөцийг хангах талаас нь хийгээд явах хэрэгтэй. Хэрвээ тийм туршлагатай хүн байх юм бол FIDIC-ийнхээ гэрээний дагуу ямар нэгэн байдлаар доголдол үүсвэл шууд “notice” гээд л явуулчихдаг шүү дээ. 2 долоо хоногийн, 1 сарын хугацаатай гээд. Тэрийгээ хийгээд явах боломжтой болохоор тэр зүйлүүд дээр нь асуулж байна. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Хариулт 4 номерын микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Ер нь төслийн менежментийн зөвлөхийг Улсын Их Хурлын гишүүдийн асуулга энэ тэрд оролцуулж байх нь зүйтэй юм байна гэдэг дээр саналаа хэлсэн. Танд баярлалаа. Бид бас тэгж бодож байна.

Батлан хамгаалах яам ажлаа хийх юм уу, хийхгүй юм уу. Туслан гүйцэтгэгчийнхээ аманд орчихоод л 2021 оноос хойш ажлаа хийхгүй ингээд байж байгаа. Хичнээн яриад бидний эрх мэдэл хүрэхгүй ийм байдалтай байгаа учраас Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо анхаарал хандуулж өгөөрэй.

Бизнес төлөвлөгөөгөө одоо харуулъя. Манай PMC гэрээ, FIDIC биш. PMC гэрээ бол олон улсын төслийн менежментийн зөвлөх project management consultancy гэрээний загвараар хийгдсэн. Инженер Ти Эн Ти өөрийнхөө 65 жилийн хугацаанд 100-гаад төсөл дээр PMC хийж байсан юм байна. Тэдний гэрээний маягт дээр манайх ажиллаад, энэ үнэ гэрээг байгуулахдаа монголдоо тендер зарлаж хуулийн зөвлөхүүд ажиллуулсан.

EPC гэрээ гэдгийг монголчууд бас сайн мэддэггүй гэрээ байж. Engineering, procurement, and construction гэж гэрээг одоогоос 5-7 жилийн өмнөхийг бодоход харьцангуй хүмүүс мэддэг болсон байна. Үүнийг бид бүгдээрээ л анхнаас нь суралцсан. Манай гэрээ, эрх зүйн газар бол 9 хүнтэй. Бүгд FIDIC гэрээн дээр сургалт авсан, мэдээж бие биедээ заасан, нэгийн зэрэг сайн мэддэг хүн байсан. EPC-1, 2, 3, 4 болгон дээрээ 1, 1 хариуцсан гэрээний мэргэжилтэнтэй.

Бидний хувьд түрүүлж ийм гэрээтэй харьцаж эхэлсэн хүмүүс юм шиг байгаа юм. Алдаа, оноо зөндөө гарах байх мэдээж. Баярлалаа.

Бид cashflow үзүүлэх гэсэн яг одоо боломжгүй юм байна. Танд хүргүүлчих үү? Ер нь үйлдвэрийн эдийн засгийн тооцоо, cashflow, эргэн төлөлтийн талаар гишүүдэд дахин танилцуулга хийж болно.

**С.Ганбаатар:** Г.Лувсанжамц гишүүн тодруулъя.

**Г.Лувсанжамц:** Баярлалаа, нарийн мэдээллүүдийг хүлээж байя. Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо бас авахаар ажиллаарай. Протокол дээр дараагийн хуралдаанд “Engineers India Limited” компаниас, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Батлан хамгаалах яамнаас хариуцаж байгаа хүмүүсийг нь заавал оролцуулахыг тэмдэглүүлж байна. Project Management Professional гэдэг дээр тоог нь дараа ирүүлнэ гэж ойлголоо. Та бүхэнд амжилт хүсье.

**С.Ганбаатар:** EPC, PMC, cashflow талаарх мэдээллийг дараа явуулахаар болж байгаа юм байна. Монголчууд ойлгохгүй гэж бодож болохгүй, үүнийг тайлбарлах ёстой байх шүү.

Одоо Ж.Золжаргал гишүүн асуулт асууна.

**Ж.Золжаргал:** Тоо, техниктэй холбоотой асуулт асууя. Цахилгаан станц нэрлэгийн үлдэгдлээр түлш хийж ажиллана тиймээ? Хэрвээ хүчин чадал багатай, эсвэл түүхий эд нь өөрчлөгдөөд, эсвэл түүхий эд нь багасвал цахилгаан станцын түлшний асуудал босож ирэх үү, үгүй юу? Тэр тохиолдолд хүчин чадал нь төсөлдөө яг тааруулаад тооцчихсон байгаа юу? Өөр түлш байхгүй гэж ойлгож байгаа.

Хоёрдугаарт, түүхий эд түрүүн яригдаад өнгөрлөө. Миний ойлгож байгаагаар монголын газрын тосонд тулгуурлаж дизайн хийгдсэн. Гэхдээ ус төрөгчийн боловсруулалттай учраас түүхий эдтэй харьцангуй уян хатан гэж бодож байгаа. Тэгэхээр одоо олборлож байгаа Петрочайнагаас өөр, жишээ нь, сая Петро Матад ХХК-ийн гаргасан тосыг ашиглавал ямар байх зэргээр түүхий эдийн иймэрхүү хувилбаруудыг хэр тооцсон бэ? Цаашдаа өөр эх үүсвэр нэмэгдвэл авч ашиглах дизайны үндэслэлүүд байгаа юу?

Гуравдугаарт, EPC-2, EPC-3 дуусаагүй байгаа. Саяын мэдээлэл дээрээс харахад ер нь яагаа ч үгүй байгаа юм байна. EPC-4 бол сүүлийнх нь. EPC-2 дээр технологийн нэлээн хэдэн хэсгүүд байна. Агуулахаас бусад нь баригдаагүй гэж ойлгосон. 19 хувийн гүйцэтгэлтэй. Тэгэхээр EPC-4 байгуулагдахаас гадна энэ EPC 2, 3 нь хэзээ дуусах вэ? Гүйцэтгэлийг нь харахаар дэд бүтэц, барилга байшин энэ тэр хийгдчихээд яг технологийн тоног төхөөрөмжүүд угсрагдахгүй байгаад байх юм. Тэр нь хурдан тавигдаад эхлээсэй. Тэгвэл санаа зовохгүй явах юм байна гэж харах гээд байгаа юм. Тэгэхээр энэ EPC-2, 3 хэзээ хийгдэх бол? Төслийн талбай дээр тоног төхөөрөмжүүд буугаад, зарим ажил нь хийгээд эхлэхээр харуул хамгаалалт, хэн өмчилж, эзэмших вэ гэсэн асуудлууд байгаа гэж

түрүүний ярианаас ойлголоо. “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХХК өөрөө төсөл хэрэгжүүлэгч биш, ашиглалтын өмнөх захиргаагаа авч яваад, дараа нь үйл ажиллагаа хариуцах юм байна гэж бодсон. Тэгэхээр энэ ойлголт зөв үү, буруу юу?

Нэмээд нэг асуулт, Энэтхэг тал нь гүйцэтгэгчээ, дэд гүйцэтгэгчээ шалгаруулаад явж байгаа байх. Манай талаас хяналтын ямар баг дэд гүйцэтгэгч дээр нь орж ажиллаж байгаа вэ? Баярлалаа.

**С.Ганбаатар:** Маш тодорхой, чухал асуулт асуулаа. 4 номерын микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Ж.Золжаргал гишүүний асуултад хариулъя. Цахилгаан станцын түлшний тухайд манай үйлдвэр 47.0 мянган тонн fuel oil буюу зуухны түлш үйлдвэрлэнэ. Энэ зуухны түлшний 60-аад хувийг бид станцдаа ашиглахад цаана нь нөөц 30 хувь буюу 17 мянган тонн түлш байгаа.

Хоёрдугаарт, түүхий эдийн уян хатан чанарын тухайд үйлдвэр ерөнхийдөө манай Тамсагийн сав газрын тосны шинж чанарт зориулж концепшл дизайн (conceptual design) хийгдсэн. Гэхдээ байгууламж тус бүр дээр уян хатан чанарын процент 10-20 хувь гээд тавигдсан байдаг. Ер нь устөрөгчийн үйлдвэртэй учраас уян хатан байх тал дээр гидрокрекин гэдэг тоног төхөөрөмж өөрөө технологийн уян хатан нөхцөлийг бий болгодог учраас бид сонгосон. Гэхдээ хэт их хүчэр агуулсан бол манай үйлдвэрт хэцүү. Яагаад гэвэл манай хүхрийн үйлдвэр 10 хувийн хүчин чадлын нөөцтэй. Түүнээс биш өөр өөр шинж чанар өгөгдлүүд, нягт, зууралданги чанар зэрэг юман дээр бид хүлцэх түвшин өндөртэй гэсэн үг. Тэгэхээр өөр төрлийн тос үйлдвэрлэж болох уу гэвэл болно. Гэхдээ зарим хэт их хүхрийн агуулгатай тосыг үйлдвэрлэхэд, боловсруулахад хүндрэлтэй.

ЕРС-2, 3 дуусаагүй байгаа тухайд Ж.Золжаргал гишүүнээ, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл гэдэг харилцан адилгүй хэр нь нэлээн их хугацаа шаарддаг хэсэг байна. Хамгийн их урт хугацаа шаарддаг нь инженерчлэл байдаг юм байна. Угсралтын хувьд хамгийн хүнд тоног төхөөрөмжийг 3 сард л угсарна. Зарим нь хэдхэн өдрөөс 2-3 долоо хоногт угсарна. Ихэнх үйлдвэрт цамхгууд, тэгээд компрессор, насос, шугам хоолойнууд байгаа. Шугам хоолойнууд хойтонгоос баригдаад эхэлнэ. Зарим насос, компрессор зэргийг 18 сар хүртэл хугацаанд үйлдвэрлэж, авчраад суурилуулахад 2 долоо хоног. Тэгэхээр тоног төхөөрөмж энд тэнд үйлдвэрлэгдээд эхэлчихсэн, талбай дээр бол харагдахгүй. ЕРС-2-ын ажил 2027 оны эхээр дуусах ёстой. 3 буюу цахилгаан станцын ажил бидний төлөвлөгөөгөөр 2026 оны сүүлээр дуусах ёстой. Гэхдээ манайх урьдчилгаа төлбөрийг Экзим банкнаас гэрээ байгуулснаас хойш жилийн дараа олгосон нэг ийм хүндрэл гарсан. Тэр утгаараа 4 сараар цаашаа сунах байх гэж бодож байна. Тэгэхээр 2026, 2027-нд энэ хоёр ажил дуусна. График төлөвлөгөө болон хоцрогдлыг арилгах төлөвлөгөө боловсруулаад ажиллаж байгаа.

Газрын тос боловсруулах үйлдвэр ашиглалтын өмнөх захиргаа гэж байна. Шинээр бий болсон өмч хөрөнгө.../минут дуусав./

**С.Ганбаатар:** Нэмээд микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Ашиглалтын өмнөх захиргаа гэдгийг бид анхандаа ярихгүй. Төрийн энэ өмчийг Төрийн өмч, Сангийн яам, Уул уурхайн яам гээд Засгийн газар хариуцаад явна гэж бодож байсан. Гэхдээ бид хэдэн сар хэлэлцэж, Засгийн газар хуралдсаны эцэст манай компани ашиглалтын өмнөх захиргааг өөрсдөө аваад явах нь зөв, тийм боломж байна гээд явж байгаа. Бидний чадахгүй байгаа ганцхан юм гэвэл үйлдвэрийн талбайгаас алслагдмал орших Бор хөөврийн говь гээд усны эх үүсвэр дээрх 11 худаг байгаа. Түүн рүү татсан усны шугам хоолой, цахилгаан, дулаан дамжуулах агаарын шугам энэ хэдийг л дотоодын цэрэг, худаг, усны талаарх хуулийн хүрээнд хараа хяналт тавьж өгөөч гэсэн хүсэлт тавиад, төсөвтөө суулгаж өгөөч гэсэн. Яагаад гэвэл эд нар зөвхөн төсөвт хамгаалалт хийнэ гэж байгаа юм.

Цахилгааны шугамыг болохоор Багануур Зүүн өмнөд бүсийн Цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-г хариуцаж хийж өгөөч гэсэн одоогоор нэлээн хэт их.../минут дуусав./

**С.Ганбаатар:** 4 номерт дахиад хугацаа нэмж өгье.

**Д.Алтанцэцэг:** Цаашид байгууламжууд баригдаад бий болоод байх учраас хамгаалалтын асуудалд төр засаг анхаараасай гэж хүсэж байна. Хулгай их гарч байна. Энэтхэг, Хятадын компаниудын ярьж байгаа юм хулгай л байна. Катодын хамгаалалт гээд хэдэн метр тутамд тавьдаг зэс утсыг хүртэл аваад явчхаж байна. Хойтон жил дамжуулах хоолой бүгд баригдана. Дамжуулах хоолойг дагасан цахилгаан эрчим хүчний 500км шугам баригдаж байна. Манай улс өөрийн өмчтэй болж байгаа болохоор харуул хамгаалалтын асуудалд анхаарал хандуулаасай гэж бодож байна.

Ж.Золжаргал гишүүнээ, хяналтын асуудлын тухайд бид төслийн менежментийн зөвлөх үйлчилгээний гэрээгээрээ инженер манай өмнөөс хяналтын зураг, төсөл, худалдан авалт, барилга угсралт, хяналт тавихыг төслийн менежментийн зөвлөхөд шилжүүлсэн. Гэхдээ цахилгаан станцыг Эрчим хүчний тухай хуулиар Эрчим хүчний хөгжлийн төв, барилгын ажилд Барилгын хөгжлийн төв хяналт тавьж ажилладаг. Манай компани ямар зорилготой ажиллаж байна гэвэл бид бүгд ээлж ээлжээр энэ ажилд хяналт тавьдаг л ийм ажил хийдэг. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Тодруулах уу? Ж.Золжаргал гишүүн тодруулъя.

**Ж.Золжаргал:** Нөгөө Петро Матадын, эсвэл өөр төрлийн юун дээр судалгаа хийсэн байгаа болов уу? Өөр төрлийн эх үүсвэрүүд, түүхий эд дээр?

**С.Ганбаатар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Петро Матадын тос болно. Бид тосны судалгааг нь авсан байгаа. Ерөнхийдөө нэг сав газрын, Тамсаг-ийн сав газрын тос учраас 19, 20,

Давст 31, Хөх нуур эд нарын тосны шинж чанар бол туйлын ойролцоо байгаа. Харин Өмнөговийн Галба 11-ийн талбайн тос бол Тамсагийн сав газрын тосноос эрс ялгаатай юм байна лээ. Бүх тосыг шинжилж үзээгүй. Анхны үйлдвэрийн ТЭЗҮ, Ашигт малтмал, газрын тосны газрын Энтертек (Intertek) гээд Их Британийн лабораторид хийсэн тосны шинжилгээнд суурилж хийгдсэн. Дараа нь 2 газар дахиж шинжилгээ хийлгэсэн.

**С.Ганбаатар:** П.Ганзориг гишүүн асуулт асууя.

**П.Ганзориг:** Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. 3 асуулт байна.

Нэгдүгээрт, Энэтхэгийн Засгийн газартай байгуулж байгаа хөнгөлөлттэй зээлийн үнийн дүн Энэтхэгийн компаниудаар гүйцэтгэх гэж байгаа энэ хэсэг дээр, гэрээнүүд дээр Монголын талаас туслан гүйцэтгэгч авч байгаа хэдий хэмжээний зүйлүүд байна? Гэрээ нь ам.доллороор уу, төгрөгөөр хийгдэж байна уу? Үнийн өсөлтийн асуудал яригдаж байгаа учраас энийг тодруулах ёстой. Тухайлбал, үйлдвэрийн барилга, байшин, ажилчдын орон сууц гээд барилга, бүтээн байгуулалтын ажлын гол түүхий эдүүд болох арматур, ган хийц, бетон энийгээ дотоодоос авч байгаа юм уу? Яаж аваад байгаа юм? Энэ үндсэн гэрээ дотроос үйлдвэрлэлийн барилга, байгууламжийн бас тодорхой хэсэг нэлээн том хэсэг болоод явж байгаа.

Хоёрдугаарт, газрын тосны үйлдвэрийн нийт хөрөнгө оруулалтын зардал хэд болох вэ? Энэтхэгийн Засгийн газартай байгуулсан гэрээний хүрээнд бол сүүлд 1 тэрбум 236 сая ам.доллар болоод, одоо 400 гаруй сая ам.доллар нэмэгдэх асуудал явж байгаа юм байна. Хөгжлийн банкнаас 250 тэрбум төгрөг аваад дэд бүтцийн асуудлууд руу оруулчихсан, дамжуулах хоолой дээр Норинк-тэй нүүрсний урьдчилсан төлбөрөөр 400 орчим тэрбум төгрөгийн ажил хийгдээд явж байгаа. Тэгэхээр нийт өртөг нь хэд болох вэ?

Дараагийнх нь, ингээд үйлдвэр маань бариад ашиглалтад орчихлоо, эцсийн бүтээгдэхүүн гарлаа. Тээвэр ложистик нь яаж явах юм бэ? Энэ зүгээр энгийн авто замаар явах боломжгүй, асар өндөр даацын ачаа тээврүүд явна. Тээвэр ложистик, тэрийг гүйцэтгэх машин, техник, тоног төхөөрөмж, тусгай зориулалтын энэ чинь галын маш өндөр эрсдэлтэй. Энэ зүйлүүдээ яаж төлөвлөж байгаа юм? Авто зам уу, төмөр зам уу? Тэр дээр өртөг яаж өөрчлөгдөх талаар тооцооллууд байгаа юу? Нефтийн бүтээгдэхүүн маань гараад дотооддоо үйлдвэрлээд ирэхээр хамгийн гол нь энийг барьсны ач холбогдол, бас үнэ байх ёстой. Эдийн засаг үр ашигтай байх ёстой. Үндэсний аюулгүй байдал чухал.

Тэгэхдээ эдийн засгийн хувьд үр ашигтай байхгүй бол нөгөө л төрийн өмчийн компаниудтай адилхан асар өндөр алдагдал үүсдэг, татаас үүсдэг ийм нөхцөл байдал руу үнээ тогтвортой байлгахын тулд орно. Тэр үнэ яг баталгаатай өсөлтгүй байхад нөлөөлдөг юм нь үндсэн түүхий эд, түүхий тос. Энийгээ энэ төлөвлөгөө дээр аудитын дүгнэлт дээр 1300 орчим төгрөг гээд тавьчихсан байна. Энэ урьдчилж тохирчихсон зүйл юм уу, цаашаа тогтвортой байлгах дээр өртөг гарч ирэхэд нөлөөлөх үндсэн бүтээгдэхүүн дээр яаж үнээ тогтвортой байлгах

юм. Мөн энэ гэрээнүүдэд маш богино хугацаанд нэмэлт, өөрчлөлтүүд оруулаад байсан байна. Энэ 992 сая ам.долларын 5, 6 гэрээ байгаа. ЕРС-1 гэхэд л бараг сар ч болоогүй нэмэлт, өөрчлөлт орж байсан байгаа юм. 2023 оны 8 сарын 23-нд, 11 сард, 8 сарын 30-нд хийснийг 9 сарын 28-нд буюу 28 хоноод энэ өөрчлөлт орчихсон. Энэ ямар шалтгаанаар заримд нь 3, 4 удаа богино богино хугацаанд өөрчлөлтүүд орсон юм гэсэн асуултууд. Баярлалаа.

**С.Ганбаатар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Би 1 дүгээр асуултыг сайн ойлгосонгүй. Монголын талын туслан гүйцэтгэгчид хэр зэрэг оролцож байна гэж байна тийм үү? Тэр технологийн бус барилга байгууламжийн ажил буюу ЕРС-1-д монголын талын 50-иад компани оролцсон. Энэ дээр монголчуудын хийж чадах ажил их байсан. Ер нь бас хэл ам ихтэй, хүндрэлтэй зүйлүүд байсан ч ажил дуусаж байна. Манай компани бол зөвхөн ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаад, ерөнхий гүйцэтгэгч нь өөрөө зөвлөх болоод, барилга угсралтын, ханган нийлүүлэлтийн ямар компани сонгохоо өөрсдөө шийддэг. Өөрсдөө тендер зарладаг юм уу, яадаг юм ингэж явдаг. Бид бол ЕРС гэрээнийхээ хүрээнд л эрх, үүргээ шаарддаг.

Энэ жилийн хувьд бид саяхан энэ тоог авсан. Энэ Мега инженеринг гэж компанийн өдөр тутмын ажилд 36 монгол компани оролцож байгаагаас ихэнх нь ханган нийлүүлэх юм шиг байна лээ. Бетон ган бол тэр мэдээж чигээрээ монголынх. Ган хийцүүд бүгд цаанаасаа нөгөө Эй Пи Ай стандарт гэдгийн дагуу хийгдэж байгаа.

Бүх төрлийн тоног төхөөрөмж, шугам хоолой бүгдийнх нь материал бүгд стандартын дагуу явагдаж байгаа. Энэтхэг, Хятад, Орос хаана ч хийгдэхээс үл хамаарч яг стандартын дагуу материалын орцыг үйлдвэрлэхээс нь өмнө очиж шалгадаг, хөндлөнгийн хяналтууд хүртэл хийгддэг. Энэ ганг Энэтхэг, Хятадаас авч байна.

Нийт хөрөнгө оруулалтын зардал ТЭЗҮ-ээр бодсон тоо 1 тэрбум 236 сая. Түүнээс хойш 6 жилийн дараа л үйлдвэрийн инженерчлэлд, дээрээс нь дэлхий дахинд нүүрлэсэн үнийн өсөлт, цар тахал, геополитикийн асуудал бид нарын инженерийн шатанд хийсэн маш олон өөрчлөлтүүд, дээрээс нь лиценз эзэмшигч, технологийн лиценз эзэмшигчдээс тавигдах шаардлага эдгээрээс болоод үйлдвэрийн бүтээн байгуулалтын нийт хөрөнгө оруулалтын зардал 34 хувиар өссөн байна.

Хөгжлийн банкнаас 2018 оны 4 сард манай компанийн дэд бүтэц бусад шаардагдах Монгол Улсын Засгийн газрын хариуцаж хийх ажилд зориулж 248 тэрбум төгрөгийн зээлийн шугам нээсэн байдаг. Түүнээс одоо хэрэглэсэн нь 176 тэрбум төгрөг. Түүний ихэнх нь буюу 138 нь дэд бүтэцэд зарцуулагдсан. Өөрөөр хэлбэл, төмөр замд 67 тэрбум, авто замд 35 тэрбум, цахилгаан дамжуулах агаарын шугамд 7 тэрбум, хотхонд одоогийн байдлаар 30-аад тэрбумыг зарцуулчихсан байгаа. Манай компанийн урсгал зардал, мөн зээлийн Хөгжлийн банкнаас санхүүжиж байгаад 2023 оны 3 дугаар сарын 01-нээс Эрдэнэс Монгол

ХХК-иас урсгал зардал, цалин хөлсөө тавьдаг болсон. Тээвэр ложистикийн хувьд энэ бол монголчуудын хаа хаанаа бодох л ёстой асуудал. Манай компани үйлдвэр барих тийм.../минут дуусав./

**С.Ганбаатар:** 4 дүгээр микрофоныг нээе.

**Д.Алтанцэцэг:** Бид үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг авто зам, төмөр замаар ч тээвэрлэхээр бүгдийг нь төлөвлөөд ажлууд хийгдэж байгаа. Гэхдээ юуны өмнө манай үйлдвэрийн урдуур явдаг төмөр замыг вагон системд 4 салаалуулаад, 4 янзын бүтээгдэхүүнийг зэрэг ачих, буулгах байгууламж төлөвлөгдсөн. Мөн авто цистерд ачих байгууламж байгаа. Улс орны хэмжээний том ложистикийн асуудал гэвэл Монголын төмөр зам ч юм уу, Улаанбаатар төмөр зам, эсхүл энэ бүтээгдэхүүнийг жижиглэн худалдаалдаг энэ том компаниуд ч гэсэн үүнийг эртнээс бодож, яриад эхэлсэн. Та нар шийдлээ олох хэрэгтэй, бид үйлдвэрээсээ худалдах юм уу, үгүй бол манай үйлдвэрийг Засгийн газар бэхжүүлж, бид тэр 300 вагон системийг авч байгаад Толгойт өртөөн дээр, эсхүл Тавантолгой дээр аваачиж өгөх үү гэдгийг манай төр засгийн өөрсдөө одооноос бодож, төлөвлөх ажил байгаа юм.

Үйлдвэрийн эдийн засгийн хувьд түрүүн хэлсэнчлэн газрын тосны үйлдвэрийн эдийн засгийн гол онцлог нь гэвэл нийт зардлын 80-85 хувь нь түүхий тос байдаг. Тэгэхээр түүхий тосоо бид ямар үнээр, хэнээс авч чадах вэ гэдэг үйлдвэрийн эдийн засагт хамгийн том жин дарж байгаа асуудал. Түүхий эдийн 10 хувь нь бусад зардал болдог. Бидний үйлдвэрийн оновчлол гэдэг нь катализаторуудыг жил бүр, сар тутам солихгүйгээр зарим нь 3 жилд, зарим нь 7 жилд сольдог катализатор авахаар төлөвлөж байгаа. Энэ бол үйлдвэрийн эдийн засагт өндөр ач холбогдолтой. Эрдэнэс Тавантолгой ХХК болон Хөгжлийн банк, Энэтхэгийн Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийг гэрээнд зааснаар, санхүүгийнхээ графикайн дагуу төлөөд, дээрээс нь 25 хувийн аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг төлсний дараа 300-аас.../минут дуусав./

**С.Ганбаатар:** П.Ганзориг гишүүн тодруулах уу? Их тодорхой хариулбал сайн шүү. Онолын юм яриад явчих юм.

**П.Ганзориг:** Би дахиад тодруулаад маш тодорхой асууя. Энэ төслийн нийт хөрөнгө оруулалт гэдэгт одоо байгаа Энэтхэгийн гэрээний дүн 1 тэрбум 600 боллоо гэж бодъё, тэгээд Хөгжлийн банкны 250, дамжуулах хоолой, бүүр цаашлаад явбал тээвэр ложистикийн асуудал чинь бизнес план байгаа гээд байгаа боловч түүн дээр яг энэ төмөр замаар тээвэрлэвэл ямар өртөгтэй болох юм, авто замаар тээвэрлэвэл ямар өртөгтэй болох юм, тэрийгээ тооцсон уу? Та нар болохоор үр ашигтай гаргаад хямдхан зарчихна гээд байгаа шүү дээ. Тэгэхээр энэ чинь бизнес план дээр тооцогдсон байх ёстой шүү дээ. Төрийн өмчийн олон компаниуд дараа нь маш өндөр алдагдал, татааст ордог учраас зайлшгүй асууж тодруулах ёстой.

Хоёрдугаарт, өртөгт гол нөлөөлөх түүхий эд бол газрын түүхий тос, 70, 80 орчим хувийн жин дарж байна гээд та өөрөө сая хэллээ. Энэ үнэ тогтвортой байх

юм уу? Нийлүүлэлтийн нөөц нь байгаа юу гээд түрүүн гишүүд асуулаа. Тэгвэл үнэ нь тогтвортой байх уу? Үйлдвэр барингуут дахиад үнийн өсөлт энд явагдчихдаг. Давуу байдлаа бий болгож, тэнд нөөц байгаа бол ганцхан тэндээсээ авна. Өөр хаанаас авах вэ? Тэнд үйлдвэр барьчаад дахин тээвэрлэж хойноос түүхий тос авах уу? Үүнийгээ яаж тооцож байгаа юм гэдэг асуудал байна.

Энэтхэгийн Засгийн газартай байгуулсан гэрээний хүрээнд дотоодын компаниуд болон бусад түүхий эд хэд, яг үнийн дүнгээр асуугаад байгаа юм. 1 тэрбум 236 сая ам.доллараас одоогоор 256 сая ам.доллар нь ашигличихсан гэсэн. Энэний чинь яг хэдэн хувь нь дотоодод үлдэж байгаа юм бэ? Үнийн өсөлтөд яаж нөлөөлж байна вэ? Гэрээ байгуулж, энэ ТЭЗҮ-г хийж байхад ам.доллар чинь 2017, 2018 оны үед 2400 байсан. Өнөөдөр 3600 болоод төгрөгөөрөө тооцвол дотоодоос авахад бол үнийн өсөлтийн нөлөөлөл гайгүй байх. Валютаар, ам.доллараар хийгдчихсэн ТЭЗҮ учраас энийг бас тодруулж асууя. Энэ 2 дээр тодорхой хариулт өгөөч.

**С.Ганбаатар:** Тооцоо судалгаа байна уу л гэж асууж байх шиг байна.

**Д.Алтанцэцэг:** Бас ерөнхий хариулах байх даа. ЕРС гэдэг гэрээнд бид нар ерөнхий гүйцэтгэгч туслан гүйцэтгэгчтэйгээ хэдэн төгрөг, ямар гэрээ хийснийг бид нар мэдэх боломж байхгүй. Тэгэхээр 256-г зарцуулснаас хэдийг нь монгол компаниудад зарцуулчихсан юм гэдгийг бид нарт мэдэх боломж алга байна.

Түүхий тосны тухайд энэ тосны үнэ үргэлж хэлбэлзэнэ. Дэлхийн зах зээлийн үнэ, түрүүний 1300 ярьж байгаа чинь дэлхийн зах зээлийн сүүлийн 5 жилийн дунджаар бодчихсон байгаа. Тэгэхээр түүхий тосны үнэ хэзээ ч тогтвортой байхгүй. Харин тухайн дэлхийн зах зээлийн үнээр худалдаж авъя гэсэн ийм гэрээтэй байгаа.

**С.Ганбаатар:** Хэлэх боломжгүй байвал бид хэнээс асууж болох вэ? Тэр дээр санаа оноо байгаа болов уу? Тэгвэл бид Энэтхэгүүдээс асуух уу? С.Жавхланбаатар дарга хариулах уу? П.Ганзориг гишүүн тодруулъя.

**П.Ганзориг:** Энэ ЕРС-1, 2, 3 гээд сарын хугацаатай 3-4 дахин өөрчлөгдсөн байна шүү дээ. Тэрийг хариулсангүй та. Яагаад сар ч болоогүй гэрээнд нэмэлт, өөрчлөлт ороод байдаг юм, шалтгаан нь юу вэ? Миний гол асуугаад байгаа юм бол энэ төслийн хөрөнгө оруулалтын нийт өртөг нийт дүнгээрээ хэд болоод байгаа юм бэ? Тэр чинь өөрөө эдийн засгийн хувьд ямар үр ашигтай гэдгийг чинь тодорхойлоход маш чухал байхгүй юу. Бүгд мэдэж байгаа.

Хоёрдугаарт, тээвэр ложистикийн асуудлаа шийдэхгүйгээр манайх үйлдвэрлэл барих зориулалттай гэж ойлгож байна. Тэгэхдээ энэ чинь томоороо бид Монгол Улсын стратегийн болоод эдийн засгийн ач холбогдолтой үйлдвэрлэл явуулж байна шүү дээ. Тийм болохоор үйлдвэрлэл бариад хойших асуудал нь бид нарт хамаагүй гэвэл энийг яам хариулах юм уу? Яам тооцож байгаа юм уу? Энэ газрын тосны үйлдвэр хамаагүй байж болно. Энэ дээр тодорхой хариулт байх ёстой. Тэгэхгүй бид нар ашиглалтад оруулаад үйлдвэрийн барилга

байгууламжаа дуусаад л болоо, тэрнээс цааш юугаараа тээвэрлэх юм, тэр нь өртөг үнэ нь ямар байх юм, тэрийг нь мэдэхгүй гээд байж болохгүй байх. Төмөр зам барих гээд байгаа гэж байна шүү дээ. Түрүүн.../минут дуусав./

**С.Ганбаатар:** П.Ганзориг гишүүн ард иргэд, сонгогчдын өмнөөс л асууж байгаа шүү. Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар хариулъя.

**С.Жавхланбаатар:** П.Ганзориг гишүүний асуултад хариулъя. Нийт өртгийн асуудал ярьж байна. 1 тэрбум 600 ам.доллар Энэтхэгээс авч байгаа зээл. Өглөөхөн Засгийн газар дээр яригдсан. Та энэ яг төслийн нийт өртөг мөн үү л гэж асуугаад байна. Тийм, тэгэхээр энэ дүндээ багтаана гэж Засгийн газраас чиглэл барьж байгаа. Тэгэхээр энэ дүнг хэтрүүлэхгүй, гэнэт КОВИД зэрэг дахиад гараад төслийн үйл ажиллагаа зогсохгүй л бол энэ дүн хэтрэхгүй. Мөнгөн урсгалын тооцоо бол ТЭЗҮ нь анх 2018 онд батлагдаад, сая 2023 онд шинэчлэгдсэн байгаа. Тэгэхээр ТЭЗҮ-ийнхээ дагуу л явна. Тэр үед 1 баррель түүхий тосны үнийг тооцож авахдаа.../минут дуусав./

**С.Ганбаатар:** 1 номерт хугацааг нь сунгая.

**С.Жавхланбаатар:** Өчигдрийн ханшаар 76 ам.доллар байгаа. Ерөнхийдөө дотоод өгөөжөөрөө 16 хувьтай гарч байгаа ийм л төсөл. Зээлээ эргэн төлөх хугацаа 16 хувьтай, эргэн төлөх хугацаа нь бол 7.5 жил. Зээлийн тодорхой нарийн нөхцөлүүдийг Сангийн яам хийдэг учраас Д.Алтанцэцэг дарга мэддэг байж магадгүй. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам бол анхнаас нь технологи болон ТЭЗҮ талаас нь Монгол Улсад хэрэгтэй төсөл гэдэг агуулгаар л бодлогыг барьж байгаа. Тэгээд ТӨК байгуулаад “Эрдэнэс Монгол” компанид харьяалуулсан. Бид дотоод менежментэд огт оролцдоггүй. ТУЗ-д ганцхан хүн байдаг Ч.Хишигдалай дарга байгаа. Бид ТЭЗҮ-ийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөрөө батлуулдаг. Өөрөөр хэлбэл дан төрийн албан хаагч нар биш, мэргэжлийн хүмүүс сууж байгаад баталдаг.

**С.Ганбаатар:** Г.Очирбат гишүүн асуулт асууя.

**Г.Очирбат:** Бүгдэд нь энэ өдрийн мэнд хүргэе. Энэ чинь 1.6 тэрбум ам.доллар гээд өнөөдрийн ханшаар 5.5 их наяд тийм ээ? 2018 оноос ТЭЗҮ батлагдчихсан байдаг. 2023 онд шинэчилсэн байдаг. Тэр анхны ТЭЗҮ хийсэн компани, зөвлөгөө өгч байсан компаниуд дээр ямар хариуцлага тооцож байгаа юм бэ?

Хоёрдугаарт, энэ 5.5 их наяд төгрөгөөр яг одоогийн энэ барих гэж байгаа боловсруулах үйлдвэрийг Зүүн Азийн зах зээл дээрээс энэ хэмжээний үйлдвэр хэдэн төгрөгөөр бүтдэг вэ? Үүнийг холбогдох яам, Д.Алтанцэцэг захирал судалсан зүйл байна уу?

Гуравдугаарт, одоо дахиад 431 сая ам.долларын зээл авах гээд байгаа юм байна. Энэ зээл чинь хуучин 2018 оны нөхцөлөөр явах юм уу, эсхүл өөр нөхцөлтэй явж байна уу? Та жилийн 1.75 хувьтай гэж байна. Энэ дээр бас хариулт авъя.

Ерөнхийдөө сүүлийн асуулт бол 2027 онд манай энэ газрын тосны боловсруулах үйлдвэр ашиглалтад ороод өгөөж нь ямар байх юм бэ? Та хэд ТЭЗҮ-ээр бас гаргасан л байх. ТЭЗҮ-ийнхээ тоог ядаж хэлчхээрэй. Бид тэдий хугацааны дараа одоо хийсэн энэ 5.5 их наядын хөрөнгө оруулалтыг нөхнө, цаашдаа ингэж ажиллана гэдэг ийм зарчмын юмнуудыг эхлээд сонсчихъя. Яагаад гэвэл ТӨК-уд дандаа алдагдалтай ажилладаг, төрөөс татаас авч байна гэсэн юм одоо Засгийн газар дээр ч, Улсын Их Хурал дээр ч ярьж байгаа. Та хэд маань ашигтай, улсад хэрэгтэй гээд яриад байдаг. Тэгэхээр яг хэдий хугацаанд ямар ашигтай ажиллах юм, хөрөнгө оруулалтаа хэзээ нөхөх юм гэдэг талаар хариулт авъя. Тэгээд тодруулья.

**С.Ганбаатар:** Төрийн нарийн бичгийн дарга хариулья. 1 дүгээр микрофон.

**С.Жавхланбаатар:** ТЭЗҮ-ийн талаар манай өмнө нь оролцож байсан хүмүүс нөхөөд хариулах байх. Тэгэхээр дотоод өгөөж маань 16.6-гаар тооцогдож байгаа. Өнөөдрийн байдлаар энэ төслийн буюу нийт зээлээ саяын 1.6 тэрбум ам.доллароо 7.5 жилд нөхнө гэдэг тооцоолтой байгаа. Нөгөө талдаа анх энэ төслийг эхлүүлэхдээ л бид яагаад ач холбогдолтой гэдэг дээр Монгол Улс маань газрын тосны бүтээгдэхүүн 100 хувь хараат байгаа. Импортоор одоо 10 сарын байдлаар 2 сая 200 мянган тонн дизель, АИ92, АИ95 авсан байна. Миний санаж байгаагаар бид жилдээ 2 тэрбум ам.долларыг дунджаар зарцуулж байгаа, ер нь Орос руу урсгаж байгаа гэсэн үг. Тэгэхээр 1.6 тэрбумаар дотооддоо үйлдвэр бариад, гадагш урсаж байгаа 2 тэрбум ам.долларынхоо 55 хувийг гадагшаа урсахгүй л гэсэн ийм төсөл. Нөгөө талдаа стратеги, аюулгүй байдал, нөөцөө бодвол мөнгөн дүнгээр маш их ач холбогдолтой төсөл гэж эхлүүлсэн байх гэж бодод байна. Манайхан нөхөөд хариулах уу.

**С.Ганбаатар:** Г.Очирбат гишүүн тодруулах юм уу. 2 номер.

**Б.Анхбаяр:** Г.Очирбат гишүүний асуултад хариулья. Та бүхэн сайн мэдэж байгаа. Анх энэ төслийг Монгол Улсын Засгийн газар зээлийн эх үүсвэрийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулаад, газрын тос боловсруулах үйлдвэрийг барья гэдэг шийдвэрийг гаргасан. Мэдээж энэ дээр Энэтхэг Улсаас бид Эксим банкны өөрийнх нь тавьдаг шаардлагынх нь дагуу зээл авсан. Эксим банкны систем нь яаж явдаг вэ гэвэл мэдээж гаднын улсуудад төсөл хэрэгжүүлэхдээ өөрийнхөө улсын дотоодын бүтээгдэхүүнийг гадагшаа нийлүүлэх бодлого баримталдаг банкны эх үүсвэрээр энэ төслийг анх эхлүүлсэн. Тэгэхлээр та бүхэн өртөг дээшээ өсөж байна, өөр ийм юунууд байж болох байсан уу гэдэг дээр хариулья.

Байж болох байсан уу гэвэл тийм. Гэхдээ мэдээж энэ бол Монгол Улс өөрсдөө шийдвэрээ гаргаад явсан төсөл. Тэгэхээр төслийг анх эхлэх үед ТЭЗҮ-ийг боловсруулсан компани дээр хариуцлага тооцох асуудал дээр бид сайн мэдэхгүй байна. Ямар ч байсан 2018 онд ТЭЗҮ-ийг боловсруулсан. КОВИД-ын цар тахлын үе мэдээж үүнээс нөлөөтэй, геополитикийн асуудлууд, дээрээс нь бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтүүдээс болоод ТЭЗҮ дээр мэдээж үнийн өсөлтүүд явагдсан. Манай Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөл үнэхээр ийм

үндэслэлүүд байсан байна гэдгийг зөвлөлөөрөө дүгнэлт гаргасан. Энэний дагуу л нэмэгдсэн асуудал явагдаж байгаа юм.

**С.Ганбаатар:** 4 дүгээр микрофоныг нээе. Нэмэлт хариулт өгье.

**Д.Алтанцэцэг:** Анх 1 тэрбум 236 гэдгийг бүхэлд нь авч үзэж нэг гэрээ гэдэг байсан. Гэтэл Энэтхэгийн Засгийн газар манайд зээлийн эргэн төлөлт дээр нааштай өөрчлөлтүүд оруулсан. Юу гэвэл эргэн төлөгдөх хугацааг нь хойшлуулах зорилготойгоор эхний тэрбум ам.долларыг 3 хэсэгт хуваасан. Өөрөөр хэлбэл анх энэ 1 тэрбум 236 чинь шууд 2023 оноос эхлээд төлөгдөх ёстой байсан. Тэгтэл ингэж багцалж 4 хэсэгт хувааснаараа зээлийн эргэн төлөлтийг 7 болгоод, тухайн багцад мөнгө гарч эхэлсэн өдрөөс хойш 7 жилээр эргэн төлөлтийг нь сунгасан. Тэгэхээр ЕРС-2, 3-ын анхны төлбөр 2023 оноос эхэлж хийгдсэн юм. Тэгэхээр 2030 оноос эхэлж тэр зарцуулсан санхүүжилтийн эргэн төлөлтийг хийнэ гэсэн үг. Ийм утгатайгаар 3, 4 хуваагаад Эксим банк манай Сангийн яам хоорондоо .../минут дуусав./

**С.Ганбаатар:** М.Бадамсүрэн гишүүн асуулт асууя.

**М.Бадамсүрэн:** 5.5 их наяд, дээр нь дамжуулах хоолойн зардал нэмэгдэнэ, дахиад Хөгжлийн банкнаас авсан 250 тэрбум төгрөг нэмэгдэхээр үндсэндээ 6 бараг 7 шахуу их наяд төгрөгөөр босгож байгаа. Хөрөнгө нь байвал үйлдвэрийг барина л даа. Гол нь миний санаа зовоод байгаа юм цаашид энийг яг ашигтай, тогтвортой авч явж чадах уу л гэдэг асуудал юм. Тэгэхээр энэ төслийг хариуцаж байгаа яам, Газрын тосны боловсруулах үйлдвэр энийг цогцоор нь харах ёстой гэж үзэж байна. 2026-2027 онд зээлээ төлж эхэлнэ. Одоо нэмэлт гэрээ байгуулагдаагүй байгаа 2027 оны 12 сараас нааш ашиглалтад орохгүй, 36 сарын хугацаа гэрээ байгуулснаас хойш гэдэг зүйлийг тайлбарлаж байгаа.

Нэгдүгээрт, эргэн төлөлтөд ямар хүндрэл учрах вэ?

Хоёрдугаарт, энэ төслийн өртөг дахиад нэмэгдэхгүй гэдэг баталгаа байна уу? Давагдашгүй хүчин зүйлээс гадна үйлдвэр ажиллахад асуудал гарна. Жинхэнэ асуудал чинь үйлдвэр яг ашиглалтад ороод ирэхээр л гарна. Энийг бид бодитой ойлгох ёстой. Энэ олон улсын нэр томьёо, гадаад, дотоод хэллэг, их л гоё яриад байна. Цаашдаа яг авч явна гэхэд үнэхээр хүнд шүү. Яагаад хүнд гэхээр сүүний үйлдвэр гэж бодоод энэ үйлдвэрийг харьцуулбал үнээ буюу газрын доор тос маань байж байна. Магадгүй энэ тосыг бага олборлож байна, орон нутгийн эсэргүүцэл, ТББ, иргэний нийгмийн байгууллагуудын эсэргүүцлээс болсон гэдэг зүйлийг их хариуцлагагүй тайлбар гэж ойлгож байна. Манай яам, мэргэжлийн байгууллагууд одоо болтол ийм дүгнэлттэй байгаа гэж үү? Бурууг бусдаас хайдгаа хэзээ болих вэ? Би гайхаж байна. Үндэсний олборлолтын компани байгуулна. Газрын тосны энэ үйлдвэр дээр явна гэвэл түүхий эдийн нөөцөө дангаараа бүрдүүлж чадах уу? Эсвэл хөрш хоёр орон, Энэтхэг Улстай цаашид үйлдвэрүүд авч явахад хамтарч ажиллах талаар ч гэдэг юм уу ийм зүйл байгаа юу?

**С.Ганбаатар:** Албан тушаалтнууд гишүүдэд хүндэтгэлтэй хандаарай. Бид аль болохоор хүндэтгэлтэй байгаа. Газрын тос бидний мөрөөдөл. Оюу Толгой бидний мөрөөдөл дээр тулгуурлаж том луйвар хийж, биднийг өрөнд оруулсан. Ард түмний өмнөөс бид асуух ёстой. Та нар хариулах үүрэгтэй. Ингээд Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар хариулъя.

**С.Жавхланбаатар:** Уучлаарай, М.Бадамсүрэн гишүүний асуултад хариулъя. Хүний нөөцийн тал дээр гишүүнтэй санал нэг байна. Энэ бол Монголчууд анх удаагаа газрын тостой, тосны үйлдвэртэй болж байгаа хэрэг. Тэгэхээр хүний нөөцөө бэлтгэх талаар асуусан уу? Эхнийх нь тийм байсан, дараа нь би нөөц рүү орох гэж байна л даа.

Хүний нөөцийн асуудал дээр яам, Ашигт малтмал, газрын тосны газар, төсөл хэрэгжүүлж байгаа компани бид нар төлөвлөгөө гаргаад явж байна. Хамгийн чухал, мэдээж эхний үед гадаадын тоног төхөөрөмж орж ирж байгаа, угсралтын үед зарим хүмүүсээ бэлдэнэ. Ашиглалтын явцад эхний 3-4 жил дадлагажуулах, сургах, тоног төхөөрөмжүүдээ хэрхэн ажиллуулах, эвдлэхгүй байх вэ гэдэг тал дээр төлөвлөгөө гаргаж ажиллуулах үүргийг ерөнхийдөө төсөл хэрэгжүүлэгч компанидаа өгөөд явж байгаа. Тийм учраас ашиглалтын өмнөх захиргаа буюу үйлдвэрийг цаашид авч явах багийг хэрхэн бэлдэх асуудал хөндөгдөж байгаа.

Нөөц тасрахгүй байх уу гэдэг асуудал яригдаж байна. Өнөөдөр Засгийн газрын хуралдаанд яг адилхан асуудал хөндөгдсөн. Петрочайна компанитай Монгол Улсын Засгийн газар татварын маргаантай байгаа. Энэ газрын тосны боловсруулах төсөл маань яалт ч үгүй хоолой тавьсан тэр сав газрын газрын тос үйлдвэрлэгч нартай холбоотой. Тэр дундаа Монгол Улсад анх удаа 1992 онд орж ирээд өнөөдрийг хүртэл үйл ажиллагаа явуулж байгаа Петрочайна компани буюу Хятадын 1 номер “Си Эн Пи Си” компанитай шууд холбоотой. Ийм учраас Ерөнхий сайд 2 долоо хоногийн өмнө Ц.Туваан сайдын хамт энэ компанийн удирдлагатай уулзаж, олборлолтоо нэмэгдүүлээч гэдэг хүсэлтийг тавьсан. Нөгөө талаас мэдээж манайтай татварын маргаантай асуудлаа эргэж тавьж байгаа. Тэгэхээр гишүүний асуусан найдвартай нөөцөөр хангах чиглэлээр Засгийн газар чиглэл бүрээр ажиллаж байгаа гэдгийг хэлье.

**С.Ганбаатар:** М.Бадамсүрэн гишүүн газрын нөөцтэй холбоотой асуудал дээр олон жил ажилласан. М.Бадамсүрэн гишүүн тодруулъя.

**М.Бадамсүрэн:** Би хангалттай хариулт авч чадсангүй. Асуулт асуухад өөр юм яриад байна. Нөөцөө бүрдүүлнэ гэдэг асуудал чинь үйлдвэр барихтайгаа зэрэгцээд явах ёстой байхгүй юу. Би бол шүүмжлэлтэй хандана. Яагаад гэвэл улс орны хувь заяаны асуудал, олон иргэдийн хүлээлтийн асуудал, Монгол Улсын Засгийн газрын зорьж, мөрөөдөж байгаа зүйл. Ажил хариуцаж байгаа хүмүүс ийм маягаар хандвал энэ үйлдвэр цаашид ажиллахад хүнд болно. Ерөөсөө ажлын гүн рүү орохгүй байна. Яаж олборлолтоо нэмэгдүүлэх юм, яаж байгаль орчинд ээлтэй, шинэ технологиор, өгөөжтэй байдлаар явах юм гэдэг дээр та нар анхаарлаа хандуулах ёстой. Тэгэхгүй зүгээр энд нэг асуултад хариулчхаад тэндээ очоод мартаад байвал энэ нөөц чинь хэзээ ч бүрдэхгүй. Би энийг баталгаатай

хэлье. Энэ тэмдэглэлд үлдэж байгаа. Би энийг 2027 оны 12 сарын 31-нд дахиад асууна.

**С.Ганбаатар:** Х.Жангабыл гишүүн асуулт асууя.

**Х.Жангабыл:** Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Газрын тосны үйлдвэрийг бид барьж байгуулна. Асуудалгүй гэж бодож байна. Монголчууд ч бас энийг барьж байгуулж чадна гэж бодож байна. Та бүхэнд амжилт хүсье. Энэ байгуулагдсанаар дотоодын химийн үйлдвэрүүд, пропан, бутан, сая Эл Пи Жи (LPG) дотооддоо хангачихна гээд бас ярьж байна. Бас зөв л асуудал. Гэхдээ М.Бадамсүрэн гишүүнтэй санал нэг байна. Түүхий эд, түүхий тосоо бид яаж хангах юм бэ? Одоо түүхий тос 400-гаас 500 мянган тонныг л үйлдвэрлэж байгаа юм байна. Дээрээс нь үйлдвэрийг явуулахын тулд 1 сая тонн түүхий тосны асуудал яригдана, тийм биз? Өнөөдөр гэрээ байгууллаа гэхэд чинь 32 сарын дараа ашиглалтад орох юм байна. 1 сая тонн нефтийг 32 сарын дотор та нар олборлож чадахгүй. Энэ бол баталгаатай. Хэчнээн 100 хувь, саяын газрын тос олборлох, дэмжиж ажиллаад, хөрөнгө оруулалт хийгээд амжихгүй. Тэгэхээр энэ эх үүсвэрийг өөр эх үүсвэрээс нөхөх хэрэгтэй. Нэгдүгээрт, ОХУ. Дахиад ОХУ-аас хараат. Хоёрдугаарт, Хятад Улс. Хятад, Орос Улсын нутаг дэвсгэрээр дамжуулж, Казахстанас авах. Энэ авсан газрын тос үйлдвэрийн технологид тохирох уу? Ийм төлөвлөгөө хийж байгаа ажлууд байна уу ер нь? Энэ их чухал шүү. Энэ асуудлыг шийдэхгүйгээр цаашаа явахгүй. Хийж байгаа дээрээ маш зөв, технологи нь зөв, хийх нь зөв. Гэхдээ энэ үйлдвэрийг тогтвортой цаашаа авч явах асуудал хүнд байгаа. Би энэ дээр санаа зовж байна. Энэ дээр тодорхой төлөвлөгөө байна уу гэдэг дээр бодлогын яамнаас хариулт авмаар байна.

**С.Ганбаатар:** 2 номерын микрофоныг нээж өгье.

**Б.Анхбаяр:** Х.Жангабыл гишүүний асуултад хариулъя. М.Бадамсүрэн гишүүнтэй ч гэсэн санал нэг байна. Мэдээж газрын тосны түүхий эдийн эх үүсвэр хамгийн чухал асуудал болж байгаа. Энэ түүхий эдийн асуудал дээр яам зүгээр суугаагүй. Өнгөрсөн 7, 8 жилийн хугацаанд газрын тосны бүтээгдэхүүн, газрын тосны түүхий эдийг тогтвортой байлгахын тулд зөндөө олон бүтээгдэхүүн хуваах гэрээнүүдийг олон улсад зарласан. Энэ хугацаанд мэдээж олон компаниуд орж ирээд эрэл хайгуул хийе гэвэл дандаа асуудлуудтай тулгардаг. Жишээлбэл, М.Бадамсүрэн гишүүнийг Засаг дарга байх үед үйл ажиллагаагаа явуулж чадаагүй 2, 3 нь ч компани байна. Одоо харин азаар Петро Матад гэдэг компани дөнгөж саяхан үйл ажиллагаагаа эхлүүлж байна. Дээр нь Хөх нуур гээд талбай дээр үйл ажиллагаа явуулдаг Монголын ТӨК шүүхийн маргаантай байгаад саяхан шүүхийн маргаан нь таслагдаж байна. Иймэрхүү асуудлуудаас болоод Монгол Улсад газрын тосны салбарт хөрөнгө оруулалт гэдэг хэцүү болчихсон. Хятадууд л орж ирвэл ирнэ, үгүй бол орж ирэхгүй ийм нөхцөл байдалтай байгаа.

Х.Жангабыл гишүүний асуусан асуудлыг бид ОХУ-тай ярьж үзсэн. Засгийн газар хоорондын хэлэлцээр, газрын тосны бүтээгдэхүүн болон газрын тосны хэлэлцээр хийхээр ОХУ-д бид санал тавьсан. ОХУ бол зөвхөн газрын тосны бүтээгдэхүүнийхээ хэлэлцээрийг эхний ээлжинд хийе. Газрын тосны

асуудлыг нарийн чухалчилж авч үзье. Энэ бол стратегийн ач холбогдол бүхий учраас нарийн судалгаа хийх шаардлагатай гэдэг хариу өгсөн. Баярлалаа.

**С.Ганбаатар:** Х.Жангабыл гишүүн тодруулъя. Энэ газрын тосны олборлолтыг 2017, 2018 оны үед сая нэг зууд хүргэсэн гээд албан бус мэдээ байгаа. Одоо 400-500 мянган тонн. Энэ яагаад буурав? Энэ дээр янз бүрийн бодлого, геополитик байгаад байна уу? Энэ дээр судалгаа, дүн шинжилгээ байна уу гэж асуугаад байна. 2 номерын микрофонд хариулъя.

**Б.Анхбаяр:** 2015 онд 1.1 сая тоннд хүрсэн нь Монгол Улсад хамгийн дээд рекорд. Үүнээс хойш доошоо буусан. Энд өмнө хэлсэн манай хууль, эрх зүйн орчин буюу газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хуулийн зөрчилтэй асуудлууд байгаа учраас Засгийн газар дээр шийдвэрлэхээр явж байгаа асуудлууд байна. Мөн орон нутгийн эсэргүүцэл байна, ажлыг нь хийлгэхгүй. Зүгээр эрэл хайгуул хийе гэдэг асуудал яригдаж байхад ажлыг нь хийлгэхгүй байх асуудлаас шалтгаалж Хятадын хөрөнгө оруулагч компани бараг залхаад эхэлчихсэн. Монголд үйл ажиллагаа явуулж байхаар Орос угаасаа барууны хөрөнгө оруулалт байхгүй болчихсон болохоор Орост очиж газрын тосны хайгуул хийе гэдэг дээр бараг тулчихсан нөхцөл байдалтай байгаа учраас энэ салбарыг цаашид тогтвортой явуулъя гэвэл .../минут дуусав./

**С.Ганбаатар:** 2 номер нэмж хариулъя.

**Б.Анхбаяр:** Хууль, эрх зүйн орчныг бид нэн яаралтай шинэчлэх шаардлагатай болсон. Орон нутгийн эсэргүүцэл, татварын асуудал. М.Бадамсүрэн гишүүний хэлж байсанчлан орон нутагт ямар ч өгөөжгүй байна гэдэг асуудлыг ярьсан. Орон нутагт өгөөжтэй болгох асуудал дээр ард иргэдийг энэ салбарыг ойлгодог түвшинд аваачих шаардлагууд гараад байна.

**С.Ганбаатар:** Х.Жангабыл гишүүн маш товчхон тодруулаарай.

**Х.Жангабыл:** Тэгэхээр бид нар яах юм бэ? Түүхий эд нь байхгүй байна, тэгэхээр энэ үйлдвэрийг бариад хэрэг байна уу?

**С.Ганбаатар:** Асуултад хариулъя 2 номер.

**Б.Анхбаяр:** Энэ асуудал дээр бидний зүгээс болох бүхий л шийдлүүдийг гаргаж ажиллаж байна. Өнгөрсөн Засгийн газрын хуралдаанд бид шинээр бүтээгдэхүүн хуваах 3 гэрээг байгуулахаар оруулж, дэмжигдсэн. Дахиад 3-ыг оруулна. Өмнө Ч.Хишигдалай дарга бас хэлсэн, газрын тосны илэрц бүхий талбайнууд байна. Энэ дээр үйл ажиллагааг нь тогтвортой явуулах арга хэмжээ авмаар байна. Петрочайна компанитай бид бүтээгдэхүүн хуваах гэрээ болон хуулийн маргаантай асуудлаа шийдчихвэл хөрөнгө оруулалтын асуудал нь бас тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Бид нар нэмэлт эрэл, хайгуулаа хийнэ. Ер нь 2027 он гэхэд Газрын тос боловсруулах үйлдвэрээ 100 хувь түүхий эдээр хангахын төлөө хичээж ажиллаж байгааг хэлье.

**С.Ганбаатар:** Асуултад хариулт авах шиг боллоо. Би 2 үг хэлчхээд, дараа нь Л.Мөнхбаясгалан гишүүн үг хэлэх юм байна.

Гишүүд асууж, тодруулж байгаа зүйл нь болохоор газрын тосны үйлдвэрлэлийг бид бүгдээрээ дэмждэг, Монгол орон даяараа дэмжиж байгаа. Энд маш их хөрөнгө зарцуулаад хугацаа нь дандаа хойшлоод, тодорхойгүй, үр дүн нь муу байвал Улсын Их Хурлын гишүүд бид асуугаагүй гэдэг асуудалд орно. Тодруулаагүй, хяналт тавиагүй. Энэ дээр албан тушаалтнууд маань битгий ундууцаж уурлаач дээ. Та нарын хувийн мөнгийг бид асуугаагүй. Энэ зээл байж болно. Бэлгийн морины шүдийг үзэхгүй гэдэг шиг та нар зээл дээр юун сүртэй юм гэдэг хандлага битгий гаргаарай. Үүнийг дараа нь Монголын ард түмэн хүүтэй төлдөг. Хэрвээ дампуурвал энэ өр болно. Сайн байвал та нарын л ажил. Тэгэхлээр Монголын ард түмэн энийг мэдэх ёстой. Тодруулж асуусан зүйлүүд бол үе үе үнэ өсгөөд оруулж ирээд байгаа. Гарцаагүй юм байгаа байх. Тэрийгээ тодорхой мэргэжлийн түвшинд, шинжээчийн дүгнэлттэйгээр тодруулж ард түмэнд тайлагнаач л гэж асуугаад байна. Үнэ өсөж байгаа дээр ихэвчлэн эрх зүйн орчин муу. Сая манай зарим дарга нар бүүр ард иргэдийн эсэргүүцлээс болоод үнэ өсөж байгаа юм шиг яриад, гацаа үүсээд байна гэдэг юм ярьж байна. Тэр үнэ өссөн дээр эрх зүйн орчин муу, гадаад зах зээл, экспертүүд муу, дэд бүтэц байхгүй гэдэг энэ асуудлууд ярьсан. Энийгээ урьдчилж ТЭЗҮ болон эдийн засгийн тодорхой үндэслэлүүд дээрээ тооцоолоогүй юм уу? Эрх зүйн орчин гэвэл сүүлдээ Улсын Их Хурлын гишүүд буруутай болж байна шүү дээ. Гишүүдээс болоод гацаад байгаа гэдэг асуудал үүсэх гэж байгаа байхгүй юу. Тэгэхлээр тоо баримт, үндэслэлээр энэ олон сая ам.доллар нэмж авах болж байна.

Өмнөх ЕРС 1, 2 гээд гээд яриад байгаа. Монгол хэл баялаг шүү дээ. Энийг бас хэдүүлээ монголчууддаа ойлгомжтой ярих ёстой, монголчууд ойлгох эрхтэй, та нар ойлгуулах үүрэгтэй. Бид ч гэсэн. Түрүүн асуусан үйлдвэрлэл рүүгээ өнөөдөр хэд орсон юм бэ гээд тодруулж асуугаад байсан, ерөөсөө хариулаагүй. Сүүлдээ болох бүх асуудлыг бидний зүгээс шийдвэрлэх гэж оролдож байгаа л гэж ярьж байна. Ямар ч баталгаа байхгүй шүү л гэдэг асуудал яриад байна. Би бол энэ төсөл, газрын тос бий болоосой гэж үнэхээр мөрөөддөг, дэмждэг. Гэхдээ энэ нь монголчууд үр дүнтэй байгаасай л гэдэг ийм байр суурьтай байгаа шүү.

Одоо Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

**Л.Мөнхбаясгалан:** Асуултаа эхэлж асуучаад дараа нь үгээ хэлье. ЕРС-3 буюу багц 3 дээр 35МВт-ын ДЦС 189.7 сая ам.долларт хийнэ гэсэн байна. Энэ 1МВт-ыг нь яг хэдээр тооцож барьж байгаа вэ? Энэ дээр бас нэг ойлгомжгүй юм байна. ЕРС-3 дээр чинь Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 219 дүгээр тогтоолоор үйлдвэрийн ДЦС угсралтын ажлын захиалагчийн техникийн хяналтын ажилд шаардлагатай санхүүжилтийг “Эрдэнэс Тавантолгой” ХК-иас шийдвэрлэхээр болсон гэж байна. Энэ ямар учиртай юм? Гаргасан уу? Тэгээд зээлийг жилд 13 сая ам.доллараар үйлдвэр ашиглалтад орсон цагаас төлж эхэлнэ. Энийг төлөөд, дээрээс нь та бүхний сая амлаж байгаа тэр гоё газрын тосоо нэрээд, үйлдвэрлээд ашгаа олох уу?

Дараагийн асуулт, гэрээ монгол хэл дээр байгаа юу? Миний асуултад ирүүлсэн гэрээ Англи хэл дээр ирсэн. Болсон.

**С.Ганбаатар:** Тодорхой хариулъя, 4 номерын микрофоныг нээж өгье.

**Д.Алтанцэцэг:** Л.Мөнхбаясгалан гишүүний асуултад хариулъя. Түрүүн ЕРС 1, 2, 3 дугаар багц ажил, 4 хараахан байгуулаагүй. Багц ажлуудын ер нь нийт үйлдвэрийн хөрөнгө оруулалтын зардал энэ тендерт ирүүлж байгаа үнээр тодорхойлогдож байгаа гэж хэлж байгаа. Тэгэхээр бид хэлэлцээ хийхдээ “1МВт ийм түлштэй цахилгаан станц ийм, тийм түлштэй бол ийм” гээд бид нарын ямар л хийж байгаа ажил, тэр тооцоолол л байгаа юм. Тэгээд энэ тендерийн үнийг бид бууруулсан. Тэрнээс өөрөөр чадахгүй цуцалсан, дахин зарласан. Эцэст нь ямар риск байсан бэ гэвэл огт тендер хүлээж авахгүй байх, төсөл зогсох ийм эрсдэлтэй. Тэгэхээр бид 389 сая ам.долларын санал аваад сууж байсныгаа, бас Энэтхэгийн төр засгийнхны тусламжтайгаар ийнхүү тендерийн бичиг баримтад өөрчлөлт оруулж, өрсөлдөөн бий болгосноороо 189 сая ам.долларын санал авсан.

2024 онд 219 дүгээр тогтоол гарсан. Тэр техникийн хяналтын зардал гэдэг нь төрийн өмчдөө чиг үүргийн байгууллагууд хяналт тавих ёстой гэсэн 2 хууль байдаг юм байна. Жишээ нь, 5МВт-аас дээш хүчин чадалтай цахилгааны эрчим хүчний эх үүсвэрийн барилга, байгууламжид Эрчим хүчний хөгжлийн төв хяналт тавина гээд заачихсан. Дээрээс нь Барилгын хөгжлийн төв бол дамжуулах хоолой, үйлдвэр хоёулаа Барилгын тухай хуулиараа онцгой төвөгшилтэй барилга, байгууламжийн төрөлд багтаж байна. Тэгэхээр онцгой төвөгшилтэй барилга, байгууламжийг заавал хөндлөнгийн зөвлөх барилгын эксперт хянахаар заасан. Тэгэхээр хэдийгээр гадаадын энэ байгууллагуудаар хяналт тавиулж байгаа ч гэсэн Барилгын тухай хуулийг дагаж мөрдөхийн тулд Барилгын хөгжлийн төв, Эрчим хүчний хөгжлийн төвөөр хяналт тавиулах шаардлага гарсан. Тиймээс 219 дүгээр тогтоолоор энэ хяналтын зардлыг шийдвэрлэсэн. Жил бүр 13 сая төгрөг, түрүүний манай Төрийн нарийн бичгийн даргын ярьж байгаа cashflow дээр ЕРС-2, 3, 4 дүгээр багц ажлыг эхний 7 жил зээлийн эргэн төлөлтөөс чөлөөлнө гэсэн байгаа. Тэгэхээр 2, 3-ыг 2030 оноос, 4 дүгээр багц ажлын төлбөр энэ оны сүүлчээс гарвал 2030 он, 2025 оноос эхэлбэл 2031 оноос эхэлж төлөгдөх юм. Одоогийн 13 сая ам.доллар төлөөд явж байгаа бол 2, 3, 4 дүгээр багц ажлаас бусад ТЭЗҮ, лиценз эзэмшигчдийн төлбөр, төслийн менежментийн зөвлөх ЕРС-1-ийн гэсэн эдгээр 4 нийлээд 203 сая ам.долларын эргэн төлөлтийг хийж байгаа нь хүүтэйгээ 13 сая ам.доллар болж байгаа.

**С.Ганбаатар:** Л.Мөнхбаясгалан гишүүн тодруулах уу? Шууд үг хэлэх үү? Л.Мөнхбаясгалан гишүүн үг хэлнэ, хугацааг дахиж шинээр өгье.

**Л.Мөнхбаясгалан:** Эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын гишүүний хувиар, мөн өөрийн сонгогдсон 7 дугаар тойргийн Алтанбулагийн газрын тос боловсруулах үйлдвэрийн явцын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад асуулт тавьж, хангалттай хариултыг авсан.

Сая миний асуусан асуулт бол багц 3 дээр 35МВт-ын ДЦС гэж байгаа юм. Энэ 189 сая, 189.7 сая ам.доллараар хийгдэнэ. Энд дэлхийн зах зээл дээр 1МВт нь 2 сая ам.доллар байгаа. Манай энэ үнийг харвал 5.4 сая ам.доллар болж байгаа. Үүгээр би юу хэлэх гэсэн бэ гэвэл угаасаа энэ газрын тос боловсруулах үйлдвэрийг барих тендер зарлаж байгаа, ямар сонгон шалгаруулалт хийж байгаа, хэдэн төгрөгийг хааш нь хуваарилж байгааг манай газрын тосны үйлдвэрийнхэн буюу манай яамдууд мэдэхгүй.

Яагаад гэвэл үүнийг Энэтхэгийн тал давуу эрхтэйгээр хийж байгаа. Жишээ нь, бид багц 1 дүгээр төсөл гээд л тендер зарлахад Энэтхэгийн Эксим банкнаас хураангуй жагсаалтыг ирүүлдэг. Энэ 7 компаниас сонго гэдэг. Тэр 7 компаниас сонгохоор 2 нь таардаг. 2 нь маш өндөр үнэтэй үнийн дүн хэлдэг. Д.Алтанцэцэг дарга таны зовлонг маш сайн ойлгож байна. Энэ 3, 4 багц дээр ирүүлсэн саналуудыг, бүүр гэрээнийх нь 1.2, 1.4 их наяд, 1 тэрбум ам.долларын санал хүртэл ирүүлсэн компани байгаа. Энийгээ буулгаач гээд л захидал бичдэг, тийм үү? Тэгээд холбогдох яамдыг ажиллуулдаг, Засгийн газраас үнийг нь буулгаад өгөөч л гэдэг, тэд үнийг нь буулгадаг. Тэрний дараа ажил эхэлдэг. Түүнийг нь ерөнхийдөө манай улс тооцоолж ч чадахгүй.

Бид нар багц 1-ийг тэдэн сая ам.доллараар хийнэ, багц 2-ыг тэдэн сая ам.доллараар хийнэ гэх ямар ч тооцоолол, боломж байхгүй. Яагаад гэвэл гэрээ буюу тэр мөнгийг захиран зарцуулах тендерийн хураангуй жагсаалт, ирж байгаа бүх юм Энэтхэг Улсын мэдэлд байгаа. Түрүүн С.Жавхланбаатар дарга ярьж байна, 1.6 саяар энэ нийт өртөг тооцогдоно гэж Засгийн газар үзсэн гээд. Үүнийг Монголын Засгийн газар мэдэхгүй. Жилийн дараа дахиад энэ Байнгын хороон дээр дахиад зээл авъя гэж орж ирэхийг Энэтхэг Улс мэднэ. Энэ нарийвчилсан ТЭЗҮ боловсруулсан буюу техник, эдийн засгийн зөвлөгөө өгч байгаа нь Инженерс Индиа Лимитед (Engineers India Limited) гээд ганцхан компани л байгаа юм. Энэ компанид манайхан саналаа тавина. Үнийг нь бууруулаад өгөөч гэхэд маш хурдтай шийдвэрлэнэ. Шийдвэрлэхдээ өм цөм буулгана. Жишээ нь, миний түрүүн хэлсэн эргэн төлөлт чинь анх жилийн 68 сая ам.доллараар төлөх байсан, манайхыг гуйнгуут л жилийн 13 сая ам.доллар болгож байгаа байхгүй юу. Энэ чинь ямар тооцоолол байгаа юм бэ? Энэ дотор асар их мөнгөний наашаа цаашаа луйвар явагдаж байна гэж би бодож байгаа. Энийг бид нар 20 жил төлнө. Сангийн сайд эртээд орж ирээд 10 жил төлнө гэж байна лээ. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд орж ирээд 25 жил төлнө гэж. Мэдэхгүй л байхгүй юу.

Монгол Улсын Их Хурлын гишүүнд гэрээг англи хэл дээр явуулж байгаа юм. Байгаа юм бол яагаад ерөнхий гэрээг монгол хэл дээрх явуулаагүй вэ? Манай газрын тосны үйлдвэрийнхэн болохоор ажил хариуцчихсан, энэ үйлдвэрээ л барихын төлөө зүтгээд байгаа. Бид нар ойлгож байна. Би ч гэсэн газрын тосны үйлдвэр барих шийдвэр гарахад хамгийн түрүүнд Д.Алтанцэцэг даргыг томилогдсоны дараа очиж уулзаж, энэ талаар нэвтрүүлэг хийж байсан. Монгол Улсад стратегийн маш чухал ач холбогдолтой.

Тэр хэн дарга бас л худлаа ярьж байгаа байхгүй юу. 2018 оноос хойш 14 компани дээр бид нар талбай зарласан шүү дээ. Хайгуулын компани ирээгүй

байхгүй юу. Та хийж байгаа гэж ярьж байгаа ч хийгдээгүй удсан шүү дээ. Бид нар Петрочайна Дачин Тамсаг-аас өнөөдөр бүтээгдэхүүн хуваа.../минут дуусав./

**С.Ганбаатар:** Нэмэлт хугацаа өгье.

**Л.Мөнхбаясгалан:** Зөрчилтэй компани. 320 тэрбумын акт тавьчихаад бид өнөөдөр авч чадахгүй, манай татварын маргаан таслах зөвлөл энийг нь хүчингүй болгочихдог. Тэгэхээр энэ яг Оюу Толгойн гэрээний араас явж байгаа 5-7 их наядад тооцогдож хийгдэх үйлдвэр шүү. Бидэнд өнөөдөр түүхий эд нь баталгаагүй байгаа. Тэгэхээр бид гэрээнд өөрчлөлт оруулах тал руу явуулмаар санагдаад байгаа юм. Тийм учраас Монгол Улсын эрхэм гишүүд та бүгдээс ажлын хэсэг байгуулж өгөх саналыг маань дэмжиж өгөөч гэж хүсэж байна. Энийг нухацтай шийдвэрлэж, маш олон экспертүүдийг оруулъя. Мөн Энэтхэгийн Элчин сайдын яам, Энэтхэгийн зөвлөх үйлчилгээ үзүүлж байгаа, нарийвчилсан ТЭЗҮ хийж байгаа компаниудыг бүгдийг нь татан оруулж асуудлыг нягтлах ёстой гэсэн саналтай байна. Миний энэ саналыг дэмжиж өгөөч гэж хүсье.

**С.Ганбаатар:** Л.Мөнхбаясгалан гишүүн асуулт асууж, үг хэллээ. Ажлын хэсэг байгуулна гэхээр л мөнгө мэдэж байгаа улсууд царай нь хувьскийгээд явчихвал битгий уурлаарай. Та нартаа тусалж, та нарыгаа дэмжиж, хайрлах гэж байгаа зүйл шүү. Энэ газрын тосны асуудал амжилттай сайн болоод, монголчууд өөрсдийн гэсэн нефттэй, газрын тостой болвол та нарын л ач буян. Энэ асуудал Оюу Толгой шиг, бүүр түүнээс долоон дор аюултай байдал руу ороод, олон их наядыг зарчихаад дараа нь Монголчууд хоосон гуяа ганзагалбал ард иргэдийг төлөөлөн цалин аваад энд сууж байгаа бид энэ асуудлыг зөв чигт нь оруулах, хянах үүргээ биелүүлээгүй гэдэг асуудал үүсдэг. Ингээд Л.Мөнхбаясгалан гишүүний гаргасан саналын дагуу ажлын хэсэг байгуулах болно. Ажлын хэсгийн бэлтгэл ажлыг ирэх долоо хоногт хангаж, мэдээллүүдийг авна. Дараагийн хурлаар энэ асуудлыг шийдэх болно. Ингээд газрын тосны асуудал хэлэлцэж дууслаа.

--oOo--

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТ,  
ТҮҮНИЙ ХАРИУГ ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

№63

Эмхэтгэсэн: К.Пүрэвсүрэн  
Хянасан: Ч.Онончимэг  
Эх бэлтгэсэн: Б.Төгсзаяа

Улсын Их Хурлын Тамгын газрын  
Хяналт шалгалтын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх, олшруулах цехэд бэлтгэв.